

*Зам, тээврийн хөгжлийн сайдын
2022 оны 04 сарын 12-ны А/94 тоот
тушаалын хавсралт*



ИНД-ийн нэр томъёоны тайлбар

(Нэр томъёо болон товчлол)

Иргэний Нисэхийн Ерөнхий Газар

ТАЙЛБАР

ИНД-ийн нэр томъёоны тайлбарын зорилго нь иргэний нисэхийн үйл ажиллагаанд ашигладаг нийтлэг нэр томъёо болон товчлолын талаар нэгдсэн ойлголтыг тогтооход оршино.

ИНД-ийн нэр томъёоны тайлбар нь хэрэглэгчид ИНД, ЗЦ, маягт болон Даргын гаргасан иргэний нисэхийн эрх зүйн бусад баримт бичигт ашигладаг нэр томъёо болон товчлолыг нэгдсэн нэг утгаар ойлгож, ашиглахад зориулагдсан бөгөөд дараах хэсгээс бүрдэнэ:

- нэр томъёо;
- товчлол.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-ийн нэр томъёоны тайлбарын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-ийн нэр томъёоны тайлбар, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих ИCAO-гийн 1992 оны 29-р чуулганы A29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын ИНД-ийг боловсруулсан.

Өөрчлөлтийн дугаар	Хүчинтэй болсон огноо
Анхны боловсруулалт	2007 оны 10 сарын 01
Өөрчлөлт 1	2010 оны 6 сарын 30
Өөрчлөлт 2 (Шинэчлэлт)	2022 оны 4 сарын 12

Тэмдэглэл: ИНД-ийн нэр томъёоны тайлбарыг монгол болон англи хэл дээр, 2021 оны 12 сарын 1-ны NZ Part 1 A.57-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

1.1.	Нэр томъёо.....	1-61
1.3.	Товчлол.....	62-70

1.1. Нэр томъёо

Хуулийн дагуу боловсруулсан ИНД-д хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:

Автоматаар задлах төхөөрөмж / Automatic activation device гэж шүхэр өөрөө задрахаар зохион бүтээсэн, автоматаар өндрийн-түвшин болон өндөр алдалтын хурд мэдрэгчийг;

Агаараас хөнгөн агаарын хөлөг / Lighter-than-air aircraft гэж өөрийн хөвөх чадвараар давамгайлсан агаарт хөвөн тогтдог агаарын хөлгийг;

Агаараас хүнд агаарын хөлөг / Heavier-than-air aircraft гэж аэродинамикийн хүчээр нислэгт өөрийн үндсэн өргөх хүчээ үүсгэдэг агаарын хөлгийг;

Агаараас бордоо цацах / Aerial topdressing гэж агаарын хөлгөөр дараах бодисыг цацах:

- (1) газар тариалангийн химийн хуурай бодис; эсхүл
- (2) ургамлын тэжээл, хөрсний бордоо, эсхүл ургамлын тархалтыг сайжруулахад зориулсан бусад хуурай бодис;

Агаараас мэргэчийн хор цацах / Aerial VTA гэж агаарын хөлгөөр хортон мэргэч, шавж устгах зорилгоор хортой болон хоргүй өгөөш цацах;

Агаараас шингэн цацах / Aerial spraying гэж агаарын хөлгөөр дараах бодисыг цацах:

- (1) газар тариалангийн химийн шингэн бодис; эсхүл
- (2) ургамлын тэжээл, хөрсний бордоо, эсхүл ургамлын тархалтыг сайжруулахад зориулсан бусад шингэн бодис;

Агаарт тогтох нислэг / Hover гэж гадаргуугаас дээш, агаарт тогтмол өндөр болон байршилд хөвөн тогтох нисдэг тэрэгний нислэгийг;

Агаарын зайн зөрчил / Airspace incident гэж дараах үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, эсхүл журмыг мөрдөхгүй байх эсхүл түүнд хайнга хандсантай холбоотой зөрчлийг:

- (1) агаарын хөлгүүд хоорондоо мөргөлдөхөөс зайлсхийх; эсхүл
- (2) агаарын хөлөг НХҮ авч байхдаа агаарын хөлгүүд хоорондоо болон бусад саадтай мөргөлдөхөөс зайлсхийх;

Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ / Aeronautical telecommunication service certificate гэж IFR нислэгт, эсхүл НХҮ-нд дэмжлэг үзүүлэх зорилгоор нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын техник үйлчилгээ үзүүлэх болон байгууламж ажиллуулах эрх олгодог, ИНД-171-ийн дагуу Даргын олгосон гэрчилгээг;

Агаарын тээврийн үйл ажиллагаа / Air transport operation гэж зорчигч, эсхүл барааг агаараар хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх, дараахаас бусад үйл ажиллагааг:

- (1) тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаа - ИНД-135 (GA AOC);
- (2) нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа - ИНД-133;
- (3) ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа - ИНД-137;
- (4) чөлөөт нисэхийн үйл ажиллагаа - ИНД-115;
- (5) танилцах нислэг - ИНД-149;

Агаарын тээвэрлэгч / Air operator гэж дараах гэрчилгээ эзэмшигчийг:

- (1) Хууль болон ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ; эсхүл
- (2) ИНД-129-ийн дагуу олгосон гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ;

Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр / Air operator security program гэж агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүн, газрын ажилтан, агаарын хөлөг болон байгууламжийг хууль бус үйлдлээс хамгаалах хөтөлбөрийг;

Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ / Air operator certificate гэж:

- (1) ИНД-119 болон ИНД-135-ын хувьд, шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг; эсхүл
- (2) ИНД-121 болон ИНД-125-ын хувьд, шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг;

Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч / Holder of an air operator certificate гэж ИНД-119-ийн дагуу, эзэмшигчид арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх эрх олгодог агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийг;

Агаарын хөлгийн зайлшгүй шаардлагатай төхөөрөмж / Justifiable aircraft equipment гэж агаарын хөлгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай төхөөрөмжийг. Үүнд максимум төлбөрт ачааллын багтаамжийг хангахын тулд агаарын хөлгийн хоосон жинг өөрчлөх зорилгоор байнгын, эсхүл бусад хэлбэрээр тусгайлан суурилуулсан төхөөрөмж, эсхүл тэнцвэржүүлэх ачаа багтахгүй;

Агаарын хөлгийн зөрчил / Aircraft incident гэж агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой өөрөөр ангилагдаагүй зөрчлийг;

Агаарын хөлгийн категори / Aircraft category and category of aircraft гэж аль нэг нисэх онгоц, бөмбөлөг, глайдер, ханг-глайдер, нисдэг тэрэг, эсхүл хэт хөнгөн агаарын хөлгийн ангиллыг;

Агаарын хөлгийн ослын байрлал тогтоох систем / Aircraft Emergency Location System гэж дараах системийг:

- (1) агаарын хөлөгт суурилуулсан;
- (2) ослын үед тухайн агаарын хөлгийн байрлалыг ЭХАТ үйлчилгээнд автоматаар мэдээлдэг;
- (3) ИНД-91.529(ab)-гийн дагуу Даргын зөвшөөрсөн;

Агаарын хөлгийн радио станц / Aircraft radio station гэж:

- (1) зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай антен, заах хэрэглэл, удирдлага, холболтын кабель болон цахилгаан системийн сүлжээг багтаасан, агаарын хөлөгт суурилуулсан радио холбооны төхөөрөмжийг;
- (2) ИНД-91-д авч явахыг шаардсан, зөөврийн бүх ослын радио холбооны төхөөрөмжийг;

Агаарын хөлгийн хөдөлгүүр / Aircraft engine гэж агаарын хөлгийн давших хөдөлгөөнд хэрэглэдэг, эсхүл хэрэглэхээр зориулсан, түүний ажиллагаанд шаардлагатай, сэнснээс бусад, turbo-superchargers, аппарат болон туслах тоноглолыг багтаасан хөдөлгүүрийг;

Агаарын хөлөг / Aircraft гэж агаар газрын гадаргуутай харилцан үйлчилснээс өөр, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр агаар мандалд хөөрөн нисэх чадвартай төхөөрөмжийг;

Агууламжийн мэдэгдэл / Statement of content гэж агаараар тээвэрлэх ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд агуулагдаж байгаа эд зүйлийн үнэн зөв тодорхойлолтыг;

Агуулах сав / Receptacle гэж бодис, эсхүл эд зүйлийг хүлээн авч, хадгалахад зориулсан хааж битүүмжлэх боломжтой савыг;

Ажиглагч нисгэгч / Pilot non-flying гэж тухайн нислэгийн үйл явцад хяналт тавих ба НХУ-тай радио холбоо барих, агаарын хөлгийн системийг хянах, бусад үйл ажиллагааг гүйцэтгэх багийн бусад гишүүдэд хяналт тавих үүрэгтэй нисгэгчийг; Мөн ажиглагч нисгэгч нь нислэгийн төлөвлөгөөг мөрдөх, түлшинд хяналт тавих, шалгах-хуудсыг унших болон газардах анги, далавчны флапс удирдах үүрэгтэй;

Ажиглалтын дэлгэц / Situation display гэж агаарын хөлгийн байршил, хөдөлгөөн болон бусад шаардлагатай мэдээллийг хариулдаг электрон дэлгэцийг;

Ажиллагаатай / Operable гэж төхөөрөмж болон хэрэглэлийн хувьд, бүрэн ажиллагаатай, тохируулагдсан ба холбогдох НТЧ-ын шаардлага хангасан байхыг;

Албадан саатуулах агаарын хөлөг / Aircraft to be intercepted гэж тухайн Улсын цэрэг, гааль, эсхүл цагдаагийн эрх бүхий байгууллагаас дараах зөрчилд сэжиглэгдэж байгаа агаарын хөлгийг:

- (1) НХУ-ний нэгжтэй хамтран ажиллах, эсхүл ажиглалтын хоёрдогч радар болон бусад төхөөрөмж ашиглан бүрэн танигдаж тогтоогдоогүй байдалтай тухайн Улсын агаарын зайд нэвтрэхийг завдсан, эсхүл нэвтэрсэн; эсхүл

- (2) тухайн Улсын нутаг дэвсгэрт иргэний нислэг үйлдэхийг хориглосон цэргийн үйл ажиллагааны, эсхүл хяналттай болон хориотой бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэхийг завдсан, эсхүл нэвтэрсэн; эсхүл
- (3) мэдэгдэж байгаа, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр агаарын зайд НХҮ-ний нислэгийн замын сүлжээнээс гарч, НХҮ-ний тогтоосон нислэгийн зам, эсхүл нислэгийн төлөвлөгөөнд заасан замаас хазайсан; эсхүл
- (4) тухайн Улсын хууль болон Конвенци зөрчин хууль бус бараа, эсхүл этгээдийг тээвэрлэж байгаа гэж сэжиглэгдэж байгаа; эсхүл
- (5) НХҮ-ний зөвшөөрөлгүй тухайн Улсын агаарын зайд нэвтэрч, тухайн агаарын зайг орхих, эсхүл буух шаардлагыг биелүүлээгүй; эсхүл
- (6) тухайн нисэн өнгөрөх зөвшөөрөлд зааснаас өөр цэгээр тухайн Улсын агаарын зайд нэвтэрсэн, эсхүл өөр замаар нислэг үйлдсэн; эсхүл
- (7) бусад агаарын хөлөгт аюул учруулж байгаа;

Алтиметр / Altimeter гэж ИНД-105-ын хувьд, шүхрээр буух үеийн өндрийн түвшнийг хэмжиж харуулах хэрэглэлийг;

Алтиметрийн тохируулга (QNH) / Altimeter setting (QNH) гэж газарт байхдаа тухайн өндөрлөгийг тодорхойлох зорилгоор алтиметрийн даралтын цонхны заалтаар тохируулдаг ба далайн дундаж түвшний 1013.25 hPa (760 мм м.у.б) даралт болон 1000м тутамд 6.5°C-ийн буурах хурдтай 15°C хэмд тодорхойлсон, ICAO-гийн Стандарт Атмосферийн дагуу далайн дундаж түвшин хүртэл багасгасан тухайн аэродромын түвшний даралтыг;

Ангилал-1 хэт хөнгөн агаарын хөлөг / Class 1 microlight aircraft гэж 1 хүн тээвэрлэхээр зохион бүтээж, тоноглосон хэт хөнгөн агаарын хөлгийг. Ангилал-1 нисдэг тэрэг нь Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөгт багтана;

Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөг / Class 2 microlight aircraft гэж 2 хүн тээвэрлэхээр зохион бүтээж, тоноглосон хэт хөнгөн агаарын хөлгийг;

Ангилал-3.1А шатамхай шингэн / Class 3.1A-Flammable liquid гэж бензин суурьтай бүтээгдэхүүнийг багтаасан дөл үүсэх хэм нь 23°C-аас доош, буцалж эхлэх максимум хэм нь 35°C-аас ихгүй шингэн;

Ангилал-3.1С шатамхай шингэн / Class 3.1C-Flammable liquid гэж керосин суурьтай бүтээгдэхүүнийг багтаасан дөл үүсгэх хэм нь 23°C, эсхүл түүнээс дээш, гэхдээ 60°C, эсхүл түүнээс доош шингэн;

Ангилал-3.1D шатамхай шингэн / Class 3.1D-Flammable liquid гэж дизель бүтээгдэхүүнийг багтаасан дөл үүсэх хэм нь 60°C -аас дээш, гэхдээ 93°C ба түүнээс доош шингэн;

Анхдагч хэлбэрийн навигацийн систем / Primary-means navigation system гэж өгөгдсөн навигацийн тодорхойлолт, эсхүл нислэгийн үе шатанд зөвшөөрөгдсөн, төлөвлөсөн нислэгийн зам, эсхүл журмаар аюулгүй нисэхэд ашигладаг навигацийн системийг;

Апрон / Apron гэж зорчигч суулгах, эсхүл буулгах, эсхүл ачаа, эсхүл шууданг ачих, эсхүл буулгах, агаарын хөлгийг түлшээр сумлах, зогсоолд байрлуулах, эсхүл техник үйлчилгээ хийх зорилгоор газрын аэродром дээр тогтоосон талбайг;

Апрон зохицуулалтын үйлчилгээ / Apron management service гэж апрон дээрх агаарын хөлөг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон үйл ажиллагааг зохицуулах үйлчилгээг;

Аргамжаат бөмбөлөг / Moored balloon гэж максимум диаметр нь 1.5 м-ээс их, эсхүл 3 м³-ээс дээш хийн багтаамжтай, газрын гадаргуугаас, эсхүл газрын гадаргуу дээрх байгууламжаас аргамжсан нисгэгчгүй бөмбөлгийг;

Арилжааны нислэгийн үйл ажиллагаа / Air operation гэж зорчигч, эсхүл барааг агаараар хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх дараах үйл ажиллагааг:

- (1) ИНД-121-ийн хувьд, шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын багтаамж нь 3410 кг-аас их нисэх онгоц ашиглан гүйцэтгэдэг агаарын тээврийн үйл ажиллагаа, эсхүл тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагааг; эсхүл
- (2) ИНД-125-ын хувьд дараах нисэх онгоц ашиглан гүйцэтгэдэг агаарын тээврийн үйл ажиллагаа, эсхүл тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагааг:
 - (i) шаардлагатай нисэх багийн гишүүний суудлаас гадна, 10 - 30 зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын багтаамж нь 3410 кг, эсхүл түүнээс бага, MCTOW нь 5700 кг-аас дээш жинтэй; эсхүл
 - (ii) ганц-хөдөлгүүртэй нисэх онгоцоор гүйцэтгэх SEIFR-зорчигч тээврийн үйл ажиллагаа; эсхүл
- (3) ИНД-135-ын хувьд, дараах агаарын хөлөг ашиглан гүйцэтгэдэг SEIFR-зорчигч тээврийн үйл ажиллагаанаас бусад агаарын тээврийн үйл ажиллагаа, эсхүл тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагааг:
 - (i) шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 9, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай, MCTOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоц; эсхүл
 - (ii) нисдэг тэрэг; эсхүл
- (4) ИНД-115-ын хувьд, чөлөөт нисэхийн үйл ажиллагааг;

АХОШШБ / AAIB гэж Annex 13-ын дагуу Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах зорилгоор Хуулийн дагуу байгуулсан байгууллагыг;

Ачаа / Cargo гэж шуудан, нөөц сэлбэг болон тээшнээс бусад, агаарын хөлөгт тээвэрлэж байгаа өмч хөрөнгийг;

Ачааны агаарын хөлөг / Cargo aircraft гэж зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлгөөс бусад, бараа, эсхүл өмч хөрөнгө тээвэрлэж байгаа агаарын хөлгийг;

Ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил / Cargo security incident гэж зохицуулалттай агаарын ачааны байгууллага, эсхүл агаарын тээвэрлэгчийн олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээнд ашиглах агаарын хөлөгт агаараар тээвэрлэхээр хүлээн авсан, эсхүл тээвэрлэсэн ачаа, эсхүл шуудантай холбоотой дараах зөрчлийг:

- (1) ачаа, эсхүл шууданд гэмтэл учруулсан, эсхүл гэмтэл учруулсан байж болзошгүй нь хууль бус үйлдэл байсан, эсхүл завдсан болохыг нотлох баримт байгаа; эсхүл
- (2) ачаа, эсхүл шууданд хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодис илэрсэн;

Ачилтын нэгж төхөөрөмж / Unit load device гэж дараахаас бусад, багц ачааны болон агаарын хөлгийн чингэлэг, агаарын хөлгийн тортой ачааны тавцан, эсхүл агаарын хөлгийн хэлбэржүүлсэн тортой ачааны тавцанг:

- (1) гадуур боодол; эсхүл
- (2) цацраг идэвхт материалын багц ачааны чингэлэг;

Ашиглалтад шилжүүлэх / Release to service (Maintenance release) гэж тухайн техник үйлчилгээний ажлыг холбогдох НТЧ-ын шаардлагын дагуу амжилттай хийж гүйцэтгэсэн болохыг бататгах гэрчилгээжүүлэлтийн баримт бичгийг;

Ашиглалтын хязгаарлалттай / Lifed гэж нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсэгт НТЧ-ын байнгын хадгалалтын зааварчилгаагаар тогтоосон дараах хугацааг:

- (1) тухайн нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсгийн ашиглалтын хязгаарт цаг; эсхүл
- (2) тухайн нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсэгт санал болгосон, эсхүл заавал хийх их засварын цаг;

Ашиглалтын цаг / Time in service гэж техник үйлчилгээний цаг, агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэр болон бусад ижил зорилгоор хийх бүртгэлийн хувьд, тухайн агаарын хөлөг гадаргуугаас хөөрөн, буулт үйлдэж дахин газардах хүртэл үргэлжлэх хугацааг;

Аэробатик нислэг / Aerobatic flight гэж:

- (1) агаарын хөлөг нь нуруугаараа эргэсэн нислэгт байх, эсхүл эгц нислэгээс эргэж нуруугаараа нисэх, эсхүл буцаж эргэн эгц нисэхээр зориуд гүйцэтгэж байгаа маневрыг; эсхүл
- (2) хурдны нуралттай хажуу эргэлт (stall turn), босоо-stall (hammerhead stall), эсхүл whip-хурдны нуралт (whip stall), эсхүл эдгээрийн хослолд шилжих эргэлт, гогцоо, штопор, эгц дээш нисэх маневрыг;

Аэродром / Aerodrome гэж:

- (1) агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн ашиглахад зориулсан, эсхүл зохион бүтээсэн, газар, эсхүл усан дээр тогтоосон талбай;
- (2) тухайн аэродром, эсхүл түүний захиргааны удирдлагатай холбоотой ашиглаж байгаа талбай дээр, эсхүл түүний дэргэд байрлах барилга, байгууламж болон төхөөрөмжийг багтаана;

Аэродромын гэрчилгээ / Aerodrome operator certificate гэж дараах нисэх онгоцонд үйлчлэх аэродромд ИНД-139-ийн дагуу Даргын олгосон гэрчилгээг:

- (1) олон улсын тогтмол агаарын тээврийн нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг; эсхүл
- (2) 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай, зорчигч тээвэрлэх тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаг;

Аэродромын давтамжид хариулах нэгж / Aerodrome Frequency Response Unit гэж агаарын хөлгөөс модуляцлагдсан VHF дамжуулалтыг тохирох давтамж дээр хүлээн авч, тухайн нисгэгчийн радио давтамжийн сонголтыг бататгах зорилгоор дуугаар, эсхүл дууны өнгөөр, эсхүл аль алиныг нь хослуулан хариуг автоматаар дамжуулдаг газрын VHF радиог;

Аэродромын зөрчил / Aerodrome incident гэж агаарын хөлгийн үйл ажиллагаанд нөлөөлөх дараах зөрчлийг:

- (1) аэродромын үйл ажиллагааны бүс дээрх, эсхүл аэродромын саадыг хязгаарлах гадаргуугаас дээш гарсан саад; эсхүл
- (2) гэмтэлтэй ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ; эсхүл
- (3) маневрын талбайн гэмтэлтэй гадаргуу; эсхүл
- (4) аэродромын гэмтэлтэй бусад байгууламж;

Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ / Aerodrome flight information service гэж аэродромын ойролцоо нислэгийг аюулгүй, үр ашигтай гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл болон зөвлөгөө өгөх зорилгоор үзүүлдэг үйлчилгээг;

Аэродромын нислэгийн хөдөлгөөн / Aerodrome traffic гэж:

- (1) аэродромын маневрын талбай дээрх бүх хөдөлгөөнийг;
- (2) аэродромын ойролцоо нисэж байгаа бүх агаарын хөлгийг;

Аэродромын нислэгийн хөдөлгөөний хайрцаг / Aerodrome traffic circuit гэж аэродромын ойролцоо үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн нислэгийн замыг;

Аэродромын удирдлагын үйлчилгээ / Aerodrome control service гэж аэродромын хөдөлгөөнийг удирдлагаар хангадаг НХУ-ын үйлчилгээг;

Аэродромын удирдлагын цамхаг / Aerodrome control tower гэж аэродромын хөдөлгөөнд НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгжийг;

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч / Aerodrome operator гэж:

- (1) аэродромын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд; эсхүл
- (2) хэрэв энэ зүйлийн (1)-д заасан этгээд тодорхойлогдоогүй бол тухайн аэродромын удирдлагыг хариуцсан этгээд; эсхүл
- (3) хэрэв энэ зүйлийн (1), эсхүл (2)-т заасан этгээд тодорхойлогдоогүй бол тухайн аэродромын газрыг эзэмшиж байгаа этгээд; эсхүл
- (4) хэрэв энэ зүйлийн (1), (2), эсхүл (3)-д заасан этгээд нь тодорхойлогдоогүй бол тухайн аэродромын газрын бүртгэгдсэн өмчлөгчийг;

Аэродромын үйл ажиллагааны бүс / Aerodrome operational area гэж:

- (1) аэродром дээрх хөдөлгөөний бүс, түүний холбогдох зурвас, аюулгүй байдлын талбай;
- (2) агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилгоор аэродром дээр байгуулсан газрын төхөөрөмж, эсхүл байгууламжийг;

Аюулгүй байдлын давхар үзлэг шалгалт / Duplicate safety inspection гэж агаарын хөлгийн удирдлагын, эсхүл бүрдэл хэсгийн удирдлагын аль ч системийн анхан шатны угсралт болон задаргаа, эсхүл тохируулга хийсний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх эрх бүхий 2 ажилтан гүйцэтгэх шаардлагатай үзлэг шалгалтыг;

Аюулгүйн үзлэг / Screening гэж хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодисыг илрүүлэх болон/эсхүл танихад чиглэсэн техникийн, эсхүл бусад арга хэлбэрийг ашиглан хийх ажиллагааг;

Аюулгүйн үзлэгийн цэг / Screening point гэж аэродромын үйл ажиллагаа эрхлэгч ИНД-139.203(d)(4)-ийн дагуу, зорчигчийн аюулгүйн үзлэгт зориулан гаргасан талбайг;

Аюулгүйн хамгаалалттай аэродром / Security designated aerodrome гэж хууль болон ИНД-140-ийн дагуу, тухайн цаг хугацаанд аюулгүйн хамгаалалттай байхаар тогтоосон аэродромыг;

Аюулгүйн хамгаалалттай бүс / Security area гэж Дарга, ИНД-ийн дагуу хамгаалалттай байхаар заасан талбайг;

Аюулгүйн хамгаалалттай навигацгийн байгууламж / Security designated navigation installation гэж Дарга аюулгүйн хамгаалалттай байхаар тогтоосон навигацгийн байгууламжийг;

Аюулгүйн хамгаалалтын зөрчил / Security incident гэж хууль бус үйлдэлтэй холбоотой зөрчлийг;

Аюулгүйн хамгаалалтын мэдэгдэл / Declaration of security гэж ИНД-109-ийн шаардлагын дагуу ачаа, эсхүл шуудангаар илгээх барааны талаар үйлдсэн мэдүүлгийг;

Аюулгүйн хамгаалалтын удирдах ажилтан / Security management гэж 140.61(а)(5)-д заасан байрлал бүрийг хариуцсан нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтныг, үүнд тухайн ажилтны орлогч болон тухайн ажилтан хариуцлагаа шилжүүлсэн бусад ажилтан багтана;

Аюулгүйн хамгаалалтын хяналт / Security control гэж хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодисыг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлж чадах арга хэмжээг;

Аюултай бараа / Dangerous goods гэж бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал, өмч хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болох дараах эд зүйл, эсхүл бодисыг:

- (1) ICAO-гийн Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх Техникийн Зааварчилгаанд заагдсан, эсхүл ангилагдсан; эсхүл
- (2) ICAO-гийн Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх Техникийн Зааварчилгааны дагуу аюултай бараа гэж ангилагдсан эд зүйл, эсхүл бодисын хэв шинжийг агуулсан;

Аюултай барааны ангилал (Ангилал 1 - 9) / Classification of dangerous goods (Classes 1 to 9) гэж Техникийн Зааварчилгааны Бүлэг 2-т заасантай ижил утгатай;

Аюултай барааны зөрчил / Dangerous goods incident гэж үйл ажиллагаа эрхлэгч хүлээн авсны дараа аюултай барааг агаараар тээвэрлэхтэй холбоотой дараах зөрчлийг:

- (1) сав баглааны бүрэн бүтэн байдал алдагдсаны улмаас аливаа этгээдийг гэмтээх, өмч хөрөнгөд хохирол учруулах, гал гарах, хагарах, шингэн асгарах, шүүрэх, эсхүл төөнөх зэрэгт хүргэсэн; эсхүл
- (2) аюултай барааг буруу мэдүүлсэн, савласан, шошгожуулсан, тэмдэглэсэн, эсхүл баримт бүрдүүлснээс үүдэлтэй;

Аюулын дохио мэдээллийн үйлчилгээ / Alerting service гэж ЭХАТ тусламж шаардлагатай агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх ба шаардлагатай бол тухайн байгууллагад дэмжлэг үзүүлэх НХҮ-г;

Аяллын нислэгийн түвшин / Cruising level гэж нислэгийн дийлэнх хэсэгт хадгалдаг нислэгийн түвшнийг;

Аяллын орон нисгэгч / Cruise relief pilot гэж аяллын нислэгийн үед хөлгийн дарга, эсхүл хамтран нисгэгчид түр амрах боломж олгодог, нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр томилогдсон нисэх багийн гишүүнийг;

Аяллын түлш / Trip fuel гэж хөөрөлтийн гүйлт үйлдэж эхлэхээс, буултын гүйлтийг дуусгаж, ХБЗ-аас гарах хүртэл тухайн төлөвлөсөн нислэгт шаардлагатай түлшийг;

ADS-B OUT / ADS-B OUT гэж ADS-B хүлээн авагчид тохиромжтой форматаар бүхээгийн системээс авдаг векторын байдал (байршил тогтоох болон хурд) болон бусад мэдээллийг тодорхой давтамжтай мэдээлдэг агаарын хөлгийн ажиллагааг;

ADS-B систем / ADS-B system гэж GNSS байршлын эх үүвэр болон Mode S Extended Squitter-т тохирох 1090 МГц-ийн ADS-B OUT транспондер, эсхүл ИНД-91.258(а)(6)-гийн мэдэгдэлд заасан Даргын тогтоосон бусад тохиромжтой транспондерыг;

AIP-ын өөрчлөлт / AIP Amendment гэж AIP-ын мэдээлэлд орсон байнгын шинж чанартай өөрчлөлтийг;

AIP-ын нэмэлт / AIP Supplement гэж AIP-ын мэдээлэлд орсон, тусгай хуудсаар хэвлэн нийтэлсэн түр өөрчлөлтийг;

AIP-ын үйлчилгээ / AIP service гэж Монгол Улсын AIP, AIP-ын өөрчлөлт, AIP-ын нэмэлт болон AIC хэвлэх үйлчилгээг;

AIRAC (нисэхийн мэдээллийн зохицуулалт ба хяналт) / AIRAC гэж нийтлэг хүчинтэй хугацаанд суурилсан, үйл ажиллагааны практикт зарчмын өөрчлөлт оруулахыг шаарддаг нөхцөл байдлын талаар урьдчилсан мэдээллээр хангах зорилготой тогтолцоог илэрхийлдэг товчлолыг;

Annex / ICAO Annex гэж Конвенцийн Хавсралтыг;

AWIB үйлчилгээ / AWIB Service гэж тусгайлан нисэхийн үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор аэродромын болон цаг агаарын мэдээгээр хангадаг автомат радио нэвтрүүлгийг, AWIB үйлчилгээ нь НХУ биш;

Багийн гишүүн / Crew member гэж агаарын хөлөгт байгаа дараах этгээдийг:

- (1) үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон:
 - (i) тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэх нисэх багийн гишүүн, эсхүл бүхээгийн ажилтан; эсхүл
 - (ii) нислэгийн хугацаанд тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэх этгээд; эсхүл
- (2) зөвхөн дараах зорилгоор тээвэрлэж байгаа:
 - (i) тухайн агаарын хөлгийг удирдан нисэх зааварчилгаа авч, эсхүл өгч байгаа; эсхүл
 - (ii) нисэх-инженерийн, эсхүл бүхээгийн ажилтны зааварчилгаа авч байгаа; эсхүл
- (3) нислэгийн хугацаанд тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой дадлага хийхээр Даргын зөвшөөрсөн; эсхүл
- (4) шалгагч-нисгэгч;

Багийн нэмэлт гишүүн / Supplementary crew member гэж тухайн нисэх онгоцны гэрчилгээжүүлэлтэд шаардсан минимум багийн гишүүдээс илүү бүрдүүлсэн, нисэх онгоцонд байгаа тухайн багийн гишүүнийг;

Баглаа боодлын иж бүрдэл / Packaging гэж Annex 18-ын савлагаанд тавих шаардлагын хэрэгжилтийг бататгах болон агуулах сав өөрийн хадгалалтын үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай агуулах сав болон бусад бүрдэл хэсгийг;

Баглаа боодол / Package гэж тээвэрлэлтэд зориулж бэлдсэн баглаа боодлын иж бүрдэл болон түүний агууламжаас бүрдсэн, савлах үйл ажиллагааны эцсийн бүтээгдэхүүнийг;

Багц ачаа / Freight гэж нэг байрлалаас нөгөө байрлалд буулгах зорилгоор агаарын хөлгөөр тээвэрлэж байгаа өмч хөрөнгийг;

Багш-нисгэгч / Flight instructor гэж ИНД-61-ийн дагуу олгосон багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг, эсхүл нислэгийн зааварчилгаа өгөхийг Дарга зөвшөөрсөн этгээдийг;

Байгууламж / Facility гэж ИНД-174-ийн хувьд, дараах үйл ажиллагааны систем, эсхүл төхөөрөмжийг багтаасан, цаг уурын албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг, эсхүл цаг уурын мэдээгээр хангадаг, автомат ажиллагаатай аливаа систем, эсхүл төхөөрөмжийг:

- (1) цахим өгөгдлийн дүн шинжилгээ болон урьдчилсан мэдээ боловсруулах;
- (2) цаг агаарыг зайнаас тандан судлах;
- (3) цаг уурын мэдээг цахимаар, эсхүл автоматаар дамжуулах;

Байгууламжийн доголдлын зөрчил / Facility malfunction incident гэж нисэхийн байгууламж болон түүний төхөөрөмжийн буруу ажиллагаатай холбоотой зөрчлийг;

Байнгын үзлэг / Routine inspection гэж хэсэгчилсэн үзлэгийн хувьд, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, систем болон төхөөрөмжид аль болохоор задаргаагүй хийдэг нүдэн үзлэгийг;

Бараа / Goods гэж амьтан болон шууданг багтаасан, бүх төрлийн хөдлөх өмч хөрөнгийг;

Баримт бичиг / Document гэж дараах хэлбэрийн баримт бичгийг:

- (1) аливаа материал дээр бичигдсэн зүйл;
- (2) аливаа бичлэгийн төхөөрөмж, компьютер, эсхүл бусад төхөөрөмжид бичигдсэн, эсхүл хадгалагдсан мэдээлэл болон бичигдсэн, эсхүл хадгалагдсан мэдээллээс дараа нь гаргаж авсан материал;
- (3) аливаа ном, газрын зураг, схем зураг, төлөвлөгөө, диаграмм, эсхүл зураг;
- (4) аливаа фото зураг, хальс, негатив, хуурцаг, эсхүл 1, эсхүл түүнээс олон дүрсийг агуулсан бөгөөд (бусад төхөөрөмжийн тусламжтай, эсхүл тусламжгүйгээр) сэргээх чадвартай бусад хэрэгслийг;

Баталгаажуулсан зөвшөөрөл / Validation permit гэж тухайн эзэмшигчид үнэмлэхний эрхээ хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг, ИНД-61.7 болон 61.9-ийн дагуу гадаадын нисгэгчид олгосон зөвшөөрлийг;

Бие даасан хэлбэрийн навигацийн систем / Sole-means navigation system гэж тухайн үйл ажиллагаа, эсхүл нислэгийн үе шатанд заалтын нарийвчлал, тохирол, бэлэн байдал болон тасралтгүй ажиллагаа зэрэг навигацийн системийн бүх 4 үзүүлэлтийн шаардлагыг хангах боломжийг тухайн агаарын хөлөгт олгох үүрэгтэй, тухайн өгөгдсөн үйл ажиллагаа, эсхүл нислэгийн үе шатанд зөвшөөрөгдсөн навигацийн системийг;

Босго / Threshold гэж ХБЗ-ны гадаргуу, 1:20-ын саадаас чөлөөтэй ойртолт үйлдэх гадаргуутай огтлолцсон цэгийг;

Босго хугацаа / Threshold time гэж:

- (1) 2 турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, 60 минут;
- (2) 2-оос олон турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, 180 минутыг;

Бөглүү аэродром / Remote aerodrome гэж хөөрөлт, эсхүл буулт үйлдэхэд ашигладаг, усан дээр, эсхүл газар дээр тогтоосон дараах талбай, эсхүл байгууламжийг:

- (1) тухайн байршилд замаар, эсхүл усаар хүрэхэд хүндрэлтэй бөгөөд газар зүйн нөхцөлөөс шалтгаалан зам нь хязгаарлагддаг, эсхүл хаагддаг;
- (2) ИНД-139-ийн дагуу Даргын хүлээн зөвшөөрөхүйц аэродромын стандартыг хангаагүй;

Бөмбөлөг / Balloon гэж хөдөлгүүргүй, агаараас хөнгөн агаарын хөлгийг;

Буултын боломжит зай / Landing distance available (LDA) гэж нисэх онгоцны газрын гүйлтэд ашиглахад бэлэн ба тохиромжтой гэж тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчээс мэдэгдсэн ХБЗ-ны уртыг;

Буултын талбай / Landing area гэж агаарын хөлөг буулт, эсхүл хөөрөлт үйлдэхэд зориулсан хөдөлгөөнт талбайн хэсгийг;

Буцах боломжгүй болох цэг / Point of no return гэж тухайн цэгээс нисэх онгоц нисэн очих аэродром руу, мөн тухайн нислэгт өгөгдсөн нислэгийн замын дагуух бэлтгэл аэродром руу нисэн хүрч чадах газар зүйн сүүлчийн боломжит цэгийг;

Бүрдэл хэсэг / Component гэж нислэгт агаарын хөлгийг ажиллуулах, эсхүл удирдахад ашигладаг, эсхүл ашиглахаар зорьж байгаа, эсхүл тухайн агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн, тухайн үйлдвэрлэгч эдгээр эд зүйлийг стандарт эд анги гэж тогтоосноос бусад тохиолдолд, үйлдвэрлэгчээс олгосон серийн болон эд ангийн дугаартай, хүчилсэн бүтэц, агаарын хөлгийн хөдөлгүүр, эсхүл сэнсийг багтаасан багаж хэрэгсэл, механизм, төхөөрөмж, эд анги, эсхүл туслах тоноглолыг;

Бүртгэгдсэн өмчлөгч / Registered proprietor гэж Газрын тухай хуульд тодорхойлсон бүртгэгдсэн өмчлөгчийг;

Бүртгэгч улс / State of Registry гэж тухайн агаарын хөлгийг бүртгэсэн улсыг;

Бүртгэлтэй харилцагч / Known customer гэж илгээгчийн ачаа, эсхүл шууданг агаараар тээвэрлүүлэхээр Зохицуулалттай агаарын ачааны байгууллага, эсхүл агаарын тээвэрлэгчтэй холбоо тогтоосон, зохицуулалттай агаарын ачааны байгууллага, эсхүл Агаарын тээвэрлэгчид бүртгэлтэй ачаа, эсхүл шуудан илгээгчийг;

Бүрэн ажиллагаатай хос удирдлага / Fully functioning dual controls гэж нисгэгчийн суудлаас удирдаж болдог хөндлөн (pitch), тууш (roll), босоо (yaw) тэнхлэгийн дагуух хөдөлгөөний болон хөдөлгүүрийн хүчний удирдлагыг;

Бүсийн навигаци (RNAV) / Area Navigation (RNAV) гэж газрын, эсхүл сансрын навигацийн туслах төхөөрөмжийн бүрхэлтийн хүрээнд, эсхүл өөртөө агуулсан туслах төхөөрөмжийн хүчин чадлын хязгаарлалтын хүрээнд, эсхүл тэдгээрийн хослолын хүрээнд агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааг хүссэн нислэгийн замаар хийх боломжийг олгодог навигацийн аргачлалыг;

Бүсийн удирдлагын төв / Area control centre гэж өөрийн хариуцдаг удирдлагын бүсийн хяналттай нислэгт НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгжийг;

Бүсийн удирдлагын үйлчилгээ / Area control service гэж хяналттай агаарын зайд хяналттай нислэгт үзүүлдэг НХУ-ын үйлчилгээг;

Бүтээгдэхүүн / Product гэж агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, эсхүл сэнсийг;

Бүхээгийн ажилтан / Flight attendant гэж агаарын хөлөгт зорчигчдын аюулгүй байдлыг хөлгийн даргын өмнө хариуцахаар зохих ёсоор сургалтад хамрагдаж, үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон этгээдийг;

Бэлтгэл аэродром / Alternate aerodrome гэж буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродромд буух, эсхүл түүнийг чиглэн нисэх боломжгүй, эсхүл тохиромжгүй болсон аль ч үед агаарын хөлөг чиглэн нисэж болох аэродромыг;

В ангиллын ачаа, эсхүл тээшний бүхээг / Class B cargo or baggage compartment гэж дараах ачааны, эсхүл тээшний хэсгийг:

- (1) нислэгт, багийн гишүүн чөлөөтэй нэвтрэх гарц бүхий, гар-гал унтраагууртай бүхээгийн аль ч хэсэгт саадгүй хүрэх боломжтой;
- (2) нэвтрэх гарцыг ашигласан үед багийн гишүүд, эсхүл зорчигч байрласан бүхээгт осолтой хэмжээний утаа, гал, эсхүл унтраах бодис нэвтэрч ордоггүй;
- (3) нисгэгч, эсхүл нисэх-инженерийн хэрэглэлийн самбарт анхааруулах дохио өгөх, тусдаа, зөвшөөрөгдсөн утаа мэдрэгч, эсхүл галын дохиоллын системтэй;

Вариант / Variant гэж нисэх онгоцны нэг үндсэн маяг, эсхүл мастер сериэс гаралтай боловч төхөөрөмж нь ялгаатай, эсхүл аюулгүй үйл ажиллагааны журам нь нисэх багийн гишүүдээс нэмэлт мэдлэг, ур чадвар, эсхүл чадавх шаарддаг нисэх онгоцыг;

VFR нислэг / VFR flight гэж ил харааны нислэгийн дүрмийн дагуу үйлдэж байгаа нислэгийг;

VORSEC гэж VOR/DME секторын минимум өндрийн-түвшний зургийг;

VORTAC гэж VOR болон TACAN хослолыг;

Гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа / Foreign air transport operation гэж гадаадын иргэн, эсхүл гадаадын агаарын тээвэрлэгчийн гүйцэтгэдэг дараах агаарын тээврийн үйл ажиллагааг:

- (1) Монгол Улс руу, эсхүл Монгол Улсаас гүйцэтгэх үйл ажиллагаа; эсхүл
- (2) Монгол Улс руу, эсхүл Монгол Улсаас гүйцэтгэх агаарын тээврийн үйл ажиллагааны нэг хэсэг болох, Монгол Улсын дотор гүйцэтгэх үйл ажиллагаа;

Гадаадын агаарын хөлөг / Foreign aircraft гэж дараах агаарын хөлгийг:

- (1) ИНД-47-гийн дагуу бүртгэлтэй байхыг шаардсан;
- (2) Монгол Улсад бүртгэгдээгүй агаарын хөлөг;

Гадур боодол / Overpack гэж хадгалах болон тээвэрлэхэд тохиромжтой, тээвэрлэлтийн 1 нэгж болгон 1, эсхүл түүнээс олон баглаа боодлыг багтаахад ашигладаг баглааг;

Газар зүйн солбицол / Geographical co-ordinates гэж World Geodetic System 1984-ийн газар зүйн тогтоосон цэгээс (geodetic reference datum) эхлэлтэй өргөрөг болон уртрагийг;

Газрын багийн гишүүн / Ground crew member гэж газрын үйл ажиллагаанд чөлөөт нисэхийн гэрчилгээ эзэмшигчийн томилсон ба үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдсан, чөлөөт нисэхийн аюулгүй байдалд зайлшгүй шаардлагатай этгээдийг;

Галт зэвсэг / Firearm гэж 2015 оны Галт зэвсгийн тухай хуульд заасныг;

Ганц-нисгэгчтэй агаарын хөлөг / Single-pilot aircraft гэж тухайн нислэгийн төрөлд, минимум нисэх баг нь нэг-нисгэгчтэйгээр үйл ажиллагаа эрхэлж болохыг нислэгийн зааварт нь зөвшөөрсөн агаарын хөлгийг;

Ганц-нисгэгчтэй үйл ажиллагаанд гэрчилгээжсэн / Certificated for single-pilot operation гэж агаарын хөлгийн хувьд, гэрчилгээжүүлэлтийн явцад Бүртгэгч улс, минимум багийн гишүүн нэг нисгэгчтэй аюулгүй үйл ажиллагаа гүйцэтгэж чадах агаарын хөлгийн маяг болохыг тогтоосныг;

Гар тээш / Carry on baggage гэж тээш болон дараах эд зүйлийг:

- (1) тухайн Үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу зорчигч, эсхүл багийн гишүүд агаарын хөлөгт авч ордог;
- (2) тухайн зорчигч, эсхүл багийн гишүүний хяналтад байдаг;

Глайдер / Glider гэж:

- (1) нислэгийн тодорхой нөхцөлд хөдөлгөөнгүй байрласан гадаргуу нь агаартай харилцан үйлчилснээр, нислэгт үндсэн өргөх хүч үүсгэдэг, хөдөлгүүргүй, агаараас хүнд агаарын хөлгийг;
- (2) үүнд, хөдөлгүүр нь ажиллаж байгаа эсэхээс үл хамааран моторт-глайдер мөн багтана;

Глайдерын байгууллага / Gliding organisation гэж глайдерын үйл ажиллагаатай холбоотой тухайн эрхийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн, ИНД-149-ийн дагуу олгосон Нисэх клубийн гэрчилгээ эзэмшигчийг;

Гурван талт зураг / Three-view drawing гэж агаарын хөлгийн харагдах байдлыг дээд, урд болон хажуугийн түвшнээс цогцоор харуулсан, агаарын хөлгийн нарийвчилсан дүрслэлийг;

Гүйцэтгэх захирал / Chief Executive Officer (CEO) гэж тухайн байгууллагын үйл ажиллагааны санхүүжилт, холбогдох Хууль, ИНД-ийн байнгын хэрэгжүүлэлтэд өдөр тутмын хяналт тавьж, эцсийн хариуцлага хүлээх үүрэгтэй этгээдийг;

Гэмтлийн зөрчил / Defect incident гэж нислэгт, эсхүл газарт илэрсэн, агаарын хөлөг, эсхүл түүний бүрдэл хэсгийн татгалзал, эсхүл доголдолтой холбоотой зөрчлийг;

Гэрчилгээжсэн байгууллага / Certificated organisation гэж Хуулийн дагуу боловсруулсан ИНД-ээр гэрчилгээ авсан байгууллагыг;

Гэрчилгээжсэн максимум хөөрөлтийн жин (MCTOW) / Maximum certificated take-off weight гэж агаарын хөлгийн хувьд, агаарын хөлгийн нислэгийн зааварт, эсхүл НТЧ-ын гэрчилгээнд тухайн агаарын хөлгийн хөөрөлтийн максимум жин гэж заасан жинг;

GPS өгөгдлийн сан / GPS database гэж нисэх буудал, илтгэх цэгийн навигацийн туслах төхөөрөмж, хэрэглэлээр нисэн гарах стандарт, хэрэглэлээр нисэн ирэх стандарт, хэрэглэлээр ойртолт үйлдэх, тусгай зориулалтаар ашиглах агаарын зай болон нисгэгчид хэрэгцээтэй бусад мэдээллийг агуулсан цахим ой санамжийг;

GPS-мэдрэгч / GPS sensor гэж FMS-ийн хүрээнд нислэгт ашигладаг ганц GPS төхөөрөмжийг;

Дамжин өнгөрөх тээш / Transit baggage гэж:

- (1) аэродромд агаарын хөлөг ирэхэд түүний бүхээгт байсан;
- (2) тухайн аэродромыг агаарын хөлөг орхиход бүхээгт байсаар байгаа тээшийг;

Дарга / Director гэж Хуулийн дагуу томилогдсон ИНЕГ-ын даргыг;

Даргын хүлээн зөвшөөрөхүйц агаарын тээврийн нисгэгчийн сургалтын хөтөлбөр / Airline transport pilot training program acceptable to the Director гэж гэрчилгээ эзэмшигч АС61-7-гийн дагуу боловсруулж, Даргын баталсан сургалтын хөтөлбөрийг;

Даялах максимум хугацаа / Maximum diversion time гэж EDTO нислэг үйлдэж байгаа тухайн цэгээс, замын EDTO нислэгийн бэлтгэл аэродромд хүрэх нэг хөдөлгүүр ажиллагаагүй аяллын нислэгийн хурдтайгаар, тогтуун агаарт, ISA нөхцөлд, олон-турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоц нисэхээр тооцсон максимум нислэгийн цагийг;

Даялах хугацаа сунгасан нислэгийн үйл ажиллагаа (EDTO) / Extended diversion time operation (EDTO) гэж тухайн замын цэгээс тохиромжтой аэродромд хүрэх (нэг хөдөлгүүр ажиллагаагүй аяллын нислэгийн хурдтайгаар, тогтуун агаарт, ISA нөхцөлд тооцсон) нислэгийн цаг нь тухайн нисэх онгоцонд тогтоосон босго хугацаанаас их байх олон-турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцны нислэгийг;

Дирижабль / Airship гэж хөдөлгүүртэй, агаараас хөнгөн агаарын хөлгийг;

Дундаж чөлөөт бөмбөлөг / Medium free balloon гэж дараах чөлөөт бөмбөлгийг:

- (1) 2, эсхүл түүнээс дээш багц ашигт ачааллаас бүрдсэн, дараах нийлбэр жинтэй ашигт ачаалал тээвэрлэдэг:
 - (i) 4 кг-аас их;
 - (ii) 6 кг-аас бага;
- (2) хүнд чөлөөт бөмбөлгийн тодорхойлолтод заасан шалгуурыг хангаагүй;

Дутагдал / Defect гэж нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсгийг зориулалтын дагуу ашиглах боломжгүй, НТЧ-гүй болгодог бүтцийн, эсхүл чанарын өөрчлөлтийг;

Дуу багасгах журам / Noise abatement procedures гэж аэродромын ойролцоо бүсэд дуу чимээг багасгах зорилгоор хэрэгжүүлдэг нислэгийн журмыг;

Дүгнэгч-нисгэгч / Evaluator гэж мэргэшсэн шалгагч-нисгэгч, эсхүл мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийн (AQP) дагуу багийн гишүүн, багш, сургагч, бусад дүгнэгч-нисгэгч болон нислэгийн үйл ажиллагааны ажилтны ур чадварын дүгнэлт гаргах мэргэшүүлэх сургалтад хамрагдаж болон амжилттай дүгнэгдсэн этгээдийг;

Дүрмийн шаардлагаас чөлөөлөх / Exemption гэж ИНД-ийн шаардлагыг Даргын зөвшөөрсөн өөр хэлбэрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

Ерөнхий заавар / Exposition гэж агуулгыг өөрөөр шаардаагүй бол ИНД-ээр шаардсан Ерөнхий зааврыг;

Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ / General aviation air operator certificate гэж тухайн эзэмшигчид Дарга ИНД-135-ын дагуу нисдэг тэрэг, эсхүл шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна 9, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай, МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоц ашиглан, SEIFR-зорчигч тээврийн үйл ажиллагаанаас бусад арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх эрх олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг;

Ерөнхий зориулалтын нисэхийн бүс / General aviation area гэж VFR нислэгийн идэвхтэй ажиллагаа гүйцэтгэж болох, G-ангиллын агаарын зайн дүрэм үйлчилдэг тогтоосон хэмжээтэй агаарын зайг;

Ерөнхий чиглэл / General direction гэж ИНД-67-гийн хувьд, Даргын гаргасан Ерөнхий чиглэлийг;

EDTO бататгах нислэг / EDTO verification flight гэж тухайн нисэх онгоц нь EDTO нислэгийн шаардлага хангаж байгааг тогтоох зорилгоор үйлдэх нислэгийг;

EDTO нислэг эхлэх цэг / EDTO entry point гэж тухайн цэгээс, нэг хөдөлгүүр ажиллагаагүй аяллын нислэгийн хурдтайгаар, тогтуун агаарт, ISA нөхцөлд нисэн хүрэхээр тооцоолсон тохиромжтой аэродромд хүрэх нислэгийн цаг нь тухайн нисэх онгоцонд тогтоосон босго хугацаанаас их байх, нисэх онгоцны EDTO нислэгийн замын анхны цэгийг;

EDTO нислэгийн бэлтгэл аэродром / EDTO alternate aerodrome гэж дараах тохиромжтой аэродромыг:

- (1) ИНД-139-ийн дагуу гэрчилгээжсэн, эсхүл гэрчилгээжсэн аэродромд тавьдаг аюулгүй байдлын дүйцэх шаардлагыг хангасан;
- (2) ашиглаж байгаа нисэх онгоцны маягт нийцсэн дараах байгууламж болон үйлчилгээгээр хангадаг:
 - (i) тухайн аэродромын цаг уурын урьдчилсан мэдээ;
 - (ii) тухайн улсын AIP-д хэвлэн нийтэлсэн, 1-ээс доошгүй тохирох хэрэглэлээр ойртолт үйлдэх журам;
 - (iii) тухайн нисэх онгоц нисэн ирэх тооцоот цагаас 30-аас доошгүй минутын өмнө аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх чадвартай;
 - (iv) урьдчилан мэдэгдсэн тохиолдолд, тухайн нисэх онгоц нисэн ирэх тооцоот цагаас 30-аас доошгүй минутын өмнө категори 4-өөс доошгүй аврах болон гал унтраах төхөөрөмжөөр үйлчлэх чадвартай;

EDTO нислэгийн эрсдэлтэй түлш / EDTO critical fuel гэж тухайн нислэгийн замын хамгийн эрсдэлтэй цэгт хамгийн бага цагийн хязгаарлалттай систем татгалзана гэж тооцон, нислэгийн замын бэлтгэл аэродром руу нисэхэд шаардлагатай түлшний хэмжээг;

EDTO нислэгт нөлөөлөх систем / EDTO significant system гэж тэдгээрийн татгалзал нь EDTO нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, эсхүл тэдгээрийн үйл ажиллагаа нь EDTO нислэгийг аюулгүй үргэлжлүүлэх болон даялалтын үед аюулгүй буулт үйлдэхэд чухал шаардлагатай, нисэх онгоцны татах хүчний систем болон нисэх онгоцны бусад системийг;

Extended Squitter / Extended Squitter гэж стандарт Mode S дамжуулалт болон ADS-B OUT-д шаарддаг өгөгдлийг багтаасан extended squitter транспондероор дамжуулдаг нэмэлт өгөгдлийг;

Жагсаалын нислэг / Formation flight гэж нэгээс дээш агаарын хөлгийн дараах нислэгийг:

- (1) ганц агаарын хөлөг мэт нислэг үйлдэж, мэдээлдэг;
- (2) жагсаалын удирдагчаас 1.8 км (1 nm)-ээс холгүй хэвтээ, 30 м (100 feet)-ээс холгүй босоо зайд жагссан;

Жиро-глайдер / Gyroglider гэж хүн, эсхүл хүмүүсийг тээвэрлэх чадвартай, газар, эсхүл усан гадаргуугаас чирдэг, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр, ихэвчлэн босоо тэнхлэгтэй 1, эсхүл түүнээс олон ротор чөлөөтэй эргэн агаарт хөөрдөг, хөдөлгүүргүй, агаараас хүнд агаарын хөлгийг;

Заасан өндөр / Defined height or Screen height гэж А ангиллын нисэх онгоцны хувьд 10.5 м (35 ft), В ангиллын нисэх онгоцны хувьд 15 м (50 ft) (А ангиллын нисэх онгоц - тээврийн категорийн, эсхүл агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаг нисэх онгоц);

Загвар пуужингийн аюулгүй байдлын дүрэм / Model Rocketry Safety Code гэж Монгол Улсын Нисэх Загварын Спортын Нийгэмлэгээс гаргасан дүрмийг;

Загварын өөрчлөлт / Design change гэж тухайн өөрчлөлт нь бүтээгдэхүүн, түүний бүрдэл хэсэг, эсхүл хэрэгсэлд модификаци, эсхүл их засвар хийхийг шаарддаг маягийн загварын өөрчлөлт, эсхүл маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний аливаа хэсгийн өөрчлөлтийг;

Зайнаас удирддаг агаарын хөлөг / Remotely piloted aircraft гэж зайнаас удирдан нисгэдэг хүнгүй агаарын хөлгийг, үүнд:

- (1) радио удирдлагатай агаарын хөлгийн загвар болон дрон багтана; гэхдээ
- (2) утсан удирдлагатай, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар багтахгүй;

Зардал хуваах нислэг / Cost sharing flight гэж зөвхөн хүмүүс тээвэрлэх зорилгоор гүйцэтгэсэн дараах нислэгийг:

- (1) тухайн нислэгийг нийтэд сурталчлаагүй;
- (2) тухайн багийн гишүүд нь үйлчилгээндээ төлбөр, эсхүл бусад шан урамшуулал авдаггүй;
- (3) агаарын хөлгөөр зорчсон хүмүүс болон багийн гишүүд нь тухайн нислэгийн зардлыг адил тэнцүү хуваадаг;
- (4) тухайн нислэгт оролцсон этгээдээс энэ хэсгийн (3)-д зааснаас өөр төлбөр, эсхүл бусад шан урамшуулал шаарддаггүй;

Зардал хуваах нислэгийг хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа гэж үзэхгүй;

Зарласан зай / Declared distance гэж ХБЗ-ны хувьд, дараах зайг:

- (1) Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зай (TORA);
- (2) Хөөрөлтийн боломжит зай (TODA);
- (3) Хөөрөлтийн гүйлтийг зогсоох боломжит зай (ASDA);
- (4) Буултын боломжит зай (LDA);

Засвар / Repair гэж гэмтсэн, эсхүл элэгдсэн агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл тэдгээрийн эд ангийг холбогдох НТЧ-ын шаардлагын дагуу нислэгт тэнцэх нөхцөлд сэргээн оруулах үйл явцыг;

Зогсоох зурвас / Stopway гэж хөөрөлтийг үргэлжлүүлэхээс татгалзсан тохиолдолд, агаарын хөлгийг зогсоох зорилгоор хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зайн (TORA) төгсгөлд бэлдсэн, газар дээр тогтоосон, тохиромжтой тэгш өнцөгт талбайг;

Зорчигч / Passenger гэж багийн гишүүдээс бусад, агаарын хөлгөөр тээвэрлэж байгаа этгээдийг;

Зохион бүтээгч улс / State of Design гэж тухайн маягийн загварын эрх эзэмшдэг байгууллагыг хуулийн дагуу хариуцсан улсыг, эсхүл хэд хэдэн улсын байгуулсан байгууллагыг;

Зохицуулалттай агаарын ачааны байгууллага / Regulated air cargo agent гэж ИНД-109-ийн дагуу олгосон, зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээ эзэмшигчийг;

Зөвшилцлийн стандарт / Consensus standard гэж спортын хөнгөн агаарын хөлгийг гэрчилгээжүүлэх зорилгоор агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх болон НТЧ-т хамаарах үйлдвэрлэл-хөгжүүлсэн стандартыг. Энэ стандартад, агаарын хөлгийн загвар болон үзүүлэлтийн стандарт, шаардлагатай төхөөрөмж, үйлдвэрлэгчийн чанар баталгаажуулалтын систем, үйлдвэрлэлийн баталгаажуулах тестийн журам, үйл ажиллагааны зааварчилгаа, техник үйлчилгээний болон үзлэг шалгалтын журам, том засвар, том өөрчлөлтийг тодорхойлох болон бүртгэх, НТЧ-ын байнгын хадгалалт багтах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй;

Зөвшөөрлийн хязгаар / Clearance limit гэж тухайн агаарын хөлөгт олгосон НХУ-ын зөвшөөрөл үйлчлэх төгсгөлийн цэгийг;

Зөвшөөрөгдөөгүй эд зүйл / Unauthorised article гэж аливаа этгээд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, эсхүл хүндэтгэх шалтгаангүйгээр, эсхүл тухайн агаарын хөлгийн өмчлөгч, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөлгүй, эсхүл тухайн зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр агаарын хөлөгт авч орсон, эсхүл авч орохыг завдсан дараах эд зүйлийг:

- (1) галт зэвсэг; эсхүл
- (2) бусад аюултай, эсхүл хор хөнөөл учруулах зэвсэг, эсхүл эдгээрийн аливаа төрлийн хэрэгсэл; эсхүл
- (3) сум хэрэгсэл; эсхүл
- (4) тэсрэх бодис, эсхүл хэрэгсэл, эсхүл бусад гэмтэл учруулах бодис, эсхүл агаарын хөлгийн, эсхүл түүний бүхээгт байгаа этгээдийн аюулгүй байдалд аюул учруулахад ашиглах аливаа төрлийн хэрэгсэл;

Зөвшөөрөгдсөн / Approved гэж аливаа этгээдтэй холбоотой хэрэглэснээс бусад тохиолдолд Даргын бичгээр зөвшөөрсөн хэлбэрийг;

Зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч / Approved handler гэж онц аюултай бодисыг зохицуулах тусгай зөвшөөрөлтэй этгээдийг;

Зөвшөөрөгдсөн сургалт / Approved training гэж үйлдвэрлэгчийн, эсхүл Хэлэлцэн тохиролцогч улсын зөвшөөрсөн, эсхүл хамтын ажиллагааны зохицуулалтаар хүлээн зөвшөөрсөн сургалтын байгууллагын хяналтын дор зохион байгуулдаг сургалтыг;

Зөвшөөрөл / Validation гэж НХУ-ний зэрэглэлийн хувьд, тухайн зэрэглэлийн эрхийг тодорхой байрлал болон үйл ажиллагааны нэгжид хэрэгжүүлэх эрхийг;

Зөөлтийн нислэг / Consolidation гэж аливаа этгээд шинээр олж авсан мэдлэг болон ур чадвараа практик болон туршлагаар дамжуулан сайжруулах үйл явцыг;

Зөрчил / Incident гэж агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, түүний үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох, ослоос бусад хэрэг явдлыг;

Зүрхний электрон төхөөрөмж / Cardiac pacemaker гэж хүний биед суулгах боломжтой, зүрхний хэмнэлийг сайжруулагч автомат төхөөрөмжийг;

Зэрэглэл / Rating гэж тухайн үнэмлэх, эсхүл гэрчилгээтэй холбоотой тусгай нөхцөл, эрх, эсхүл хязгаарлалтыг зааж байгаа үнэмлэх, гэрчилгээ, эсхүл бүртгэлийн дэвтэрт тэмдэглэсэн, эсхүл тэдгээрт хавсаргасан эрхийг;

Зэрэглэлтэй нислэгийн мэдээллийн ажилтан / Rated flight service operator гэж ИНД-65-ын дагуу олгосон, тодорхой ажлын байранд хүлээн зөвшөөрөгдсөн хүчинтэй үнэмлэх болон зэрэглэл эзэмшдэг нислэгийн мэдээллийн ажилтныг;

Зэрэглэлтэй нислэгийн хөдөлгөөний удирдагч / Rated air traffic controller ИНД-65-ын дагуу олгосон, тодорхой ажлын байранд хүлээн зөвшөөрөгдсөн хүчинтэй үнэмлэх болон зэрэглэл, эсхүл зэрэглэлүүд эзэмшдэг нислэгийн хөдөлгөөний удирдагчийг;

Зэрэглэлтэй, аэродромын нислэгийн мэдээллийн ажилтан / Rated aerodrome flight information operator гэж ИНД-65-ын дагуу олгосон, тодорхой ажлын байранд хүлээн зөвшөөрөгдсөн хүчинтэй үнэмлэх болон аэродромын нислэгийн мэдээллийн зэрэглэл эзэмшдэг нислэгийн мэдээллийн ажилтныг;

Идэвхтэй нисгэгч / Pilot flying гэж тухайн үе шатанд нислэгийг удирдах, зохицуулах үндсэн үүрэгтэй нисгэгчийг; Мөн идэвхтэй нисгэгч нь радио холбоо барих, агаарын хөлгийн системийг хянах, бусад үйл ажиллагааг гүйцэтгэх багийн бусад гишүүдэд хяналт тавих үүрэгтэй;

Ил харааны ажиглалтын систем / Visual surveillance system нь аэродром, түүний ойролцоох орчны нөхцөл байдлыг хянахад шаардлагатай нислэгийн хөдөлгөөн болон бусад мэдээллийг электрон дэлгэцээр үзүүлдэг дурантай камерын системийг багтаана;

Ил харааны нислэгийн цаг уурын нөхцөл (VMC) / Visual meteorological conditions (VMC) гэж заасан минималтай тэнцүү, эсхүл түүнээс дээш, хараагаар, үүлнээс барих зайгаар болон үүлний суурийн өндрөөр илэрхийлдэг цаг уурын нөхцөлийг;

Илгээх бараа / Consignment гэж 1 илгээгчээс 1 цагт, 1 хаягаар, 1 авалтаар авсан ба 1 хүлээн авагчид 1 хаягаар хүргэхээр үйл ажиллагаа эрхлэгч хүлээн авсан 1, эсхүл түүнээс олон аюултай барааны баглаа боодлыг;

Илтгэх цэг / Reporting point гэж агаарын хөлөг байрлалаа харьцуулан илтгэж болох онцгойлон заасан (нэрлэсэн) газар зүйн байршлыг;

ИНЕГ / Authority гэж Хуулийн дагуу байгуулагдсан Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газрыг;

Иргэний нисэх / Civil aviation гэж Конвенцийн Зүйл 3-т заасан улсын агаарын хөлгийн үйл ажиллагаанаас бусад, иргэний агаарын хөлгийн үйл ажиллагааг;

Иргэний нисэхийн дүрэм (ИНД) / Civil Aviation Rules (CAR) гэж Конвенцийн Аппен-дын стандарт, зөвлөмжийн суурь түвшнийг хангах зорилгоор Хуульд нийцүүлэн боловсруулж, Сайдын баталсан, иргэний нисэхийн аюулгүй байдлын зохицуулалтын дүрмийг;

Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт / Accredited medical conclusion гэж эрүүл мэндийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн эрүүл мэндийн байдлын талаар шийдвэр гаргах зорилгоор Даргын хүлээн зөвшөөрөхүйц 1, эсхүл түүнээс олон эксперт-эмчийн гаргасан дүгнэлтийг;

Их засвар / Overhaul гэж агаарын хөлөг, эсхүл түүний бүрдэл хэсгийн хувьд, үзүүлэлт болон ашиглалтын хугацааг сэргээх зорилготой задаргаа болон бүрэн гүйцэд шалгалтыг багтаасан багтаамж ихтэй ажлыг;

ICAO Doc гэж ICAO Document-ийг;

ICAO-гийн Хэлэлцэн тохиролцогч улс / ICAO Contracting State гэж Конвенцид гарын үсэг зурсан улсыг; мөн Конвенцид гарын үсэг зурсан улсуудын байгуулсан, тэдгээр улсуудын өмнөөс нисэхийн холбоотой баримт бичиг, эсхүл эрх олгодог байгууллага багтана;

IFR нислэг / IFR flight гэж хэрэглэлийн нислэгийн дүрмийн дагуу үйлдэж байгаа нислэгийг;

Конвенци / Convention гэж:

- (1) 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Чикаго хотод гарын үсэг зурсан Олон улсын иргэний нисэхийн тухай конвенци; болон
- (2) дараах баримт бичгийг:
 - (i) Монгол Улс соёрхон баталсан, Конвенцийн Зүйл 94(a)-ийн дагуу хүчинтэй болсон Конвенцийн нэмэлт өөрчлөлт;
 - (ii) Конвенцийн Зүйл 90-ийн дагуу зөвшөөрсөн аливаа Annex, эсхүл түүний нэмэлт өөрчлөлт;
 - (iii) Конвенцийн Зүйл 37-гийн дагуу шаардлагатай хугацаанд ICAO-гаас баталж, нэмэлт өөрчлөлт оруулдаг олон улсын стандарт, зөвлөмж;

Конфигураци / Configuration гэж агаарын хөлгийн хувьд, тухайн нисэх онгоцны аэродинамик үзүүлэлтэд нөлөөлдөг далавчны флапс, эсхүл газардах анги зэрэг хөдөлгөөнт хэсгийн байршлын тодорхой комбинацийг;

Конфигурацийн, техник үйлчилгээний болон журмын стандарт баримт бичиг / Configuration, maintenance and procedures standards document гэж тусгай үзлэг шалгалт, эд ангийн ашиглалтын хязгаар, нисэх багийн журам, MMEL-ийн хязгаарлалт болон тухайн нисэх онгоцны хүчилсэн бүтэц/хөдөлгүүрийн хослол нь EDTO нислэгт нийцэж байгааг тогтооход шаардлагатай техник үйлчилгээний практик аргачлалыг багтаасан, тухайн нисэх онгоцны конфигурацийн минимум шаардлагыг тогтоох зорилгоор гэрчилгээжүүлэх эрх бүхий байгууллагын баталсан баримт бичгийг;

Маневрын талбай / Manoeuvring area гэж:

- (1) агаарын хөлгийн хөөрөлт болон буулт үйлдэх болон хөөрөлт, буулттай холбоотой агаарын хөлгийн гадаргуу дээрх хөдөлгөөнд ашигладаг аэродромын хэсгийг; гэхдээ
- (2) агаарын хөлөгт ачаа ачих, буулгах, эсхүл техник үйлчилгээ хийх зориулан тусад нь тогтоосон талбай орохгүй;

Маяг / Type гэж:

- (1) нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хувьд, жолоодлого, эсхүл нислэгийн үзүүлэлтэд том өөрчлөлт оруулдаг модификацаас бусад түүнд хийсэн бүх модификацийг багтаасан ижил үндсэн загвартай бүх агаарын хөлгийг; эсхүл
- (2) агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, эсхүл сэнсний гэрчилгээжүүлэлтийн хувьд, ижил төстэй загвартай агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, эсхүл сэнсийг;

Маягийн гэрчилгээ / Type certificate нь дараах баримт бичгийг багтаана:

- (1) маягийн загвар;
- (2) үйл ажиллагааны хязгаарлалт;
- (3) маягийн гэрчилгээний өгөгдлийн хуудас (TCDS);
- (4) ИНД-21, Хавсралт С-д заасан хамааралтай НТЧ-ын загварын стандарт;
- (5) агаарын хөлгийн маягийн хувьд, нислэгийн заавар;
- (6) бүтээгдэхүүний маягт хамаарах, ИНД-21-д заасан бусад нөхцөл, эсхүл хязгаарлалт;

Mach-тоо / Mach number гэж агаарын урсгалын жинхэнэ хурд болон дууны хурдны харьцааг;

Модификаци / Modification гэж тухайн бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгслийн конфигурацын өөрчлөлтөд нөлөөлдөг загварын өөрчлөлтийг;

Монгол Улсын AIP / Aeronautical Information Publication Mongolia гэж AIP-ын үйлчилгээ үзүүлэхээр гэрчилгээжсэн НМУБ-ын ИНЕГ-т зориулан хэвлэн нийтэлсэн Монгол Улсын нислэгийн мэдээллийн эмхтгэлийг;

Монгол Улсын Агаарын навигацийн бүртгэл (ANR) / Mongolian Air Navigation Register (ANR) гэж ИНД-71-ийн дагуу хийсэн Монгол Улсын агаарын навигацийн бүртгэлийг;

Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэл / Mongolian Register of Aircraft гэж Хууль болон ИНД-47-гийн дагуу хийсэн агаарын хөлгийн бүртгэлийг;

Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ / Mongolian certificate of registration гэж Даргын олгосон агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг;

Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг / Mongolian registered aircraft гэж тухайн цаг хугацаанд Дарга ИНД-47-гийн дагуу бүртгэсэн агаарын хөлгийг;

Монгол Улсын Нислэгийн Мэдээллийн бүс / Mongolian Flight Information Region (Mongolian FIR) гэж:

- (1) Монгол Улсын нутаг дэвсгэрийн хил хязгаараар тогтоосон агаарын зай;
- (2) Нислэгийн мэдээллийн бүсийн дээд хязгаар 30 000 м (FL 999);
- (3) Нислэгийн мэдээллийн бүсийн доод хязгаар нь газрын гадаргуу;

Моторт-глайдер / Powered glider гэж хөдөлгүүртэй, эсхүл хөдөлгүүр ажиллагаагүй үед глайдерийн техникийн үзүүлэлттэй, 1, эсхүл түүнээс олон хөдөлгүүрээр тоногдсон агаарын хөлгийг;

Мөрдөн шалгах / Prosecution investigation гэж Хууль зөрчсөн гэмт хэрэг гарсан эсэхийг тогтоох зорилгоор хийгдэж байгаа шалгах ажиллагааг;

Навигацийн байгууламж / Navigation installation гэж:

- (1) нислэгийн хөдөлгөөнийг удирдах, эсхүл агаарын навигацид туслах зорилготой аливаа барилга, байгууламж, ажил, аппарат болон төхөөрөмжийг, эсхүл аэродромын хэсэг, эсхүл хэсэг бус байрлалыг;
- (2) аливаа барилга, байгууламж, ажил, аппарат болон төхөөрөмж, эсхүл байрлалын зэргэлдээх болон түүнтэй холбоотой ашигладаг аливаа газрыг;

Навигацийн техникийн үзүүлэлт / Navigation specification гэж тогтоосон агаарын зайд PBN үйл ажиллагааг дэмжихэд шаарддаг, агаарын хөлөг болон нисэх багийн шаардлагын багцыг. Дараах хоёр төрлийн навигацийн тодорхойлолт байдаг:

- (1) Навигацийн шаардлагатай үзүүлэлтийн (RNP) тодорхойлолт: RNP 4, RNP APCH зэрэг RNP-ээр илэрхийлдэг, үзүүлэлтийн мониторинг болон анхааруулах шаардлагыг багтаасан бүсийн навигацид (RNAV) суурилсан навигацийн тодорхойлолт;
- (2) Бүсийн навигацийн (RNAV) тодорхойлолт: RNAV 5, RNAV 1 зэрэг RNP-ээр илэрхийлдэг, үзүүлэлтийн мониторинг болон анхааруулах шаардлагыг багтаагаагүй бүсийн навигацид суурилсан навигацийн тодорхойлолт.

Нарийвчилсан үзлэг / Detailed inspection гэж хэсэгчилсэн үзлэгийн хувьд, бүрдэл хэсгийн, эсхүл системийн их засварыг багтаасан, агаарын хөлөг болон түүний бүрдэл хэсэг, систем, төхөөрөмжид шаардлагатай түвшин хүртэл задаргаа хийж шалгах үзлэгийг;

Нарийвчлалтай бус ойртолт үйлдэх журам / Non-precision approach procedure гэж 2D хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагааны төрөл-А-д зориулан зохиосон хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг:

[Тайлбар - Үргэлжлэн өндөр алдах ойртолтын төгсгөлийн (CDFA) арга техникийг ашиглан нарийвчлалтай бус ойртолт үйлдэх журмаар нислэг үйлдэж болно. Бүхээгийн төхөөрөмжөөр тооцоолсон анхааруулах VNAV чиглүүлэгчтэй CDFA-г 3D хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагаа гэж тооцно. Шаардлагатай өндөр алдах хурдыг гар аргаар тооцоолсон CDFA-г 2D хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагаа гэж тооцно.]

Нарийвчлалтай ойртолт үйлдэх журам / Precision approach procedure гэж азимут болон глиссадын мэдээллийг ашиглан хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг;

Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа / Helicopter external load operation гэж нисдэг тэрэгний дараах үйл ажиллагааг:

- (1) татлагаар дүүжин ачаа чирэх; эсхүл
- (2) дүүжин татлагат ачаа тээвэрлэх; эсхүл
- (3) өргөгч-төхөөрөмжөөр өргөх/буулгах; эсхүл
- (4) олсоор буулгах;

Нисдэг тэргээр дүүжин ачаа чирэх үйл ажиллагаа / Helicopter external load towing operation гэж нисдэг тэрэгний үйл ажиллагааны үед тухайн гадна ачаа нь газартай харьцсан хэвээр байдаг чирэх, буулгах болон хэвтүүлэх ажиллагааг;

Нисдэг тэргээр дүүжин татлагат ачаа тээвэрлэх үйл ажиллагаа / Helicopter external sling load operation гэж нисдэг тэрэгний өөхийд бэхэлсэн сагс, тор, даруулга бэхэлгээ, татлага, эсхүл дамнуурга ашиглан ачаа, карго, эсхүл зорчигчийг нисдэг тэрэгний гадна талд тээвэрлэх, буулгах, эсхүл авах үйл ажиллагааг;

Нисдэг тэрэг / Helicopter гэж ихэвчлэн босоо тэнхлэгтэй, хөдөлгүүр хөтөлдөг 1, эсхүл түүнээс олон ротор, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр нислэг үйлддэг агаараас хүнд агаарын хөлгийг;

Нислэг дагах хяналтын үйлчилгээ / Flight following service гэж агаарын хөлөг тусгайлан тогтоосон цаг хугацаанд мэдээгээ өгөөгүй, эсхүл нисэн ирээгүй тохиолдолд, онцгой нөхцөлийн арга хэмжээг эхлүүлэх зорилгоор агаарын хөлгийн нислэгийг байнга хянах үйлчилгээг;

Нислэг үйлдэх агаарын зай / Navigable airspace гэж хязгаарлалттай, аюултай бүс болон Монгол Улсын зэвсэгт хүчин ашиглахад зориулан тогтоосон идэвхтэй цэргийн үйл ажиллагааны бүсээс бусад, бүх зөвшөөрөгдсөн нам түвшний нислэгийн үйл ажиллагааг багтаасан, ИНД-д заасан нислэгийн минимум өндрөөс дээших агаарын зайг;

Нислэгийн ачаалал / Traffic load гэж зорчигч, тээш болон ачааны нийт жинг;

Нислэгийн аюулгүй байдал / Flight safety гэж нислэгийн үйл ажиллагааг хүний амь нас, эсхүл өмч хөрөнгөд учирч болох эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд хадгалан гүйцэтгэх нөхцөлийн төлөв байдлыг;

Нислэгийн бичлэгийн төхөөрөмж / Flight recorder гэж осол, эсхүл зөрчилтэй холбоотой шинжлэн шалгах ажиллагаанд ашиглах зорилгоор агаарын хөлөгт суурилуулсан аливаа бичигчийг;

Нислэгийн заавар / Flight manual гэж НТЧ-ын гэрчилгээтэй холбоотой, тухайн агаарын хөлөг уг хязгаарлалтын хүрээнд нислэгт тэнцэнэ гэж үзэх хязгаарлалт болон агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагааг хангахад нисэх багийн гишүүдэд шаардлагатай зааварчилгаа болон мэдээллийг агуулсан зааврыг;

Нислэгийн зааварчилгаа / Flight instruction гэж үндсэн болон нэмэлт нислэгийн маневр хийж, агаарын хөлгийг удирдах зааварчилгааг; мөн үүнд хөдөлгөөнгүй-далавчтаас ротор-далавчит агаарын хөлөгт, эсхүл ротор-далавчтаас хөдөлгөөнгүй-далавчит агаарын хөлөгт шилжин суралцах зааварчилгаа багтана;

Нислэгийн мэдээллийн бүс (FIR) / Flight information region гэж нислэгийн мэдээллийн үйлчилгээ болон аюулын дохио мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор тогтоосон хэмжээтэй агаарын зайг;

Нислэгийн мэдээллийн төв / Flight information centre гэж бүсийн нислэгийн мэдээллийн үйлчилгээ болон аюулын дохио мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгжийг;

Нислэгийн мэдээллийн үйлчилгээ / Flight information service гэж нислэгийг аюулгүй, үр ашигтай гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр хангах НХҮ-г;

Нислэгийн өмнөх мэдээллийн товхимол / Pre-flight information bulletin гэж нислэгийн өмнө бэлтгэсэн, нислэгийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой, хүчинтэй NOTAM мэдээллийн танилцуулгыг;

Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ / Pre-flight information service гэж нислэгийн өмнөх төлөвлөлтөд зориулан Гуравдагч талыг нисэхийн мэдээллээр хангах үйлчилгээг;

Нислэгийн симулятор / Flight simulator гэж дараах шаардлагыг хангасан синтетик нислэгийн дадлагажуурыг:

- (1) FAR Part 121, Appendix H-д заасан D/phase III стандартыг хангасан; эсхүл
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх стандартыг хангасан;

Нислэгийн төлөвлөгөө / Flight plan гэж агаарын хөлгийн төлөвлөж байгаа нислэг, эсхүл нислэгийн тодорхой хэсгийн талаар НХҮ-ний нэгжид, эсхүл нислэг дагах хяналтын үйлчилгээнд ИНД-ээр хүргүүлэхийг шаардсан, тусгайлан заасан мэдээллийг;

Нислэгийн түвшин (FL) / Flight level гэж зуун фитийн утгаар илэрхийлдэг, атмосферийн тогтмол даралтын дараах гадаргууг:

- (1) 1013.2 hPa-аар тогтоосон даралтын эхлэлийн цэгтэй холбоотой;
- (2) бусад гадаргуугаас тогтоосон даралтын үечлэлээр зайчлагддаг;

Нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөө / Operational flight plan гэж тухайн нислэгийг аюулгүй гүйцэтгэх зорилгоор нислэгийн замд болон аэродромд дагаж мөрдөх шаардлагатай, тухайн нисэх онгоцны үзүүлэлт, бусад үйл ажиллагааны хязгаарлалт болон таамаглаж байгаа бодит нөхцөлийн төсөөлөлд суурилан гаргасан, гэрчилгээ эзэмшигчийн төлөвлөгөөг;

Нислэгийн хараа / Flight visibility гэж нислэгийн үед агаарын хөлгийн бүхээгээс урагш харагдах ил харааны зайг;

Нислэгийн хөдөлгөөн / Air traffic гэж нисэж байгаа, эсхүл аэродромын маневрын талбайд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бүх агаарын хөлгийг;

Нислэгийн хөдөлгөөний зөвлөмжийн үйлчилгээ / Air traffic advisory service гэж F-ангиллын агаарын зайд IFR нислэгийн төлөвлөгөөний дагуу нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүдийн хоорондын зайчлалыг боломжит хэлбэрээр хангадаг үйлчилгээг;

Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл / Traffic information гэж тухайн байршил, эсхүл төлөвлөсөн нислэгийн замын ойр байж болох, мэдэгдэж байгаа, эсхүл ажиглагдсан нислэгийн хөдөлгөөнийг нисгэгчид анхааруулж, мөргөлдөхөөс зайлсхийхэд нисгэгчид туслах зорилгоор НХҮ-ний нэгжээс өгдөг мэдээллийг;

Нислэгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зөвлөмж / Traffic avoidance advice гэж мөргөлдөхөөс зайлсхийхэд нисгэгчид туслах зорилгоор маневрыг зааж НХҮ-ний нэгжээс өгдөг зөвлөмжийг;

Нислэгийн цаг / Flight time гэж:

- (1) агаарын хөлгийн хувьд, зогсоолоос түрэх, явгалах болон холбогдох хүлээлтийн цагийг багтаасан, агаарын хөлөг нислэг үйлдэх зорилгоор хөдөлж эхлэхээс, тухайн нислэгийн төгсгөлд бүрэн зогсох хүртэлх нийт хугацааг;
- (2) бөмбөлгийн хувьд, нислэг үйлдэхээр хийлэх зорилгоор халаагчийг асааснаас эхлэн тухайн нислэгийн төгсгөлд бөмбөлгийн хий бүрэн гарах хүртэлх нийт хугацааг;

Нислэгийн цикл / Operating cycle гэж хөөрөлт, өндөр авалт, аяллын нислэгийн зам хэсэг, өндөр алдалт болон буултаас бүрдэх нислэгийн бүтэн үе шатыг;

Нислэгт тэнцэх нөхцөл / Airworthy condition гэж зохион бүтээлт, үйлдвэрлэл, техник үйлчилгээ, модификаци, засвар болон нислэгийн аюулгүй байдалтай холбоотой ИНД-д заасан бүх шаардлагыг хангасан, агаарын хөлгийн бүрдэл хэсэг, түлш болон агаарын хөлгийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бусад материал, бодисыг багтаасан агаарын хөлгийн төлөв байдлыг;

Нислэгт хөдөлгүүр унтрах / In-flight shutdown гэж:

- (1) өөрөө унтрах, нисэх баг унтраах, эсхүл дөл тасрах, дотоод татгалзал, гадны биетийг сорох болон мөстөлтийг багтаасан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй гадны бусад нөлөөгөөр хөдөлгүүр нислэгт ажиллахаа болих болон унтрах, эсхүл
- (2) хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай хөдөлгүүрийн чадлыг гаргах, эсхүл удирдах боломжгүй болохыг, гэхдээ агаарт хөдөлгүүр ажиллахаа больсны дараа автоматаар хөдөлгүүр хурдан эргэж ассаныг тооцохгүй;

Нисэх багийн гишүүн / Flight crew member гэж нислэгийн хугацаанд агаарын хөлөгт нисгэгч, эсхүл нисэх-инженерийн үүрэг гүйцэтгэхээр үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон, зохих ёсоор мэргэшсэн этгээдийг;

Нисэх буудлын нэвтрэх үнэмлэх / Airport identity card гэж ИНД-140-ийн дагуу олгосон, эсхүл зөвшөөрсөн нисэх буудлын нэвтрэх үнэмлэхийг;

Нисэх онгоц / Aeroplane гэж нислэгийн тухайн нөхцөлд хөдөлгөөнгүй байрласан гадаргуу агаартай харьцсан аэродинамикийн хүчний нөлөөллөөр нислэгт ихэнх өргөх хүчээ үүсгэдэг, хөдөлгүүртэй, агаараас хүнд агаарын хөлгийг;

Нисэх онгоцны үйл ажиллагааны үзүүлэлтийн хязгаарлалт / Aeroplane performance operating limitations гэж:

- (1) арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа турбо-жэт, эсхүл турбо-фэн нисэх онгоцны хувьд, ИНД-121-ийн Бүлэг D-д заасан үйл ажиллагааны үзүүлэлтийн хязгаарлалт;
- (2) арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа гадаадын бүртгэлтэй турбо-жэт, эсхүл турбо-фэн нисэх онгоцны хувьд, Бүртгэгч Улсын заасан үйл ажиллагааны үзүүлэлтийн хязгаарлалт;
- (3) арилжааны нислэгийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд ашиглаж байгаа турбо-жэт, эсхүл турбо-фэн нисэх онгоцны хувьд, агаарын хөлгийн нислэгийн зааварт заасан үйл ажиллагааны үзүүлэлтийн хязгаарлалт;

Нисэх онгоцны хөдөлгөөн / Aeroplane movement гэж нисэх онгоцны хөөрөлт, эсхүл буултыг;

Нисэх спортын арга хэмжээ / Aviation event гэж ИНД-91-д заасан минимум аюулгүй өндрөөс доош өндөрт хийдэг дараах арга хэмжээг:

- (1) агаарын шоу, эсхүл агаарын шоуны дасгал сургуулилт; эсхүл
- (2) агаарын уралдаан, эсхүл агаарын уралдааны дадлага; эсхүл
- (3) аэробатикийн тэмцээн; эсхүл
- (4) аэробатикийн сургалт, эсхүл дадлага;

Нисэхийн аюулгүй байдал / Aviation safety гэж агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, эсхүл түүнд шууд дэмжлэг үзүүлдэг нисэхийн үйл ажиллагаанд хамаарах эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд хадгалах ба удирдах нисэхийн байгууллага, эсхүл тогтолцооны төлөв байдлыг;

Нисэхийн аюулгүйн хамгаалалт / Aviation security гэж хүний нөөц болон материаллаг эх үүсвэрийг хослуулах замаар иргэний нисэхийг хууль бус үйлдлээс хамгаалах арга хэмжээг;

Нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтан / Aviation security officer гэж Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн үндсэн ажилтан, эсхүл тухайн цаг хугацаанд нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтны үүрэг гүйцэтгэж байгаа этгээдийг;

Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ / Aviation Security Service гэж Хуулийн дагуу байгуулагдсан Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллагын үйлчилгээг;

Нисэхийн байгууламж / Aeronautical facility гэж:

- (1) IFR нислэг, эсхүл НХҮ-г дэмждэг, нисэхийн радио нэвтрүүлгийн, эсхүл нисэхийн суурин холбооны үйлчилгээнд ашигладаг холбооны төрөл бүрийн системийг; эсхүл
- (2) нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашигладаг, холбооны төрөл бүрийн системийн газрын элементийг; эсхүл
- (3) нисэхийн радио навигацийн үйлчилгээнд ашигладаг төрөл бүрийн радио навигацийн туслах төхөөрөмжийг; эсхүл

- (4) IFR нислэг, эсхүл НХҮ-г дэмждэг газрын холбооны бусад системийг; эсхүл
- (5) нисэхийн хөдөлгөөнт холбооны радио давтамж дээр ажилладаг, цаг агаарын үндсэн мэдээлэл, орон нутгийн аэродромын мэдээ, эсхүл нислэг дагах хяналтын үйлчилгээ үзүүлэхэд ашигладаг газрын холбооны төрөл бүрийн системийг;

Нисэхийн баримт бичиг / Aviation document гэж аливаа этгээд, агаарын хөлөг, аэродром, нисэхийн журам болон нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл нисэхийн холбоотой үйлчилгээний хувьд, Хуулийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ, зөвшөөрөл, эсхүл бусад баримт бичгийг;

Нисэхийн бүтээгдэхүүн / Aeronautical product гэж агаарын хөлгийн үйл ажиллагаанд шаардлагатай түлш болон бусад ижил төрлийн зарцуулалтын материалыг багтаасан, агаарын хөлгийн эд ангийг бүрдүүлдэг, эсхүл бүрдүүлэх зориулалттай, эсхүл агаарын хөлөгт суурилуулсан, түүнд багтсан, нийлүүлсэн, эсхүл суурилуулах, багтаах, нийлүүлэхэд зориулсан аливаа эд зүйлийг;

Нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн / Aeronautical information product гэж цаасан, эсхүл цахим стандартчилсан танилцуулгыг, эсхүл тоон өгөгдлийн багцыг, эсхүл аль алиныг нь хангадаг нисэхийн өгөгдөл болон нисэхийн мэдээллийг. Үүнд дараах мэдээлэл багтана:

- (1) AIP (өөрчлөлт болон нэмэлтийг багтаасан);
- (2) AIC;
- (3) нислэгийн зураг;
- (4) NOTAM;
- (5) тоон өгөгдлийн багц;

Нисэхийн мэдээллийн үйлчилгээ (HMY) / Aeronautical information service (AIS) гэж нислэгийн үйл ажиллагааг аюулгүй, тогтмол, үр ашигтай гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай нисэхийн мэдээллийг түгээх:

- (1) AIP-ын үйлчилгээг; эсхүл
- (2) NOTAM үйлчилгээг; эсхүл
- (3) Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээг;

Нисэхийн мэдээллийн цуврал (AIC) / Aeronautical Information Circular (AIC) гэж дараах мэдээллийг агуулсан мэдэгдлийг:

- (1) NOTAM-аар мэдээлэх, эсхүл Монгол Улсын AIP-д оруулах шаардлагагүй;
- (2) нислэгийн аюулгүй байдал, агаарын навигаци, техник, захиргаа, эсхүл хууль эрх зүйтэй холбоотой;

Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP) / Aeronautical information publication (AIP) гэж тухайн улс, эсхүл түүний зөвшөөрлөөр эрхлэн гаргадаг, агаарын навигацид зайлшгүй шаардлагатай, тогтмол шинж чанартай нисэхийн мэдээллийг агуулсан хэвлэлийг;

Нисэхийн мэдээлэл / Aeronautical information гэж нисэхийн өгөгдлийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, тогтсон загварт оруулсны үр дүнд бий болсон мэдээллийг;

Нисэхийн өгөгдөл / Aeronautical data гэж нислэг, нислэгийн төлөвлөлт, газрын бартааг мэдрэх (terrain awareness) болон нислэгийн симуляторыг багтаасан нисэхийн үйл ажиллагаанд ашигладаг нисэхийн өгөгдөл, газрын бартаа болон саадын өгөгдлөөс бүрдсэн өгөгдлийг;

Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын техник үйлчилгээ / Aeronautical telecommunication service гэж:

- (1) Annex 10, Volume II, Chapter 1-д тодорхойлсон, дараах үйлчилгээг дэмжих зорилгоор үзүүлдэг холбоо, навигаци, ажиглалтын үйлчилгээг:
 - (i) нисэхийн радио нэвтрүүлгийн үйлчилгээ;
 - (ii) нисэхийн суурин холбооны үйлчилгээ;
 - (iii) нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ;
 - (iv) нисэхийн радио навигацийн үйлчилгээ;
- (1A) ИНД-172-ын дагуу НХҮ үзүүлэгч ашиглахад зориулсан, нисэхийн цаг уурын өгөгдлийг багтаасан НХҮ-ын өгөгдлийг боловсруулдаг, эсхүл үзүүлдэг аливаа радио-холбооны үйлчилгээ; эсхүл
- (2) Монгол Улсын агаарын навигацийн системд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн холбоо, навигаци, ажиглалтын бусад үйлчилгээг;

Нисэхийн холбооны станц / Aeronautical station гэж нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний газрын станцыг;

Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ / Aeronautical mobile service гэж нисэхийн холбооны станц болон агаарын хөлгийн станцын хооронд, эсхүл агаарын хөлгийн станц хоорондын холбоонд хэрэглэдэг хөдөлгөөнт холбооны үйлчилгээг; үүнд аврах хэрэгслийн станц багтаж болно. Мөн аюулын болон ослын мэдээлэл дамжуулах тогтоосон давтамж дээр ажилладаг ослын байршил заагч радио дохиологч станц багтаж болно;

Нисэхтэй холбоотой үйлчилгээ / Aviation related service гэж нисэхийн бүтээгдэхүүний хангалтыг багтаасан, иргэний нисэхийн системтэй холбоотой, эсхүл түүнд дэмжлэг үзүүлдэг аливаа төхөөрөмж, байгууламж, эсхүл агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах үйлчилгээнээс бусад НХҮ-г багтаасан үйлчилгээг;

Нойтон ХБЗ / Wet runway гэж ашиглахаар төлөвлөсөн талбай дээрх харагдахуйц чийг тунадастай, эсхүл 3 мм хүртэл усаар бүрхэгдсэн ХБЗ-ын гадаргууг;

Ноцтой зөрчил / Serious incident гэж болсон нөхцөл байдал нь осолд хүргэх дөхсөн зөрчлийг (ослын тодорхойлолт, ноцтой зөрчлийн жишээг АС 12-1-д заасан);

Нөөц хэлбэрийн навигаци / Alternative means of navigation гэж тухайн үйл ажиллагаанд, эсхүл нислэгийн үе шатанд хэрэв анхдагч хэлбэрийн навигаци ажиллагаагүй болсон тохиолдолд тухайн агаарын хөлгийн нислэгийг аюулгүй үргэлжлүүлэн, буулт үйлдэх боломжийг олгодог навигацийн системийг;

Нөөц шүхэр / Reserve parachute гэж үндсэн шүхэр татгалзсан үед хоёрдогч шүхрээр ашиглах зориулалтаар зохион бүтээсэн шүхрийн иж бүрдлийг;

Нөхцөлөөр хянах техник үйлчилгээ / Condition monitored maintenance гэж залруулах арга хэмжээ шаардлагатай гэнэтийн татгалзлыг тодорхойлох зорилгоор тухайн заасан эд зүйлтэй ижил бүх эд зүйлийн ашиглалтын туршлагын дүн шинжилгээнд тулгуурласан, техник үйлчилгээний үр дүнд мониторинг хийдэг техник үйлчилгээний процессыг;

НТЧ-ын гэрчилгээ / Airworthiness certificate гэж:

- (1) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн хувьд, ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу Даргын олгосон НТЧ-ын гэрчилгээ;
- (2) гадаадад бүртгэлтэй агаарын хөлгийн хувьд, Бүртгэгч улсын эрх бүхий байгууллагын олгосон НТЧ-ын гэрчилгээг;

НТЧ-ын өгөгдөл / Airworthiness data гэж нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсэг нь нислэгт тэнцэх нөхцөлөө хадгалж чадахыг бататгахад шаардлагатай мэдээллийг;

НТЧ-ын удирдамж / AD гэж аюулгүй ажиллах нөхцөл хадгалагдаж байгааг бататгах зорилгоор агаарын хөлөг, эсхүл нисэхийн бүтээгдэхүүнд хийгдэх модификаци, үзлэг шалгалт, нөхцөл, эсхүл хязгаарлалтыг тогтоосон заавал хэрэгжүүлэх НТЧ-ын шаардлагыг;

НТЧ-ын хадгалалтын зааварчилгаа / Instructions for continued airworthiness гэж Зохион бүтээгч улсын НТЧ-ын эрх бүхий байгууллагаас заавал хийхийг шаардсан НТЧ-тай холбоотой хязгаарлалтыг багтаасан, нисэхийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсгийн үйлдвэрлэгчээс гаргасан хүчинтэй НТЧ-ын өгөгдлийг;

Нутаг дамнансан нислэг / Cross-country flight гэж нисэн гарсан аэродромоос 46 км-ээс (25 nm) их зайд үргэлжлэх нислэгийг;

НХУ-ын зааварчилгаа / ATC instruction гэж нисгэгчийг тодорхой үйлдэл гүйцэтгэхийг шаардах зорилгоор НХУ-ын өгсөн удирдамжийг;

НХУ-ын зөвшөөрөл / ATC clearance гэж агаарын хөлөг НХУ-ын нэгжийн тогтоосон нөхцөлийн дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх эрхийг;

НХУ-ын нэгж / ATC unit гэж НХУ-ын үйлчилгээний нэгж болон бүсийн удирдлагын төв, ойртолтын удирдлагын төв, эсхүл аэродромын удирдлагын цамхгийг;

НХУ-ын үйлчилгээ / ATC service гэж дараах зорилгоор үзүүлж байгаа үйлчилгээг:

- (1) мөргөлдөхөөс сэргийлэх:
 - (i) агаарын хөлгүүд хоорондоо;
 - (ii) агаарын хөлөг маневрын талбай дээрх саадтай;
- (2) нислэгийн хөдөлгөөний урсгалыг аюулгүй, үр дүнтэй хурдасгах болон зохицуулах;

НХҮ / ATS гэж дараах үйлчилгээг:

- (1) аэродромын удирдлагын үйлчилгээ;
- (2) бүсийн удирдлагын үйлчилгээ;
- (3) ойртолтын удирдлагын үйлчилгээ;
- (4) нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (5) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (6) аюулын дохио мэдээллийн үйлчилгээ;
- (7) иргэний нисэхийн системийн аюулгүй, үр дүнтэй ажиллагаанд зайлшгүй шаардлагатай, эсхүл хэрэгтэй гэж Даргын тодорхойлсон нислэгийн хөдөлгөөний бусад үйлчилгээг;

НХҮ-ний ажиглалтын систем / ATS surveillance system гэж агаарын хөлгийг таньж тогтоох ADS-B, PSR, SSR, эсхүл газарт байрласан бусад төстэй системийг;

[Тайлбар - Газарт байрласан төстэй систем гэж харьцуулсан үнэлгээгээр, эсхүл бусад аргачлалаар аюулгүй байдлын түвшин болон үзүүлэлт нь monopulse SSR-тай тэнцүү, эсхүл илүү гэж тогтоогдсон системийг ойлгоно.]

НХҮ-ний ажилтны үнэмлэх / ATS licence гэж ИНД-65-ийн дагуу олгосон үнэмлэхийг;

НХҮ-ний гэрээ / ATS Letter of Agreement гэж НХҮ-ний нэгжүүдийн хоорондын үйл ажиллагааны онцгой нөхцөлийг зохицуулахаар байгуулсан гэрээг;

НХҮ-ний мэдээ / ATS messages гэж ICAO Doc 4444, Part IX-д заасан онцгой нөхцөлийн мэдээ, хөдөлгөөний ба удирдлагын мэдээ болон нислэгийн мэдээллийн мэдээг;

НХҮ-ний нэгж / ATS unit гэж бүсийн удирдлагын төв, ойртолтын удирдлагын нэгж, эсхүл аэродромын удирдлагын цамхаг, эсхүл эдгээрийн аль алиныг нь багтаасан НХҮ-ын үйлчилгээ үзүүлдэг нэгжийг;

Нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурд / One engine inoperative cruise speed гэж тухайн нислэгийн хувьд, нэг хөдөлгүүр ажиллагаагүй максимум даялалтын хугацаатай холбоотой нөөц түлшний шаардлага болон тогтуун агаарын замын зайг тооцоолоход ашигладаг, гэрчилгээ эзэмшигчийн сонгосон бөгөөд Даргын баталсан, тухайн нисэх онгоцны гэрчилгээжсэн хязгаарлалтын хүрээнд байх хурдыг;

Нэмэлт хэлбэрийн навигацийн систем / Supplemental means navigation system гэж бие даасан хэлбэрийн навигацийн системтэй заавал хамт ашиглах ёстой навигацийн системийг;

NOTAM / NOTAM гэж нисэхийн байгууламж, үйлчилгээ, журам, эсхүл аюул үүсгэж болох нөхцөл, эсхүл өөрчлөлтийн талаар нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа этгээд цаг алдалгүй мэдэх зайлшгүй шаардлагатай мэдээллийг агуулсан, холбооны хэрэгслээр тараадаг мэдээг;

NOTAM үйлчилгээ / NOTAM service гэж Монгол Улс НХҮ-ний хариуцсан Монгол Улсын FIR-д үйлдэх нислэгийн үйл ажиллагаатай холбоотой NOTAM гаргах болон түгээх үйлчилгээг;

Ойртолтын удирдлагын байр / Approach control office гэж 1, эсхүл түүнээс олон аэродромоос нисэн гарах, эсхүл нисэн ирэх хяналттай нислэгт НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгжийг;

Ойртолтын удирдлагын үйлчилгээ / Approach control service гэж нисэн гарах, эсхүл нисэн ирэх хяналттай нислэгт үзүүлэх НХУ-ын үйлчилгээг;

Олон улсын NOTAM-ын нэгж / International NOTAM office (NOF) гэж олон улсад NOTAM солилцохоор тухайн улсын томилсон нэгжийг;

Олон улсын аэродром / International aerodrome гэж олон улсын нисэх буудлыг;

Олон улсын нисэх буудал / International airport гэж гааль, иргэн харьяат, эрүүл ахуй, хорио цээрийн хяналт болон бусад ижил төстэй албан үүргийг хэрэгжүүлдэг, олон улсын нислэг хүлээн авах болон нислэгт гаргахаар тогтоосон нисэх буудлыг;

Олон улсын стандарт атмосфөр / International standard atmosphere гэж ICAO Doc 7488 “Manual of the ICAO Standard Atmosphere”-т заасан атмосферийн стандартыг;

Олон-нисгэгчтэй агаарын хөлөг / Multi-pilot aircraft гэж ганц-нисгэгчтэй агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийг;

Оноосон нэр / Proper shipping name гэж тээвэрлэлтийн баримт, мэдэгдэл болон шаардлагатай бол баглаа боодлын иж бүрдэлд байгаа тодорхой эд зүйл, эсхүл бодисыг тодорхойлоход хэрэглэдэг нэрийг;

Онцгой нөхцөлийн буулт / Emergency landing гэж онцгой нөхцөл байдалд агаарын хөлгөөр үйлдэх дараах буултыг:

- (1) **аргагүйдсэн буулт / Forced landing** - нислэгийг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсноос шалтгаалан аэродромд, эсхүл аэродромын гадна нэн даруй үйлдэх шаардлагатай буулт
- (2) **урьдчилан сэргийлэх буулт / Precautionary landing** - нислэгийг цаашид үргэлжлүүлэх боломжтой боловч төлөвлөсөн үлдэгдэл-нөөц түлшээ зарцуулахаас өмнө аюулгүй буулт үйлдэж чадна гэж үзэн аэродром, эсхүл аэродромын гадна үйлдэх буулт;
- (3) **усан дээрх буулт / Ditching** - усан гадаргуу дээр үйлдсэн аргагүйдсэн, эсхүл урьдчилан сэргийлэх буулт;

Орон нутгийн аэродром / Domestic aerodrome гэж олон улсын аэродромоос бусад аэродромыг;

Ослын байрлал дамжуулагч (аврах) / Emergency locator transmitter (survival) гэж агаарын хөлөгт ослын үед авч хэрэглэхэд хялбар байхаар бэхэлсэн, агаарын хөлгөөс салган авч болдог, гараар ажиллуулдаг ослын байрлал дамжуулагчийг (ELT);

Ослын байрлал дамжуулагч (суурин автомат) / Emergency locator transmitter (automatic fixed) гэж агаарын хөлөгт байнгын хэлбэрээр суурилуулсан, автоматаар ажилладаг ослын байрлал дамжуулагчийг (ELT);

Ослын байрлал дамжуулагч / Emergency locator transmitter (ELT) гэж ЭХАТ үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор, өвөрмөц дохиог тогтоосон давтамжаар мэдээлдэг төхөөрөмжийг;

Ослын байршил заагч радио дохиологч / Emergency position indicating radio beacon гэж ЭХАТ үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор өвөрмөц дохиог тогтоосон радио давтамжаар мэдээлдэг, босоо байрлалтай хөвөхөөр зохион бүтээсэн, гараар ажиллуулдаг төхөөрөмжийг;

Ослын буулт / Crash landing гэж агаарын хөлөг их хэмжээний бүтцийн эвдрэлд орсон буултыг;

Ослын шүхэр / Emergency parachute гэж ослын үед хүмүүс ашиглахад зориулан зохион бүтээсэн шүхрийн иж бүрдлийг;

Осол / Accident гэж хүнтэй агаарын хөлгийн хувьд аливаа этгээд нислэгт оролцох зорилготойгоор агаарын хөлөгт орсноос эхлэн тухайн этгээд түүнийг орхин гарах хүртэлх цаг хугацаа, эсхүл хүнгүй агаарын хөлгийн хувьд нислэг үйлдэхээр хөдлөхөд бэлэн болсноос эхлэн тухайн нислэг дуусаж, үндсэн татах хүчний системийг унтраах хүртэлх цаг хугацааны хооронд агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой гарсан дараах хэрэг явдлыг:

- (1) аливаа этгээд дараах тохиолдолд амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтсэн:
 - (i) агаарын хөлөгт байх үедээ; эсхүл
 - (ii) агаарын хөлгөөс салсан эд ангийг оролцуулан агаарын хөлгийн эд ангийн шууд нөлөөллөөс; эсхүл
 - (iii) тийрэлтэт хөдөлгүүрийн хийн урсгалын шууд нөлөөллөөс; үүнд ердийн шалтгаанаас үүдэлтэй гэмтэл, өөрийгөө гэмтээсэн, эсхүл бусад этгээд гэмтээсэн, эсхүл хөлгийн баг болон зорчигчид зориулсан бүхээгийн хэсгийн гадна нуугдан зорчиж байх үед авсан гэмтэл хамаарахгүй; эсхүл
- (2) агаарын хөлөг дараах гэмтэл, эсхүл бүтцийн эвдрэлд өртөх:
 - (i) тухайн агаарын хөлгийн бүтцийн бөх бат чанар, техникийн, эсхүл нислэгийн үзүүлэлтэд аюултай нөлөөлөх;
 - (ii) ихэвчлэн гэмтсэн бүрдэл хэсгийг солих, эсхүл том засвар хийхийг шаарддаг, үүнд хөдөлгүүрийн татгалзал, эсхүл тухайн гэмтэл нь С-хаалт, эсхүл туслах эд ангийг багтаасан ганц хөдөлгүүр, сэнс, далавчны үзүүр, антен, хүлээн авагч (probes), хаалт (vanes), дугуйн хаймар, тормоз, дугуй, бүрээс, нээлхий, газардах ангийн хаалга, салхины шил болон агаарын хөлгийн гадаргуугийн жижиг хонхойлт, эсхүл цооролтоор хязгаарлагдсан гэмтэл, эсхүл үндсэн роторын алга, сүүлний роторын алга, газардах анги болон мөндөр, эсхүл шувуутай мөргөлдсөнөөс үүссэн radome-ийн нүхийг багтаасан бусад жижиг гэмтэл хамаарахгүй; эсхүл
- (3) агаарын хөлөг сураггүй алга болох, эсхүл хүрэх боломжгүй болох.

Өдөр / Day гэж үүрийн гэгээ эхлэхээс үдшийн бүрий дуусах хүртэлх хугацааг:

- (1) үүрийн гэгээ нь ургаж байгаа нарны голч тэнгэрийн хаяанаас 6° доор буюу нар мандахаас 30 минутын өмнө эхэлнэ.
- (2) үдшийн бүрий нь жаргаж байгаа нарны голч тэнгэрийн хаяанаас 6° доор буюу нар жаргаснаас хойш 30 минутын дараа дуусна.

Өехийн буулт / Belly landing гэж агаарын хөлөг газардах ангиа буулгалгүй, их биеийн доод хэсгээрээ гулган үйлдэх ослын буултыг;

Өмчлөгч / Owner гэж агаарын хөлгийн хувьд, агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмшиж байгаа этгээдийг;

Өндөр / Height гэж тусгайлан тогтоосон эхлэлийн цэгээс хэмжсэн бөгөөд тухайн байгууламжийн босоо хэмжээг багтаасан, түвшин, цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зайг;

Өндөр алдах минимум өндөр (MDH) / Minimum descent height гэж нарийвчлалтай бус ойртолтын, эсхүл тойргоор ойртолт үйлдэх /circling approach/ үед ил харааны баримжаагүйгээр өндөр алдаж болохгүй, ХБЗ-ны босготой харьцуулан тогтоосон өндрийг;

Өндөр алдах минимум өндрийн-түвшин (MDA) / Minimum descent altitude гэж нарийвчлалтай бус ойртолтын, эсхүл тойргоор ойртолт үйлдэх /circling approach/ үед ил харааны баримжаагүйгээр өндөр алдаж болохгүй, далайн дундаж түвшинд харьцуулан тогтоосон өндрийн-түвшнийг;

Өндөр эрсдэлтэй нислэг / High risk flight гэж заналхийллийн ердийн хүчин зүйлээс илүү өндөр нөлөөнд өртөнө гэж дараах этгээдийн үнэлсэн нислэгийг:

- (1) Дарга; эсхүл
- (2) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч; эсхүл
- (3) тухайн агаарын хөлгийг Бүртгэгч улс;

Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс / Security enhanced area гэж Дарга Хууль болон ИНД-140-ийн дагуу өндөржүүлсэн хамгаалалттай байхаар тогтоосон талбайг;

Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн үзлэгийн цэг / Security enhanced area screening point гэж аэродромын үйл ажиллагаа эрхлэгч ИНД-139.203(d)(4A)-ийн дагуу, аюулгүйн үзлэг болон шалгалт хийгдэх өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн цэгт аюулгүйн үзлэг болон шалгалт хийхэд зориулан гаргасан талбайг;

Өндөрлөг / Elevation гэж далайн дундаж түвшнээс хэмжсэн, газрын гадаргуу дээр, эсхүл түүнд бэхэлсэн цэгийн, эсхүл түвшний босоо зайг;

Өндрийн-түвшин / Altitude гэж далайн дундаж түвшнээс хэмжсэн, түвшин, цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зайг;

Өндрийн-түвшний даралт (PA) / Pressure altitude гэж тухайн стандарт атмосферийн даралтад тохирсон, өндрийн-түвшний утгаар илэрхийлдэг атмосферийн даралтыг;

Параглайдер / Paraglider гэж хатуу эд ангиас бүрдсэн үндсэн бүтэцгүй ханглайдерыг;

Парасэйл / Parasail гэж ихэвчлэн задгай, дугуй шүхэр хэлбэртэй, моторт завь, эсхүл тээврийн хэрэгслийн араас аргамжин чирч, хүн, эсхүл хүмүүсийг тээвэрлэн нислэгт хөөргөдөг агаараас хүнд нисдэг төхөөрөмжийг;

Пуужин / Rocket гэж өөрийн тийрэлтэт хүч үүсгэхэд шаардлагатай бүх бодисыг өөртөө агуулсан системээр түлхэгдэж хөөрдөг, дараахаас бусад нисгэгчгүй тээврийн хэрэгслийг:

- (1) тэнгэрийн галын наадам (салют); эсхүл
- (2) нийт 20 Ньютон-секундээс ихгүй тийрэлтийн хүчтэй, A-D хэмжээтэй пуужингийн загварын мотороор түлхэгдэж хөөрдөг пуужин;

PBN (Үзүүлэлтэд суурилсан навигаци) / PBN (Performance-Based Navigation) гэж хэрэглэлээр ойртолт үйлдэх журамд, эсхүл тогтоосон агаарын зайд, НХҮ-тэй нислэгийн замд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт зориулсан, үзүүлэлтийн шаардлагад суурилсан бүсийн навигацийг (PBN зам, эсхүл PBN үйл ажиллагаа нь ижил утгатай);

Радио нэвтрүүлэг / Broadcast гэж бүх станц хүлээн авахад зориулсан дамжуулалтыг;

Ротор-хөлөг / Rotorcraft гэж 1, эсхүл түүнээс олон ротор, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр нислэг үйлддэг хөдөлгүүртэй агаараас хүнд агаарын хөлгийг;

RAIM (хүлээн авагчийн бүрэн байдлын бие даасан мониторинг) / RAIM (receiver autonomous integrity monitoring) гэж нислэгийн тухайн үе шатанд TSO-ын GPS-ийн байршлын тохирлын үзүүлэлтийн шаардлагаас хэтэрсэн байршлын алдааг илрүүлэх нислэгийн GPS-хүлээн авагч/процессорын ажиллагааг. Энэ нь шаардлагатай үед ил харагдах, болон/эсхүл анхааруулах дуут дохио өгнө;

RAIM Анхааруулга (RAIM хангалтгүй мэдээ) / RAIM Warning (RAIM not available message) гэж GPS хиймэл дагуулаас авсан навигацийн байршлын заалтын тохирлыг найдваргүй болохыг анхааруулах дохиог;

RNP (Навигацийн шаардлагатай үзүүлэлт) / RNP (Required navigation performance) гэж тусгайлан тогтоосон агаарын зайд нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхэд шаардлагатай навигацийн үзүүлэлтийн нарийвчлалын тодорхойлолт;

RNP төрөл / RNP type гэж тухайн төлөвлөсөн байршлаас нислэг үргэлжлэх нийт хугацааны 95%-аас доошгүй хувьд нисэн хүрч болох зайг далайн милээр (NM) илэрхийлсэн тоон утгыг;

Саадаас чөлөөтэй талбай / Clearway гэж дээгүүр нь нисэх онгоц тогтоосон өндрөө авах хүртэл өндөр авалтын эхний үе шатыг (initial climb) гүйцэтгэхэд тохиромжтой байхаар сонгосон, эсхүл бэлтгэсэн, ХБЗ-ны нисэн гарах төгсгөлд байгаа хуурай газар, эсхүл усан дээр тогтоосон тэгш өнцөгт дараах талбайг:

- (1) аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн хяналтад байдаг; эсхүл
- (2) тухайн талбайг хянаж байгаа холбогдох эрх бүхий байгууллагатай тохирсон;

Саадыг хязгаарлах гадаргуу / Obstacle limitation surface гэж аэродромын үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэх, аэродромын эргэн тойрны саадын өсөлтийн улмаас тухайн аэродромыг ашиглах боломжгүй болохоос сэргийлэх зорилгоор аэродромын эргэн тойронд тусгайлан тогтоосон агаарын зайг;

Савлах / Packing гэж эд зүйл, эсхүл бодисыг ороож хайрцаглах, баглаа боодлын иж бүрдэлд хийж битүүмжлэх, эсхүл бусад хэлбэрээр аюулгүй болгох чадвар болон үйл ажиллагааг;

Сайд / Minister гэж Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийг;

Синтетик нислэгийн дадлагажуур / Synthetic flight trainer гэж газарт нислэгийн нөхцөлийг дуурайлган бүрдүүлдэг дараах 3 төхөөрөмжийн аль нэгийг:

- (1) *нислэгийн симулятор*: агаарын хөлгийн механик, цахилгаан, электрон гэх мэт системийн удирдлага, нисэх багийн гишүүний үйл ажиллагааны хэвийн орчин болон тухайн маягийн агаарын хөлгийн үзүүлэлт, нислэгийн өгөгдөхүүнийг бодитоор дуурайлган үзүүлэх зорилгоор тодорхой маягийн агаарын хөлгийн нислэгийн бүхээгийн үнэн зөв, бодит орчинг бүрдүүлдэг төхөөрөмж;
- (2) *нислэгийн журмын дадлагажуур*: хэрэглэлийн заалт, агаарын хөлгийн механик, цахилгаан, электрон гэх мэт системийн хялбаршуулсан удирдлага болон тодорхой ангиллын агаарын хөлгийн үзүүлэлт, нислэгийн өгөгдөхүүнийг дуурайлган үзүүлж, нислэгийн бүхээгийн бодит байдалд ойрхон орчинг бүрдүүлдэг төхөөрөмж;
- (3) *суурь хэрэглэлийн нислэгийн дадлагажуур*: хэрэглэлийн нислэгийн нөхцөлд нисэж байгаа агаарын хөлгийн нислэгийн бүхээгийн орчинг дуурайлган, зохих хэрэглэлээр тоногдсон төхөөрөмж;

Сонирхогч-зохион бүтээгч / Amateur constructor гэж агаарын хөлгийг зөвхөн өөрийн боловсрол, эсхүл амралт зугаанд зориулан бүтээсэн зохион бүтээгч этгээдийг;

Сонирхогчийн бүтээсэн агаарын хөлөг / Amateur built aircraft гэж ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу тусгай категорийн сонирхогчийн бүтээсэн НТЧ-ын гэрчилгээ олгох боломжтой агаарын хөлөг болон дараах:

- (1) агаарын хөлгийн сонирхогч-зохион бүтээгч нь өөрийн мэдлэг боловсрол, эсхүл амралт зугаанд зориулан тухайн агаарын хөлгийн ихэнх хэсгийг бүтээсэн агаарын хөлгийг; эсхүл
- (2) туршилтын спортын хөнгөн агаарын хөлөг гэж үйлдвэрлэгч нь тогтоосон спортын хөнгөн агаарын хөлгийг;

Спортын хөнгөн агаарын хөлөг / Light Sport Aircraft гэж нисдэг тэрэгнээс бусад дараах агаарын хөлгийг:

- (1) хөөрөлтийн максимум жин нь:
 - (i) 600 кг, эсхүл түүнээс бага;
 - (ii) усан дээрх үйл ажиллагааны хувьд, 650 кг;
- (2) агаараас хөнгөн агаарын хөлгийн хувьд, 600 кг, эсхүл түүнээс бага максимум нийт жинтэй;
- (3) хэрэв хөдөлгүүртэй бол, ганц турбинт-бус, сэнст-хөдөлгүүртэй;
- (4) 45 knot максимум хурдны нурултын хурдтай;
- (5) хэрэв глайдер бол, 135 knot максимум хэзээ ч хэтэрч болохгүй хурдтай (V_{NE});
- (6) хэрэв хамааралтай бол, битүүмжлэлгүй бүхээгтэй;
- (7) нисгэгчийн суудлыг багтаасан максимум 2 суудлын багтаамжтай;

Стандарт эд анги / Standard part гэж зохион бүтээх, үйлдвэрлэх, таньж тогтоох болон материалын шаардлагыг багтаасан, дараах аль нэг стандартын дагуу нисэхийн тодорхойлолтод нийцсэн нисэхийн бүтээгдэхүүнийг;

- (1) Нисэх Хүчний Нисэхийн Стандарт / Air Force-Navy Aeronautical Standard (AN);
- (2) Америкийн Үндэсний Стандарт / American National Standards Institute (ANSI);
- (3) Австралийн Стандарт / Australian Standards (AS);
- (4) Британийн Стандарт / British Standards, Aircraft Series (BS);
- (5) Европын Стандарт / European Standards (EN);
- (6) Цэргийн Стандарт / Military Standards (MS);
- (7) Цэргийн Тодорхойлолт / Military Specifications (MIL-SPEC);
- (8) Үндэсний Сансрын Стандарт / National Aerospace Standards (NAS);
- (9) Монгол Улсын Стандарт / Mongolian Standards (MNS);
- (10) Оросын Холбооны Улсын Стандарт / Russian Standards (GOST);
- (11) SAE Сансрын Стандарт / SAE Aerospace standard (AS);
- (12) Автомашины Инженерийн Холбоо / Society of Automotive Engineers (SAE);

Сурагч-нисгэгч / Student pilot гэж ИНД-61-ийн дагуу нисгэгчийн үнэмлэх авах зорилгоор сургалт хийж байхдаа, агаарын хөлгийн (хэт хөнгөн агаарын хөлөг, ханг-глайдер, глайдер, моторт-глайдер, эсхүл бөмбөлгөөс бусад) нисгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа, гэхдээ ИНД-61-ийн дагуу хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшдэггүй этгээдийг;

Сурагч-шүхэрчин / Student parachutist гэж шүхрийн байгууллагын үйл ажиллагааны зааварт сурагч-шүхэрчин гэж тодорхойлсон этгээдийг;

Сэдэв / Curriculum гэж мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийн, дараах нэгээс доошгүй хөтөлбөрийг хамарсан хэсгийг:

- (1) үзэл баримтлалын; эсхүл
- (2) нисэх онгоцны тусгай хийц, загвар, сери, эсхүл вариант болон тодорхой ажил үүрэг гүйцэтгэх албан тушаалд шаарддаг тухайн сургалт болон мэргэшлийн ажиллагаанд чиглэсэн мэргэшүүлэх; эсхүл
- (3) нисэх онгоцны тусгай хийц, загвар, сери, эсхүл вариант болон тодорхой ажил үүрэг гүйцэтгэх албан тушаалд шаарддаг тухайн сургалт болон мэргэшлийн ажиллагаанд чиглэсэн мэргэшил хадгалах;

Сэнс / Propeller гэж хөдөлгүүрийн хөтлөгч голд бэхлэгдсэн алгануудтай ба эргэж байхдаа агаартай харилцан үйлчилснээр эргэлтийн талбайд перпендикуляр татах хүч үүсгэж агаарын хөлгийг хөдөлгөдөг хэрэгслийг; Сэнсэнд, ихэвчлэн үйлдвэрлэгчээс хангадаг удирдлагын бүрдэл хэсэг багтах боловч хөдөлгүүрийн үндсэн болон туслах ротор, эсхүл эргэлдэгч хүрз (airfoils) багтахгүй.

Сэтгэцэд нөлөөлөх бодис / Psychoactive substances гэж согтууруулах ундаа, опиоид, каннионид, тайвшруулах, нойрсуулах, кокаин, бусад сэтгэцийн идэвхжүүлэгч, галлюциноген болон дэгдэмхий уусмалыг; гэхдээ тамхи болон кофе эдгээрт хамаарахгүй.

CAT I нарийвчлалтай ойртолт үйлдэх журам / Category I precision approach procedure гэж шийдвэр гаргах өндөр (DH) 60 м-ээс (200 ft) доошгүй ба хараа 800 м-ээс багагүй, эсхүл ХБЗ-ны ил харааны зай 550 м-ээс багагүй байх аль ч нөхцөлд хэрэглэлээр үйлдэх нарийвчлалтай ойртолт болон буултыг;

CAT II нарийвчлалтай ойртолт үйлдэх журам / Category II precision approach procedure гэж шийдвэр гаргах өндөр (DH) 60 м-ээс (200 ft) доош, гэхдээ 30 м-ээс (100 ft) доошгүй ба ХБЗ-ны ил харааны зай 300 м-ээс багагүй байхад хэрэглэлээр үйлдэх нарийвчлалтай ойртолт болон буултыг;

CAT III нарийвчлалтай ойртолт үйлдэх журам / Category III precision approach procedure гэж дараах аль нэг хэрэглэлээр үйлдэх нарийвчлалтай ойртолт болон буултыг:

- (1) CAT IIIA: дараах нөхцөлд хэрэглэлээр үйлдэх нарийвчлалтай ойртолт болон буулт:
 - (i) шийдвэр гаргах өндөр (DH) 30 м-ээс (100 ft) доош, эсхүл шийдвэр гаргах өндөр (DH) заагаагүй;
 - (ii) ХБЗ-ны ил харааны зай 175 м-ээс багагүй;
- (2) CAT IIIB: дараах нөхцөлд хэрэглэлээр үйлдэх нарийвчлалтай ойртолт болон буулт:
 - (i) шийдвэр гаргах өндөр (DH) 15 м-ээс (50 ft) бага, эсхүл шийдвэр гаргах өндөр (DH) заагаагүй;
 - (ii) ХБЗ-ны ил харааны зай 175 м-ээс бага, гэхдээ 50 м-ээс багагүй;
- (3) CAT IIIC: шийдвэр гаргах өндөр (DH) болон ХБЗ-ны ил харааны зай хязгаарлалт заагаагүй нөхцөлд хэрэглэлээр үйлдэх нарийвчлалтай ойртолт болон буулт;

SARTIME гэж аюулын дохио мэдээлэх арга хэмжээг эхлүүлэх зорилгоор нисгэгчийн тогтоосон цагийг;

SEIFR-зорчигч тээврийн үйл ажиллагаа / SEIFR passenger operation гэж ганц-хөдөлгүүртэй нисэх онгоцоор, IFR-ийн дагуу зорчигч тээвэрлэх агаарын тээврийн үйл ажиллагааг;

SIGMET мэдээлэл / SIGMET information гэж агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй, тухайн нислэгийн замын дагуу ажиглагдсан, эсхүл үүсэж болно гэж таамагласан цаг агаарын аюултай үзэгдлийн талаар цаг уурын албанаас гаргадаг мэдээллийг;

Тандем-зорчигч / Tandem rider гэж тандем бэхэлгээний системийн хоёрдогч бэхэлгээг ашиглан тандем-шүхрийн буултад оролцож байгаа этгээдийг;

Тандем-мастер / Tandem master гэж тандем-шүхрийн буултын шууд удирдлагыг гүйцэтгэдэг этгээдийг;

Тандем-хос / Tandem pair гэж тандем-мастер болон тандем-зорчигчийг;

Тандем-шүхрийн буулт / Tandem parachute descent гэж нийтлэг тандем-шүхрийн иж бүрдлээр хийх тандем хосын шүхрийн буултыг;

Татах хүчний систем / Propulsion system гэж хүчилсэн бүтцэд суурилуулсан хөдөлгүүрийн гаргах татах хүч, эсхүл чадлыг хангах, хянах болон удирдах зорилгоор хэрэглэдэг холбогдох хэсгийг багтаасан төхөөрөмж болон хөдөлгүүрийг;

TACAN гэж UHF тактикийн агаарын навигацийн туслах төхөөрөмжийг;

TALPA журам / TALPA procedures гэж:

- (1) ХБЗ-ны нөхцөлд үнэлгээ өгөх ба буулт үйлдэхэд шаардлагатай ХБЗ-ны уртыг тодорхойлох зорилгоор FAA боловсруулсан стандартчилсан ойртолт үйлдэх журмыг;
- (2) агаарын хөлөг үйлдвэрлэгчээс хангадаг техникийн үзүүлэлтийн өгөгдлийн хэрэглээг багтаасан;
- (3) агаарын хөлөг үйлдвэрлэгч дагаж мөрддөг, эсхүл нэмэлт өөрчлөлт оруулсан энэ зүйлийн (1)-д заасан стандартчилсан ойртолтыг багтаасан;

Техник үйлчилгээ / Maintenance гэж агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл тэдгээрийн эд ангийн НТЧ-ын хадгалалтыг бататгахад шаардлагатай, их засвар, эд анги үзлэг шалгалт, солилт, дутагдал арилгах болон модификаци, эсхүл засварын нэг, эсхүл хэд хэдэн ажлыг багтаасан агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл тэдгээрийн эд ангид хийж гүйцэтгэх ажлыг;

Техник үйлчилгээний бүртгэлийн дэвтэр / Maintenance logbook гэж:

- (1) дараах бүртгэлийн дэвтрийг:
 - (i) САА 2101 Агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэр;
 - (ii) САА 2110 Сэнсний бүртгэлийн дэвтэр;
 - (iii) САА 2158 Хөдөлгүүрийн бүртгэлийн дэвтэр;
 - (iv) САА 1464 Агаарын хөлгийн НТЧ-ын удирдамж, Агаарын хөлгийн модификаци, Хөдөлгүүр болон Сэнсний суурилуулалтын бүртгэлийн дэвтэр; эсхүл
- (2) дараах бусад баримт бичгийг:
 - (i) Даргын хүлээн зөвшөөрөхүйц;
 - (ii) агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээний статусын бүртгэлийг агуулсан;

Техник үйлчилгээний заавар / Maintenance manual гэж тухайн агаарын хөлгийг НТЧ-тай гэж тооцож болох хязгаарлалтын хүрээ болон тухайн агаарын хөлөг нь нислэгт тэнцэх нөхцөлд байгааг бататгахад шаардлагатай зааварчилгаа болон мэдээллийг агуулсан, батлагдсан зааврыг;

Техникийн бүртгэлийн дэвтэр / Technical log гэж ИНД-91.619-ийн дагуу холбогдох агаарын хөлөг бүрд шаарддаг техникийн бүртгэлийг;

Техникийн Зааварчилгаа / Technical Instructions гэж Annex 18-ын дагуу ICAO-гийн Зөвлөлийн шийдвэрээр батлагдаж, хэвлэгдсэн, ICAO Doc 9284 “Technical Instructions for the Safe Transport of Dangerous Goods by Air”-г;

Техникийн зохицуулалт / Technical arrangement гэж нэг улсад хийсэн агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээг нөгөө улс нь гэрээний нөхцөлийн дагуу зөвшөөрөх зорилгоор агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт, техник үйлчилгээний стандарт болон баримт бичиг, хувь хүний үнэмлэх, гэрчилгээг харилцан зөвшөөрөх Монгол Улс болон бусад улсын хооронд байгуулсан зохицуулалтыг;

Техникийн өгөгдөл / Technical data гэж ИНД-21-ийн дагуу бүтээгдэхүүний гэрчилгээжүүлэлт, зөвшөөрөл болон эрх олгох, эсхүл ИНД-43-ын дагуу бүтээгдэхүүн, түүний бүрдэл хэсэг болон хэрэгслийн техник үйлчилгээ, модификаци болон засварт ашиглах шаардлагатай зураг, зааварчилгаа, эсхүл шаардлагатай бусад өгөгдлийг;

Техникийн үзүүлэлт муудах зөвшөөрөгдөх хэмжээ / Performance deterioration allowance гэж тухайн нисэх онгоц үйлдвэрлэгчийн гаргасан, түлшний зарцуулалтын тоон хэмжээ болон тодорхой нисэх онгоцонд хамаарах түлшний бодит зарцуулалтын хоорондын зөрүүг;

Техникийн эрсдэлтэй үзүүлэлт / Critical performance parameter гэж нисэхийн байгууламжийн үйл ажиллагааны бүрэн ажиллагаатай байдалд шууд нөлөөлдөг техникийн үзүүлэлтийг;

ТЕМРО гэж:

- (a) TAF-д ашиглаж байгаа тохиолдолд, заасан утгад хүрсэн, эсхүл түүнээс давсан ба тухайн тохиолдол бүрийн үргэлжлэх хугацаа нь 1 цагаас бага байх ба тухайн нийт хэлбэлзлийн ажиглагдах хүрээ нь урьдчилсан мэдээнд өгсөн хугацааны хагасаас бага байх цаг уурын нөхцөлийн урьдчилсан мэдээний түр зуурын хэлбэлзлийн тодорхойлолтыг; эсхүл
- (b) TREND-д ашиглаж байгаа тохиолдолд, заасан босго утгад хүрсэн, эсхүл түүнээс давсан ба тухайн тохиолдол бүрийн үргэлжлэх хугацаа нь 1 цагаас бага байх цаг уурын нөхцөлийн урьдчилсан мэдээний түр зуурын хэлбэлзлийн тодорхойлолтыг. Ийм хэлбэлзлийг METAR, SPECI, эсхүл AUTO METAR-ийг гаргасан хугацаанаас хойш 2 цагийн турш ажиглагдах ба METAR, SPECI, эсхүл AUTO METAR-д анх мэдээлсэн нөхцөлөөс давамгайлсан нөхцөл үе үе үүснэ гэж таамагласан;

Тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээ / Regular air transport passenger service гэж үйл ажиллагаа эрхлэгч, аливаа үргэлжилсэн 28 хоногийн дотор 4-өөс доошгүй удаа, хоёр, эсхүл түүнээс дээш аэродромын хооронд зорчигч тээвэрлэхээр санал болгож байгаа агаарын тээврийн үйл ажиллагааг;

Тогтмол агаарын тээврийн үйлчилгээ / Regular air transport service гэж үйл ажиллагаа эрхлэгч, аливаа үргэлжилсэн 28 хоногийн дотор 4-өөс доошгүй удаа, хоёр, эсхүл түүнээс олон аэродромын хооронд гүйцэтгэж байгаа агаарын тээврийн үйл ажиллагааг;

Тогтмол илгээгч / Regular shipper гэж дараах этгээдийг:

- (1) аюултай бараа үйлдвэрлэдэг, эсхүл ханган нийлүүлдэг ба тэдгээр аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгодог; эсхүл
- (2) аюултай барааг агаараар тээвэрлэх үйлчилгээг олон нийтэд санал болгож, зохицуулдаг;

Том загвар пуужин / Large model rocket гэж дараах пуужинг:

- (1) 25 гр-аас их, гэхдээ 125 гр-аас ихгүй шатагч түлш хэрэглэдэг;
- (2) 20 Ньютон-секундээс их, гэхдээ 320 Ньютон-секундээс ихгүй нийт түлхэлтийн хүч үүсгэдэг;
- (3) удаан шаталттай шатагч түлш хэрэглэдэг;
- (4) цаас, мод, резин, хуванцар зэрэг хөнгөн жинтэй материалаар хийсэн;
- (5) металлаар хийсэн конус хошуу, тэнцвэржүүлэгч, эсхүл металл их биегүй;
- (6) нийт жин нь шатагч түлшний хамт 453 гр-аас их, гэхдээ 1.5 кг-аас ихгүй;

Том засвар / Major repair гэж хэрэгжүүлэлтийн үр дүнгээс шалтгаалан агаарын хөлөг, эсхүл түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд нөлөөлөх боломжтой дараах 1, эсхүл түүнээс олон зөрчилд хүргэж болох том хэмжээний засварыг:

- (1) бүтцийн эвдрэл;
- (2) удирдлага алдагдах;
- (3) эх үүсвэрийн татгалзал;
- (4) агаарын хөлгийн аюулгүй байдал, эсхүл үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай систем, эсхүл төхөөрөмж санамсаргүй ажиллах, эсхүл ажиллах чадваргүй болох;
- (5) бүхээгт байгаа хүмүүсийг ажил үүргээ гүйцэтгэх чадварыг алдуулах гэмтэл;
- (6) хүлээн зөвшөөрөгдөхөөргүй байдлаар ажиллагаагүй, эсхүл ашиглах боломжгүй болох;

Том модификаци / Major modification гэж хэрэгжүүлэлтийн үр дүнгээс шалтгаалан агаарын хөлөг, эсхүл түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд нөлөөлөх боломжтой, дараах 1, эсхүл түүнээс олон зөрчилд хүргэж болох том хэмжээний модификацийг:

- (1) бүтцийн эвдрэл;
- (2) удирдлага алдагдах;
- (3) эх үүсвэрийн татгалзал;
- (4) агаарын хөлгийн аюулгүй байдал, эсхүл үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай систем, эсхүл төхөөрөмж санамсаргүй ажиллах, эсхүл ажиллах чадваргүй болох;
- (5) бүхээгт байгаа хүмүүсийг ажил үүргээ гүйцэтгэх чадварыг алдуулах гэмтэл;
- (6) хүлээн зөвшөөрөгдөхөөргүй байдлаар ажиллагаагүй, эсхүл ашиглах боломжгүй болох;

Тохиромжтой аэродром / Adequate aerodrome гэж тухайн ашиглаж байгаа нисэх онгоцны хувьд, ИНД-121.71-д заасан аэродромын болон ХБЗ-ны холбогдох шаардлагыг хангасан байхаас гадна, хэрэв тухайн аэродромыг нислэгийн замын дагуух бэлтгэл аэродром байхаар сонгосон бол аврах болон гал унтраах төхөөрөмж нь категори 4-өөс доошгүй байх ёстой ба тухайн нисэх онгоц нисэн ирэх баримжаат цагаас 30-аас доошгүй минутын өмнө урьдчилан мэдэгдсэн тохиолдолд ашиглахад бэлэн байх ёстой аэродромыг;

Тохирох / Appropriate гэж нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хувьд, ижил категорийн агаарын хөлөгт хамааралтай байхыг;

Тохирох зөв хүн / Fit and proper person гэж тохирох зөв хүний шалгуурыг хангасан этгээдийг;

Төлбөрт ачааллын багтаамж / Payload capacity гэж:

- (1) MZFW заагаагүй бол, MCTOW-ээс хоосон жин, агаарын хөлгийн зайлшгүй шаардлагатай төхөөрөмжийн жин болон дараах жингээс бүрдсэн үйл ажиллагааны ачааллыг хасаж тооцсон жинг:
 - (i) VFR-ийн цаг агаарын нөхцөлд, 322 км (174 nm)-ээс хол зайтай орон нутгийн нисэх буудлуудын хоорондох нислэгт ИНД-ийн дагуу шаарддаг тухайн түлшний минимум жин;
 - (ii) TCDS-д заасан тосны максимум багтаамж, эсхүл 160 кг тосны аль бага жин;
 - (iii) шаардлагатай нисэх багийн гишүүн бүрийг 91 кг-аар;
 - (iv) шаардлагатай катерингийн хангалт; эсхүл
- (2) MZFW заасан бол, MZFW-ээс хэрэглэх түлш, тосноос бусад хоосон жин болон дараах жингээс бүрдсэн ачааллыг хасаж тооцсон жинг:
 - (i) агаарын хөлгийн зайлшгүй шаардлагатай төхөөрөмжийн жин болон үйл ажиллагааны ачааллын жин;
 - (ii) минимум нисэх багийн гишүүн бүрийг 91 кг-аар;
 - (iii) шаардлагатай катерингийн хангалт;

Төөрсөн агаарын хөлөг / Strayed aircraft гэж төлөвлөсөн зам, эсхүл мэдээнээс их хэмжээгээр хазайж, холбоо тасарсан агаарын хөлгийг;

Төсөөтэй олон систем / Multiple identical system гэж төсөөтэй системийн ижил элемент, гэхдээ EDTO нислэгт нөлөөлөх системээс тусдаа;

Төсөөтэй олон системийн техник үйлчилгээ / Multiple identical system maintenance гэж 2 турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, төсөөтэй олон системд хуваарьт, эсхүл хуваарьт бус техник үйлчилгээний үед, ижил цаг хугацаанд хийсэн техник үйлчилгээг;

Туйлын бүс / Polar area гэж хойд өргөргийн 78°-аас хойш, эсхүл өмнөд өргөргийн 60°-аас урагш газар зүйн бүсийг;

Тунадастай / Contaminated гэж ХБЗ-ны хувьд, хэрэглэхэд шаардлагатай ХБЗ-ны урт болон өргөний 25%-иас дээш гадаргуу нь ус, шавар шалбааг, эсхүл 3 мм-ээс дээш зузаантай зөөлөн цасаар хучигдсан, эсхүл гадаргуугийн аливаа хэсэг нь мөстсөн ХБЗ-ыг;

Турбинт-хөдөлгүүртэй / Turbine powered гэж турбо-жэт, эсхүл турбо-фэн, эсхүл турбо-проп, эсхүл турбо-голт хөдөлгүүрийг;

Турбо-голт / Turboshaft гэж илүүдэл хийн урсгалын энергийг хөдөлгүүрийн голыг эргүүлэхэд ашигладаг хийн турбинт хөдөлгүүрийг;

Турбо-жэт / Turbojet гэж илүүдэл хийн урсгалын энергийг шууд татах хүч болгон ашигладаг хийн турбинт хөдөлгүүрийг;

Турбо-проп / Turboprop гэж илүүдэл хийн урсгалын энергийг сэнс эргүүлэхэд ашигладаг хийн турбинт хөдөлгүүрийг;

Турбо-фэн / Turbofan гэж турбо-жэт хөдөлгүүрийн дотоод контураас үүсэх хийн урсгалын илүүдэл энергийг ашиглан компрессорыг эргүүлж, хөдөлгүүрийн дотоод контурын гадуурх агаарын урсгалын энергийг нэмэлт татах хүч болгон ашигладаг хөдөлгүүрийг;

Тусгай VFR нислэг / Special VFR flight гэж НХУ-ын нэгжээс VMC-ээс бага цаг уурын нөхцөлд, удирдлагын зоонд үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрсөн VFR нислэгийг;

Тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаа / Special operation гэж агаараар зорчигч, эсхүл барааг хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх дараах үйл ажиллагааг:

(1) үүнд:

- (i) зорчигч бүр нь тухайн үйл ажиллагаанд тодорхой ажил, эсхүл үүрэг гүйцэтгэж байгаа, эсхүл ажил, үүрэг гүйцэтгэх сургалт хийж байгаа; эсхүл
- (ii) бөглүү аэродромоос, эсхүл бөглүү аэродром руу зорчигч, эсхүл бараа тээвэрлэж байгаа;

(2) (1)-д зааснаас бусад дараах үйл ажиллагаа:

- (i) ИНД-133-ын дагуу гүйцэтгэдэг нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа; эсхүл
- (ii) ИНД-137-гийн дагуу гүйцэтгэдэг хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

Тухайн байрлалын газрын түвшин / Ground level at its site гэж тухайн байрлалын эргэн тойрон 600 м радиус доторх хамгийн өндөр газрыг;

Түвшин / Level нь нисэж байгаа агаарын хөлгийн босоо байршилтай холбоотой өндөр, өндрийн-түвшин, эсхүл нислэгийн түвшнийг илэрхийлдэг олон утгатай ерөнхий ойлголт;

Түгээгдсэн мэдээллийн зөрчил / Promulgated information incident гэж AIP, газрын зураг, схем зураг, эсхүл бусад хэлбэрээр агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулан түгээгдсэн ноцтой алдаатай, бүрэн бус, эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл, эсхүл нисэхийн өгөгдөлтэй холбоотой зөрчлийг;

Түлшгүй максимум жин (MZFW) / Maximum zero fuel weight гэж ашиглагддаггүй түлш, эсхүл тостой агаарын хөлгийн зөвшөөрөгдөхүйц максимум жинг; Түлшгүй жинг агаарын хөлгийн маягийн гэрчилгээний өгөгдлийн хуудас (TCDS), эсхүл зөвшөөрөгдсөн агаарын хөлгийн нислэгийн заавар, эсхүл аль алианаас харж болно.

Тээш / Baggage гэж үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу агаарын хөлөгт тээвэрлэж байгаа, эсхүл тээвэрлэхээр зорьж байгаа зорчигч, эсхүл багийн гишүүдийн хувийн өмч хөрөнгийг;

Удирдлагад оролцох / Manipulation of controls гэж агаарын хөлгийн чиглэл, өндрийн-түвшин, хурд, эсхүл бусад нислэгийн үзүүлэлтийг өөрчлөхөөр нислэгийн жолоодлогод оролцохыг;

Удирдлагын бүс / Control area гэж газар дээр тогтоосон хязгаараас дээш 20 000 м (FL 660) хүртэл үргэлжлэх хяналттай агаарын зайг;

Удирдлагын зоон / Control zone гэж газрын гадаргуугаас дээш тогтоосон хязгаар хүртэл үргэлжлэх хяналттай агаарын зайг;

Удирдлагын систем / Control system гэж нислэгийн удирдлага, хөдөлгүүр болон сэнсний удирдлага, холбогдох бусад системийн удирдлага болон хамааралтай ажиллах механизмын удирдлагыг багтаасан, нислэгийн зам, агаарын хөлгийн байрлал, эсхүл татах хүчийг шууд өөрчлөх чадвартай системийг;

Ур чадвараа амжилттай шалгуулах / Successfully demonstrate competency гэж ИНД-61-ийн О, ОА, ОВ болон ОС Бүлгийн зорилгод нийцүүлэн, зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч, эсхүл зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлийн дагуу зөвшөөрөгдсөн холбогдох үйл ажиллагааг гүйцэтгэх хангалттай мэдлэг болон ур чадвараа шалгуулах зорилгоор мэргэшсэн холбогдох шалгагч-нисгэгч, эсхүл багш-нисгэгчид 61.701, 61.707, 61.711, 61.717, 61.721, 61.727, 61.731 болон 61.737-гийн дагуу аман болон нислэгийн шалгалт өгөхийг;

Усан дээгүүрх үргэлжилсэн нислэгийн үйл ажиллагаа / Extended over-water operation гэж эргээс 93 км (50 nm) зайтай цэгийг агуулсан, төлөвлөсөн нислэгийн замаар гүйцэтгэх нисэх онгоцны үйл ажиллагаа;

Утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар / Control line model aircraft гэж тухайн агаарын хөлгийг нисгэж байгаа этгээд ганц, эсхүл олон утсаар удирддаг, нэг төвтэй тойргоор хязгаарлагдан нисдэг агаарын хөлгийн загварыг;

Үзлэгийн дараах бүс (Аюулгүйн хамгаалалтын хяналттай бүс) / Sterile area (Security restricted area) гэж тухайн бүсэд нэвтрэх хяналт дээр нэмж аюулгүйн хамгаалалтын бусад хяналтыг хийдэг өндөр эрсдэлтэй бүс гэж тогтоосон нисэх буудлын хамгаалалттай бүсийн талбайг; Энэ бүс нь аюулгүйн үзлэгийн цэгээс, нислэгт бэлтгэж агаарын хөлөг болон аюулгүйн үзлэг хийсэн ачаа, тээш байрласан ачааны талбай, шуудангийн төв, хамгаалалттай бүс дэх катеринг болон агаарын хөлгийн цэвэрлэгээний талбайг багтаасан агаарын хөлөг, зогсоол болон тээш бэлтгэх талбай хүртэлх зорчих гудам, бүх арилжааны нислэгийн зорчигчийн явах бүсийг багтаана;

Үзүүлэлт / Specification гэж агаарын хөлөгт ашиглагдаж байгаа эд зүйлийн минимум үзүүлэлтийн стандартыг;

Үйл ажиллагаа эрхлэгч / Operator гэж агаарын хөлгийн үйл ажиллагаанд оролцож байгаа этгээдийг;

Үйл ажиллагаа эрхлэх / Operate гэж агаарын хөлгийн хувьд, тухайн этгээд нь агаарын хөлөгт байх эсэхээс үл шалтгаалан, тухайн агаарын хөлгийг нисгэх, ашиглах, эсхүл тухайн агаарын хөлгийг нисэхийг зөвшөөрөх, эсхүл нисгэхэд хүргэх шалтгаан болохыг; мөн "үйл ажиллагаа эрхлэгч"-ийг дээрх утгаар ойлгоно.

Үйл ажиллагааны бүс / Operational area гэж үйл ажиллагааны бүсийн таних тэмдгээр тогтоосон, эсхүл үйл ажиллагааны байгууламж байрласан бүсийг багтаасан, агаарын хөлгийн хөдөлгөөн, эсхүл маневр хийдэг аэродром дээрх талбайг;

Үйл ажиллагааны нэгж / Operating position гэж 1, эсхүл түүнээс олон нислэгийн хөдөлгөөний удирдагч, эсхүл нислэгийн мэдээллийн ажилтан тогтоосон бүс, эсхүл хариуцлагын бүсэд НХУ-ын үйлчилгээ үзүүлдэг ажлын байрыг;

Үйл ажиллагааны тодорхойлолт / Operations specifications гэж тухайн гэрчилгээний салшгүй хэсэг болох эрх, хязгаарлалт болон журмыг багтаасан, тухайн агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд Даргын тогтоосон нөхцөлийг;

Үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарь / Manufacturer's maintenance schedule гэж тухайн агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнс, ротор, хэрэгсэл, ослын төхөөрөмж болон эд ангийг гэрчилгээжүүлэх эрх бүхий байгууллагаас шаардсаны дагуу үйлдвэрлэгчээс гаргасан Техник үйлчилгээний зааварт, эсхүл НТЧ-ын хадгалалтын зааварчилгаанд заасан хөтөлбөрийг;

Үйлдвэрлэсэн огноо / Date of manufacture гэж бүтээгдэхүүний хувьд, маягийн загварын шаардлага хангасныг харуулсан тухайн бүтээгдэхүүний үзлэг шалгалтын бүртгэлийн он, сар, өдрийг;

Үйлчилгээний агент / Handling agent гэж зорчигч, эсхүл ачааг хүлээн авах, ачих, буулгах, шилжүүлэх, эсхүл бусад ажиллагааг багтаасан, үйл ажиллагаа эрхлэгчийн бүх, эсхүл зарим үйл ажиллагааг түүний өмнөөс гүйцэтгэдэг байгууллагыг;

Үлдэгдэл-нөөц түлш / Final-reserve fuel гэж нисэн очих, эсхүл бэлтгэл, эсхүл тохиромжтой аэродромын ойролцоо төлөвлөгдөөгүй маневр гүйцэтгэх тохиолдолд, нислэгийг аюулгүй гүйцэтгэж дуусгахад шаардлагатай нөөцийг хангадаг, ердийн үед, буулт үйлдэж дуусахад агаарын хөлөгт үлддэг түлшний минимум хэмжээг;

Үндсэн нислэгийн хөдөлгөөн / Essential traffic гэж зайчлал шаарддаг бусад хяналттай нислэгт хамааралтайгаар тогтоосон минима-гаар зайчлаагүй аливаа хяналттай нислэгийн хөдөлгөөнийг;

Үндсэн чиглэлийн агаарын хөлөг / Originating aircraft гэж өмнөх нислэг, эсхүл нислэгүүдийн төгсгөлд зорчигч болон ачаагаа буулгадаг, Монгол Улсын аливаа аэродромоос тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээнд ашиглах агаарын хөлгийг, гэхдээ үүнд байгаа ачаалал дээрээ зорчигч болон ачаа нэмж авсан тохиолдолд ч Монгол Улсыг, эсхүл түүний аль нэг нисэх буудлыг дамжин өнгөрч байгаа агаарын хөлөг багтахгүй.

Үндсэн шүхэр / Main parachute гэж аврах шүхрээс бусад, үндсэн шүхрээр ашиглах зорилгоор зохион бүтээсэн шүхрийг;

Үнэмлэх / Licence гэж:

- (1) ИНД-61, ИНД-63, ИНД-65, ИНД-66, болон ИНД-67-гийн хувьд, Даргын олгосон нисэхийн ажилтны үнэмлэхийг; эсхүл
- (2) ИНД-103, ИНД-104, ИНД-105 болон ИНД-106-гийн хувьд, тухайн зорилгоор Даргын шилжүүлсэн эрх эзэмшигчийн олгосон үнэмлэхийг;

Үнэмлэх эзэмшигч / Licence holder гэж дараах этгээдийг:

- (1) нисэхийн баримт бичиг эзэмшдэг, эсхүл нисгэгч;
- (2) ЭМГ эзэмшдэг, эсхүл эзэмшихийг ИНД-ээр шаардсан;

Үүлний суурийн өндөр / Ceiling гэж газар, эсхүл усан гадаргуугаас дээш, тэнгэрийн хагасаас илүүг бүрхсэн, 6000 м-ээс (20 000 ft) доош өндөртэй, үүлний хамгийн доод давхаргын суурь хүртэлх өндрийг;

Үхлийн аюултай гэмтэл / Fatal injury гэж ослоос хойш 30 хоногийн дотор үхэлд хүргэсэн гэмтлийг;

ХАА-н агаарын хөлгийн арилжааны үйл ажиллагаа / Commercial agricultural aircraft operation гэж хөлс, эсхүл шан урамшуулалтай гүйцэтгэж байгаа хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагааг;

ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа / Agricultural Aircraft Operation гэж дараах зорилгоор, ачаалах талбай болон холбогдох ажлын талбай хоорондын шилжих нислэгийг багтаасан нэг, эсхүл хэд хэдэн нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагааг:

- (1) агаараас шингэн цацах;
- (2) агаараас бордоо цацах;
- (3) агаараас мэрэгчийн хор цацах;
- (4) ХАА-н химийн, эсхүл ХАА, цэцэрлэгжүүлэлт, ой модны хамгаалалтад нөлөөлөх бодис цацах;
- (5) хөдөө орон нутагт малчдад шаардлагатай хангамжийг агаараас хаях, эсхүл шаардлагатай материалыг хүргэх;
- (6) газрын бартаанаас дээш 150 м-ээс (500 ft) доош өндөрт газар тариалан, ой мод, эсхүл усан гадаргуугийн тандалт хийх;
- (7) хөдөө орон нутагт мал, амьтан тээвэрлэх, эсхүл тэжээл хүргэх;
- (8) энэ зүйлийн (1) - (7)-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлын талбайд тандалт хийх;

ХАА-н аэродром / Agricultural aerodrome гэж зөвхөн ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаанд ашигладаг, эсхүл ашиглахад зориулсан, НХУ-ын бүсэд байрлаагүй дараах гэрчилгээжээгүй аэродромыг:

- (1) нисэх онгоцны хувьд:
 - (i) хамгийн ойр байрлах бусад аэродромоос 9 км-ээс (5 nm) багагүй зайд байрладаг;
 - (ii) хамгийн ойр байрлах хэлипортоос 5.6 км-ээс (3 nm) багагүй зайд байрладаг; эсхүл
- (2) нисдэг тэрэгний хувьд:
 - (i) хамгийн ойр байрлах аэродромоос 5.6 км-ээс (3 nm) багагүй зайд байрладаг;
 - (ii) хамгийн ойр байрлах бусад хэлипортоос 1.8 км-ээс (1 nm) багагүй зайд байрладаг;

ХАА-н химийн бодис / Agricultural chemical гэж дараах зориулалттай бодис, эсхүл бодисуудын хольцыг:

- (1) холбогдох эрх бүхий байгууллагаас улсын, эсхүл орон нутгийн хэмжээнд хөдөө аж ахуйн хортон шавьж, эсхүл хортой ургамал гэж зарласан хорхой шавьж, мэрэгч амьтад, хялгасан хорхой, хогийн ургамал, мөөгөнцөр, эсхүл бусад амьтан, ургамлын бусад хэлбэр, эсхүл вирус /хүн, эсхүл амьтны биед байдаг вирусээс бусад/-ээс хамгаалах, устгах, үргээх, эсхүл багасгах; эсхүл
- (2) ургамлын ургалтыг зохицуулагч, устгагч, эсхүл хатаагчаар ашиглах;

Хазайлтыг нөхөх түлш / Contingency fuel гэж дараах тохиолдолд зориулсан түлшийг:

- (1) замын салхи, эсхүл агаарын хэм нь урьдчилсан мэдээнээс зөрүүтэй байх;
- (2) нислэгийн төлөвлөгдсөн зам, өндрийн-түвшин, эсхүл нислэгийн түвшнээс хазайх;
- (3) үйл ажиллагааны хэмнэлттэй горимоос хазайх;

Халхлагдсан үйл ажиллагаа / Shielded operation гэж байгалийн, эсхүл хүний бүтээсэн байгууламжийн оройгоос доош, 100 м дотор хийгдэх агаарын хөлгийн үйл ажиллагааг;

Хамтарсан нислэгийн зааварчилгаа / Dual flight instruction гэж этгээдэд нисгэгчийн суудлаас, зохих ёсоор үнэмлэх болон зэрэглэл эзэмшдэг багш-нисгэгчийн өгдөг нислэгийн зааварчилгааг;

Хамтарсан нислэгийн цаг / Dual flight time гэж тухайн этгээд нь хос удирдлагатай агаарын хөлгийн бүхээгт зохих ёсоор үнэмлэх болон зэрэглэл эзэмшсэн нисгэгчээс нислэгийн зааварчилгаа авч байгаа үеийн нислэгийн цагийг;

Хамтран нисгэгч / Co-pilot гэж хөлгийн даргаас бусад, тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаанд нислэгийн заавраар шаардсан нисгэгчийг; гэхдээ тухайн агаарын хөлгийн бүхээгт байгаа нисгэгчээс нислэгийн зааварчилгаа авч байгаа нисгэгч багтахгүй.

Ханг-глайдер / Hang glider гэж нисгэгч зөвхөн хөлөө ашиглан хөөрч, буудаг моторт-глайдерийг багтаасан глайдерийг, үүнд параглайдер багтана;

Ханг-глайдерын байгууллага / Hang gliding organisation гэж ханг-глайдерын үйл ажиллагаатай холбоотой тухайн эрхийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн, ИНД-149-ийн дагуу олгосон нисэх клубийн гэрчилгээ эзэмшигчийг;

Хараа / Visibility гэж нисэхийн зорилгоор ашигладаг дараах зайны аль ихийг:

- (1) газар дээр байрлуулсан тохиромжтой хэмжээтэй хар биетийг тод гэгээтэй дэвсгэрээс ялгаж харах болон таньж тогтоож чадах хамгийн хол зай;
- (2) 1000 кандел гэрлийн ойролцоо байгаа гэрлийг харанхуй дэвсгэрээс ялгаж харах болон таньж тогтоож чадах хамгийн хол зай;

Харгалзагчтай зорчигч / Escorted passenger гэж агаарын тээврийн үйл ажиллагааны үед томилогдсон харгалзагчийн оролцоо шаарддаг зорчигчийг;

Хариуцлагын бүс / Area of responsibility гэж НХҮ-ний байгууллага, түүний үйл ажиллагааны нэгжийн хариуцсан агаарын зайг (аэродромын бүсийн хувьд маневрын талбайг багтаана);

Хатуу буулт / Hard Landing гэж өндөр алдах хурд, эсхүл ачааллын “g” тоо, эсхүл аль алинаар нь илэрхийлсэн үйлдвэрлэгчийн гаргасан газардалтын хязгаарлалтыг хэтрүүлэн үйлдэх буултыг;

ХБЗ-ны ил харааны зай (RVR) / Runway visual range гэж ХБЗ-ны гадаргуугийн тэмдэглэгээ, эсхүл ХБЗ-г тэмдэглэсэн, эсхүл түүний гол шугамыг харуулсан гэрлийг ХБЗ-ны гол шугам дээр байгаа агаарын хөлгийн нисгэгчийн харж чадах зайг;

ХБЗ-ны талбай / Runway strip гэж ХБЗ болон зогсоох зурвасыг (хэрэв зогсоох зурвас/stopway байгаа бол) багтаасан, дараах зорилгоор тогтоосон талбайг:

- (1) ХБЗ-аас агаарын хөлөг гарах үед үүсэх гэмтлийн эрсдэлийг багасгах;
- (2) хөөрөлт, эсхүл буулт үйлдэх үйл ажиллагааны үед тухайн ХБЗ-ны талбайн дээгүүр нисэж байгаа агаарын хөлгийг саадаас хамгаалах гадаргууг хангах;

ХБЗ-ны төгсгөлийн аюулгүйн талбай (RESA) / Runway end safety area гэж ХБЗ-ны үргэлжилсэн гол шугамтай тэгш хэмтэй ба нисэх онгоц ХБЗ-д дутуу суух, эсхүл даван гүйж гарах үед учрах гэмтлийн эрсдэлийг багасгахад зориулсан ХБЗ-ны талбайн төгсгөлтэй зэрэгцээ байрлах талбайг;

Хоосон жин / Empty weight гэж дараах жинг багтаасан агаарын хөлгийн хоосон жинг:

- (1) агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, хөдөлгүүр, сэнс болон ротор;
- (2) агаарын хөлөгт суурилуулсан төхөөрөмж;
- (3) агаарын хөлөгт суурилуулсан тэнцвэржүүлэх балласт;
- (4) агаарын хөлөгт үлддэг хэрэглэгддэггүй түлш;
- (5) цэвэр ус, жорлонгийн ус болон тухайн агаарын хөлгийн хөдөлгүүрт хүч нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэдэг уснаас бусад, агаарын хөлгийн системийн хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай бүрэн дүүргэсэн шингэн;
- (6) нислэгийн заавар, эсхүл түүний нэмэлт хавсралтын жин, төвлөрөлтийн хэсэгт заасан эд зүйл;

Хөгжлийн бэрхшээлтэй зорчигч / Disabled passenger гэж агаарын тээврийн үйл ажиллагааны үед бие махбод, эрүүл мэнд, эсхүл сэтгэхүйн нөхцөлөөс шалтгаалан ердийн зорчигчоос илүү тусгайлсан анхаарал халамж шаарддаг зорчигчийг;

Хөдөлгөөний урсгал зохицуулалт / Flow control гэж өгөгдсөн агаарын зай, нислэгийн зам, эсхүл аэродромын бүсэд тухайн агаарын зайг хамгийн үр дүнтэй ашиглаж байгааг бататгахын тулд хөдөлгөөний урсгалыг тохируулах зорилгоор авч хэрэгжүүлдэг арга хэмжээг;

Хөдөлгөөнт бүс / Movement area гэж агаарын хөлгийн хөөрөлт болон буулт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд ашиглахад зориулагдсан, маневрын талбай, техник үйлчилгээний талбай болон апроныг багтаасан аэродромын тодорхой хэсгийг;

Хөдөлгүүрийн өгөгдлийг автоматаар бичих систем / Automatic engine data recording system гэж агаарын хөлгийн хөдөлгүүрийн нислэгт тэнцэх нөхцөлтэй холбоотой олон төрлийн үзүүлэлтийг хэмжих тусгай мэдрэгчээс өгөгдөл авч хадгалдаг системийг;

Хөлгийн дарга / Pilot-in-command гэж аливаа агаарын хөлгийн хувьд, тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа болон нислэгийн аюулгүй байдлыг хариуцахаар агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон нисгэгчийг;

Хөлгийн даргын дадлага / Command practice гэж үйл ажиллагаа эрхлэгчээс, тухайн зорилгоор томилсон хөлгийн даргын хяналтын дор, нислэгийн турш хөлгийн даргын ажил, үүргийг гүйцэтгэх хамтран нисгэгчийн гүйцэтгэлийг;

Хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа / Hire or reward operation гэж зорчигч, эсхүл барааг агаараар тээвэрлэх төлбөртэй нислэгийн үйл ажиллагааг;

Хөөрөлтийн боломжит зай / Take-off distance available (TODA) гэж хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зайн (TORA) урт дээр нэмж аливаа саадаас чөлөөтэй талбайн уртыг;

Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зай / Take-off run available (TORA) гэж нисэх онгоцны хөөрөлтийн газрын гүйлтэд ашиглахад тохиромжтой ба боломжтой гэж аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн мэдүүлсэн ХБЗ-ны уртыг;

Хөөрөлтийн гүйлтийг зогсоох боломжит зай / Accelerate-stop distance available (ASDA) гэж хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зайн (TORA) урт дээр нэмж зогсоох зурвасны уртыг;

Хөөрөлтийн жин / Take-off weight гэж хөөрөлтийн гүйлт үйлдэхийн өмнө нисэх онгоцон дээр, эсхүл нисэх онгоцон дотор байгаа бүх зүйл, эсхүл хүмүүсийг багтаасан, хөөрөлтийн гүйлт үйлдэхийн өмнөх тухайн нисэх онгоцны жинг;

Хөөрөлтийн үеийн нислэгийн аюулгүй зам, хөөрөлтийн нислэгийн зам, хөөрөлтийн зай болон хөөрөлтийн гүйлтийн зам / Net take-off flight path, take-off flight path, take-off distance, and take-off run гэж тухайн нисэх онгоцны гэрчилгээжүүлэлтийн дүрэмд заасныг;

Хөөрч, буух зурвас (ХБЗ) / Runway гэж агаарын хөлгийн буулт, хөөрөлтөд зориулан бэлдсэн, газрын аэродром дээр тогтоосон тэгш өнцөгт талбайг;

Хувийн байрлал дохиологч / Personal locator beacon гэж ЭХАТ үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор, өвөрмөц дохиог тогтоосон давтамжаар мэдээлдэг, хувь хүн биедээ авч явахаар бүтээсэн, гараар ажиллуулдаг төхөөрөмжийг;

Хувийн нисэх / General private гэж нисгэгчийн суудлыг оролцуулан 6, эсхүл түүнээс бага суудлын багтаамжтай, 2730 кг-аас (6 000 lbs) бага MCTOW-тэй, агаарын хөлгөөр хувийн нисгэгчийн үнэмлэхний (PPL) эрх хязгаарлалтын хүрээнд AMSL 7500 м-ээс (25,000 ft) доош өндөрт гүйцэтгэдэг нислэгийн үйл ажиллагааг; (зардал хуваахыг зөвшөөрөх боловч, хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагааг хориглоно)

Хууль / Act гэж Иргэний нисэхийн тухай хуулийг;

Хууль бус үйлдэл / Acts of unlawful interference гэж зорчигч, багийн гишүүн, газрын ажилтан, агаарын хөлөг, эсхүл байгууламжид аюул учруулах үйлдэл, эсхүл завдсан үйлдлийг;

Хуурай / Dry гэж ХБЗ-ны хувьд, чийгтэй байсан ч хуурай үеийн үр дүнтэй тормозлох нөхцөлийг хадгалах зорилгоор тусгайлан гаргасан ховилтой, эсхүл сүвэрхэг хучилттай ХБЗ-ыг багтаасан нойтон биш, тунадастай биш ХБЗ-ыг;

Хүнгүй агаарын хөлгийн систем / Unmanned aircraft system гэж бүхээгтээ нисгэгчгүй үйл ажиллагаа гүйцэтгэдэг агаарын хөлөг болон түүний холбогдох элементийг;

Хүнгүй агаарын хөлөг / Unmanned aircraft гэж бүхээгтээ нисгэгчгүй ажиллахаар зохион бүтээсэн бөмбөлөг, утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар, чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар болон зайнаас удирддаг агаарын хөлгийг;

Хүнд гэмтэл / Serious injury гэж ослын улмаас хүнд учирсан дараах гэмтлийг:

- (1) гэмтэл авснаас хойш 7 хоногийн дотор, 48 цагаас дээш хугацаагаар эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай; эсхүл
- (2) хөл, гарын хуруу, эсхүл хамрын ясны жижиг хугарлаас бусад ясны хугаралд хүргэсэн; эсхүл
- (3) биеийн гэмтлээс шалтгаалан цус ихээр алдах, мэдрэлийн судас, булчин, эсхүл шөрмөс хүндээр гэмтэх; эсхүл
- (4) дотоод эрхтний гэмтэл; эсхүл
- (5) II, эсхүл III зэргийн түлэгдэлт, эсхүл их биеийн гадаргуугийн 5%-иас дээш түлэгдэлт; эсхүл
- (6) халдварт бодисын хордлого, эсхүл гэмтэл учруулахуйц төөнөлт;

Хүнд чөлөөт бөмбөлөг / Heavy free balloon гэж дараах чөлөөт бөмбөлгийг:

- (1) ашигт ачаалал тээвэрлэдэг:
 - (i) нийлбэр жин нь 6 кг, эсхүл түүнээс их жинтэй; эсхүл
 - (ii) ашигт ачааллын багц нь 3 кг, эсхүл түүнээс их жинтэй; эсхүл
 - (iii) ашигт ачааллын багц нь 2 кг, эсхүл түүнээс дээш, 13 гр/см²-аас их талбайн нягтралтай;
- (2) ашигт ачааллыг олс, эсхүл бусад хэрэгсэл ашиглан дүүжилдэг, бөмбөлөгт дүүжилсэн тухайн ашигт ачааллыг салгахад 230 Ньютон, эсхүл түүнээс их үйлчлэх хүч шаарддаг;

Хүргүүлсэн нислэгийн төлөвлөгөө / Filed flight plan гэж нисгэгч, эсхүл томилогдсон төлөөлөгчийн НХҮ-ний нэгжид хүргүүлсэн, өөрчлөлт ороогүй нислэгийн төлөвлөгөөг;

Хүчин чадлын Ангилал-1 нисдэг тэрэг / Performance Class 1 helicopter гэж эрсдэлтэй хүчний төхөөрөмж татгалзсан тохиолдолд, татгалзсан тухайн хөөрөлтийн талбайд эргэж буух, эсхүл өөр тохиромжтой буултын талбай хүртэл нислэгийг аюулгүй үргэлжлүүлж чадах техникийн үзүүлэлттэй нисдэг тэргийг;

Хүчин чадлын Ангилал-2 нисдэг тэрэг / Performance Class 2 helicopter гэж хөөрөлтийн дараах тогтоосон цэгийг өнгөрөхөөс өмнө, эсхүл буултын өмнөх тогтоосон цэгийг өнгөрсний дараа хөдөлгүүр татгалзсан үед аргагүйдсэн буулт үйлдэх шаардлагатайгаас бусад тохиолдолд, хөдөлгүүр татгалзсан үед нислэгийг аюулгүй үргэлжлүүлж чадах техникийн үзүүлэлттэй нисдэг тэргийг;

Хүчин чадлын Ангилал-3 нисдэг тэрэг / Performance Class 3 helicopter гэж нислэгийн аль ч үе шатанд хөдөлгүүр татгалзсан тохиолдолд, аргагүйдсэн буулт заавал үйлдэхийг шаарддаг техникийн үзүүлэлттэй нисдэг тэргийг;

Хүчинтэй / Current гэж үнэмлэх, зэрэглэл, эсхүл эрүүл мэндийн гэрчилгээний хувьд, эрхээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн баримт бичиг эзэмшигч нь туршлага хадгалах болон эрүүл мэндийн бүх шаардлагыг хангасан байх ба тухайн баримт бичиг нь хүчинтэй байхыг;

Хүчинтэй / Valid гэж:

- (a) үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хувьд, тухайн баримт бичгийг ИНД-ийн дагуу олгосон ба түүний хугацаа дуусаагүй, түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй байхыг;
- (b) эрүүл мэндийн гэрчилгээний хувьд, тухайн эрүүл мэндийн гэрчилгээг ИНД-67-гийн дагуу олгосон ба түүний хугацаа дуусаагүй, түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй байхыг;

Хэв журам зөрчсөн зорчигч / Unguly passenger гэж агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулсан, эсхүл учруулахаар завдсан, эсхүл агаарын хөлөг дотор санаатайгаар нийтийн хэв журам зөрчсөн этгээдийг;

Хэлипорт / Heliport гэж нисдэг тэрэгний буулт, хөөрөлт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн ашиглахад зориулан газар, эсхүл усан гадаргуу дээр тогтоосон, эсхүл байгууламж дээр байгуулсан талбайг;

Хэрэг явдал / Occurrence гэж осол, эсхүл зөрчлийг;

Хэрэглэлийн нислэг / Instrument flight гэж гадны хяналтын цэгийг ашиглалгүй, зөвхөн хэрэглэлээр баримжаалан агаарын хөлгөөр үйлдэх нислэгийг;

Хэрэглэлийн нислэгийн журам / Instrument flight procedure гэж IFR-ийн дагуу нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулан дараах мэдээллээс бүрдсэн, эсхүл тэдгээртэй холбоотой ил харааны, эсхүл хэрэглэлийн нислэгийн журмыг:

- (1) IFR-аар нисэн ирэх болон нисэн гарах замыг багтаасан IFR нислэгийн зам;
- (2) IFR-ийн өндрийн-түвшин;
- (3) хэрэглэлээр нисэн ирэх стандарт;
- (4) хэрэглэлээр нисэн гарах стандарт;
- (5) дараах цэгүүдийг багтаасан тодорхой цэг:
 - навигацийн туслах төхөөрөмжийг шилжүүлэх цэг;
 - IFR-ийн мэдээлэх цэг;
 - IFR-ийн тодорхой цэг;
 - тогтоосон цэг;
- (6) IFR-ийн хүлээх тойрог;
- (7) ойртолтоос 2-т гарах холбогдох журам болон цаг уурын минима-г багтаасан хэрэглэлээр ойртолт үйлдэх журам;
- (8) хэрэглэлээр нисэн гарах журам болон холбогдох цаг уурын минима;

Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээ / Instrument flight procedure service гэж хэрэглэлийн нислэгийн журмыг зохиох, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх, эсхүл хадгалах үйлчилгээг;

Хэрэглэлийн нислэгийн цаг / Instrument flight time гадны хяналтын цэгийг ашиглалгүй, зөвхөн хэрэглэлээр баримжаалан агаарын хөлгөөр үйлдэх нислэгийн хугацааг;

Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл (IMC) / Instrument meteorological conditions (IMC) гэж VMC-д заасан минима-гаас бага, хараагаар, үүлнээс барих зайгаар болон үүлний суурийн өндрөөр илэрхийлдэг цаг уурын нөхцөлийг;

Хэрэглэлийн ХБЗ / Instrument runway гэж хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг ашиглаж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулсан дараах аль нэг төрлийн ХБЗ-ыг:

- (1) *Нарийвчлалтай бус ойртолтын ХБЗ*: хараа 1000 м-ээс багагүй байхад хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагааны төрөл-А-гийн дараа буултын үйл ажиллагаанд зориулан ил харааны болон ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээгээр тоногдсон ХБЗ;
- (2) *CAT I нарийвчлалтай ойртолтын ХБЗ*: шийдвэр гаргах өндөр (DH) 60 м-ээс (200 ft) доошгүй ба хараа 800 м-ээс багагүй, эсхүл ХБЗ-ны ил харааны зай 550 м-ээс багагүй байх аль ч нөхцөлд хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагааны төрөл-В-гийн дараа буултын үйл ажиллагаанд зориулан ил харааны болон ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээгээр тоногдсон ХБЗ;
- (3) *CAT II нарийвчлалтай ойртолтын ХБЗ*: шийдвэр гаргах өндөр (DH) нь 60 м-ээс (200 ft) доош, гэхдээ 30 м-ээс (100 ft) доошгүй ба ХБЗ-ны ил харааны зай 300 м-ээс багагүй байхад хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагааны төрөл-В-гийн дараа буултын үйл ажиллагаанд зориулан ил харааны болон ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээгээр тоногдсон ХБЗ;

- (4) *CAT III нарийвчлалтай ойртолтын ХБЗ*: дараах нөхцөлд, ХБЗ-ны гадаргуу хүртэл хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагааны төрөл-В дараа буултын үйл ажиллагаанд зориулан ил харааны болон ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээгээр тоногдсон ХБЗ:
- (i) CAT IIIA: шийдвэр гаргах өндөр (DH) нь 30 м-ээс (100 ft) доош, эсхүл шийдвэр гаргах өндөр (DH) заагаагүй ба ХБЗ-ны ил харааны зай 175 м-ээс багагүй байх үйл ажиллагаанд зориулсан;
 - (ii) CAT IIIB: шийдвэр гаргах өндөр (DH) нь 15 м-ээс (50 ft) доош, эсхүл шийдвэр гаргах өндөр (DH) заагаагүй ба ХБЗ-ны ил харааны зай 175 м-ээс бага, гэхдээ 50 м-ээс багагүй байх үйл ажиллагаанд зориулсан;
 - (iii) CAT IIIC: шийдвэр гаргах өндөр (DH) болон ХБЗ-ны ил харааны зайн хязгаарлалт заагаагүй үйл ажиллагаанд зориулсан;

Хэрэглэлийн цаг / Instrument time нь тухайн нисгэгчийн хэрэглэлийн нислэгийн цаг болон зөвшөөрөгдсөн механик хэрэгслээр дуураймал хэрэглэлийн нислэгийн дадлагыг хийсэн цагийг багтаана;

Хэрэглэлээр ойртолт үйлдэх журам / Instrument approach procedure гэж ойртолтын эхлэлийн цэгээс, эсхүл хамааралтай тохиолдолд, тогтоосон нисэн ирэх замын эхлэлээс буулт үйлдэж чадах цэг хүртэл, түүний дараа хэрэв буулт үйлдэж чадаагүй бол хүлээх, эсхүл нислэгийн замын дагуу саадыг давах зайн шалгуурыг хангасан байршил хүртэл саадаас хамгаалдаг нислэгийн хэрэглэлээр баримжаалан үйлдэхээр урьдчилан тогтоосон бүлэг маневрыг;

2D хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагаа / 2D instrument approach operation гэж зөвхөн хэвтээ тэнхлэгийн нислэгийн чиглүүлэгч ашиглан үйлдэх ойртолт болон буултыг;

3D хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагаа / 3D instrument approach operation гэж босоо болон хэвтээ 2 тэнхлэгийн нислэгийн чиглүүлэгч ашиглан үйлдэх ойртолт болон буултыг;

Хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагааны төрөл-А / Instrument approach operation type A гэж өндөр алдах минимум өндөр (MDH), эсхүл шийдвэр гаргах өндөр (DH) нь 75 м (250 ft), эсхүл түүнээс дээш байхад хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг;

Хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагааны төрөл-В / Instrument approach operation type B гэж шийдвэр гаргах өндөр (DH) нь 75 м-ээс (250 ft) доош байхад хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг;

Хэрэгсэл / Appliance гэж нислэгт агаарын хөлгийг ажиллуулах, эсхүл удирдахад ашигладаг, эсхүл ашиглахаар зорьж байгаа, эсхүл тухайн агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн, хүчилсэн бүтэц, хөдөлгүүр, эсхүл сэнснээс бусад хэрэглэл, механизм, төхөөрөмж, эд анги, эсхүл туслах тоноглолыг;

Хэсэгчилсэн үзлэг / Progressive inspection гэж хэд хэдэн жижиг үзлэгт хуваасан, агаарын хөлгийн бүрэн үзлэгийг;

Хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллага / Microlight organisation гэж хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой тухайн эрхийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн, ИНД-149-ийн дагуу олгосон Нисэх клубийн гэрчилгээ эзэмшигчийг;

Хэт хөнгөн агаарын хөлөг / Microlight aircraft гэж Даргын хүлээн зөвшөөрөхуйц бага моментын үзүүлэлттэй, хоёроос дээшгүй хүн тээвэрлэхээр зохион бүтээсэн нислэгийн бага үндсэн үзүүлэлттэй агаарын хөлгийг;

Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ / Qualifying aerodrome certificate гэж тогтмол агаарын тээврийн нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг дараах нисэх онгоцонд үйлчлэх аэродромд ИНД-139-ийн дагуу Даргын олгосон гэрчилгээг:

- (1) 9-өөс дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай; эсхүл
- (2) төлбөрт ачаалал нь 3410 кг, эсхүл түүнээс бага, MCTOW нь 5700 кг-аас дээш жинтэй; эсхүл
- (3) SEIFR-ээр зорчигч тээвэрлэх үйл ажиллагаанд ашигладаг.

Хяналттай агаарын зай / Controlled airspace гэж агаарын зайн ангиллын дагуу, IFR болон VFR нислэгт НХУ-ээр хангадаг тогтоосон хэмжээтэй агаарын зайг;

Хяналттай аэродром / Controlled aerodrome гэж аэродромын нислэгийн хөдөлгөөнд НХУ-ын үйлчилгээ үзүүлдэг аэродромыг;

Тайлбар - “хяналттай аэродром” гэсэн ойлголт нь тухайн аэродромын нислэгийн хөдөлгөөнд НХУ-ын үйлчилгээ үзүүлдэг, гэхдээ удирдлагын зоон байгаа гэж ойлгож болохгүй.

Хяналттай нислэг / Controlled flight гэж НХУ-ын зөвшөөрөл шаардлагатай нислэгийг;

Хяналттай нэвтрэх бүс / Access controlled гэж үйл ажиллагаатай холбоотой, зөвшөөрөгдөөгүй этгээд нэвтрэхээс сэргийлж, хамгаалагдсан бүсийг;

Цаасан шувуу / Kite гэж хөдөлгөөнгүй цэгт бэхэлсэн, эсхүл гараар барьж салхины хүчээр хөөрдөг, татах хүчний үүсгүүргүй, нисгэгчгүй агаараас хүнд нисдэг төхөөрөмжийг;

Цаг агаарын үндсэн мэдээлэл / Basic weather report гэж нисэхийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайд ажиглагдсан дараах цаг агаарын бодит нөхцөлийг тодорхойлж байгаа аман мэдээллийг:

- (1) салхины чиглэл ба хүч;
- (2) далайн дундаж түвшний агаарын даралт;
- (3) агаарын хэм;
- (4) цаг агаарын нөхцөл болон үүлшил;

Цаг уурын алба / Meteorological office гэж цаг уурын үйлчилгээгээр хангадаг, эсхүл дэмжлэг үзүүлдэг албыг, эсхүл цаг уурын мэдээг нэгтгэдэг, боловсруулдаг, эсхүл хэрэглэгчдэд дамжуулдаг албыг;

Цаг уурын алдаатай мэдээ / Erroneous meteorological information гэж тухайн мэдээний зөвшөөрөгдөхүйц нарийвчлал, эсхүл зөвшөөрөгдөх хэмжээнээс ихээхэн хэмжээгээр хэтэрсэн, эсхүл хэтэрсэн байж болох цаг уурын мэдээг;

Цаг уурын мэдээлэл / Meteorological report гэж нисэхийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор, тодорхой цаг болон байрлалтай холбоотой ажиглагдсан цаг уурын нөхцөлийн мэдэгдлийг;

Цаг уурын мэдээ / Meteorological information гэж нисэхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх цаг уурын мэдээлэл, дүн шинжилгээ, эсхүл урьдчилсан мэдээ болон одоогийн, эсхүл таамаглаж байгаа цаг уурын нөхцөлтэй холбоотой нисэхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бусад мэдэгдлийг;

Цаг уурын үйлчилгээ / Meteorological service гэж нисэхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор цаг уурын мэдээгээр хангадаг дараах үйлчилгээг:

- (1) Уур амьсгалын мэдээний үйлчилгээ: тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайд зориулан уур амьсгалын мэдээ боловсруулах болон хангах үйлчилгээ;
- (2) Урьдчилан мэдээлэх үйлчилгээ: тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайн хэсэгт зориулан цаг уурын урьдчилсан мэдээгээр хангах үйлчилгээ;
- (3) Мэдээлэл түгээх үйлчилгээ: цаг уурын мэдээг цуглуулах болон түгээх үйлчилгээ;
- (4) Цаг уурын зааварчилгаа өгөх үйлчилгээ: цаг уурын одоогийн болон таамаглаж байгаа нөхцөлийн талаарх цаг уурын мэдээг бичгээр болон амаар тайлбарлан мэдээлэх үйлчилгээ;
- (5) Цаг уурын мэдээллийн үйлчилгээ: цаг уурын тогтмол мэдээллээр хангах үйлчилгээ;
- (6) Цаг уурын ажиглалтын үйлчилгээ: тодорхой газар нутаг дахь агаарын хөлгийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын нөхцөлд ажиглалт хийх үйлчилгээ;

Цагийн хязгаарлалттай систем / Time limited system гэж чадвар нь тогтоосон цагаар хязгаарлагддаг бөгөөд тухайн нисэх онгоцны боломжит нислэгийн цагийн үргэлжлэх хугацаанд нөлөөлдөг нисэх онгоцны аливаа системийг;

Цуцлагдсан буулт / Balked landing гэж саадыг давах өндрийн-түвшин / өндрөөс (OCA/H) дооших аливаа цэгээс гэнэтийн нөхцөлөөс шалтгаалан цуцалсан буултын маневрыг;

Цэргийн сургуулилтын нислэгийн үйл ажиллагаа / Simulated military operation гэж бай чирэх нислэг, эсхүл араас чирсэн байг хөөх, эсхүл 1, эсхүл түүнээс олон агаарын хөлгөөр цэргийн нислэгийн үүргийн маневрыг гүйцэтгэж байгаа 1, эсхүл түүнээс олон агаарын хөлөг оролцсон чөлөөт нисэхийн үйл ажиллагааг;

Чадвараа алдсан / Impaired гэж ядаргаа, гэмтэл, эрүүл мэндийн нөхцөл, эсхүл тухайн этгээд өөрийн, эсхүл бусдын аюулгүй байдалд эрсдэл учруулж болох согтууруулах ундаа, эсхүл бусад эм бэлдмэлийн хэрэглээний нөлөөлөлд орсныг;

Чөлөөт бөмбөлөг / Free Balloon гэж 1.5 м³-ээс дээш хийн багтаамжтай, чөлөөт нислэгт татах хүчний үүсгүүргүй, нисгэгчгүй аэростатыг;

Чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар / Free flight model aircraft гэж хөөргөснөөс хойш удирдах боломжгүй нислэгийн замтай, далавчны максимум ачаалал нь 62 гр/дм²-аас (20 oz/ft²) ихгүй агаарын хөлгийн загварыг;

Чөлөөт нисэхийн аэробатик нислэгийн үйл ажиллагаа / Adventure aviation aerobatic operation гэж аэробатик нислэг гүйцэтгэж байгаа чөлөөт нисэхийн үйл ажиллагааг;

Чөлөөт нисэхийн жагсаалын нислэгийн үйл ажиллагаа / Adventure aviation formation flight operation гэж жагсаалын нислэг гүйцэтгэж байгаа чөлөөт нисэхийн үйл ажиллагааг;

Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа / Adventure aviation operation гэж нислэгт, эсхүл агаараас гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцож байгаа зорчигчид танин мэдэхүйн туршлага олгох зорилготой хөлс, эсхүл шан урамшуулалтай агаараар зорчигч тээвэрлэх дараах үйл ажиллагааг:

- (1) стандарт категорийн НТЧ-ын гэрчилгээ олгосон нисэх онгоц, эсхүл нисдэг тэргээр А-аас А цэг рүү жагсаалын нислэг, аэробатикийн маневр болон огцом өндөр авах, огцом өндөр алдах, огцом эргэлт хийх зэрэг ижил төрлийн стандарт бус нислэгийн маневр хийх;
- (2) тохирох тусгай категорийн анхдагч, тусгай категорийн спортын хөнгөн агаарын хөлгийн, эсхүл тусгай категорийн хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээ олгосон агаарын хөлгөөр А-аас А цэг рүү (үүнд газар уснаа явагч агаарын хөлгийн усан дээрх завсрын буулт багтана) жагсаалын нислэг, аэробатикийн маневр болон огцом өндөр авах, огцом өндөр алдах, огцом эргэлт хийх зэрэг ижил төрлийн стандарт бус нислэгийн маневр хийх;
- (3) А-аас А цэг рүү Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн нислэг;
- (4) халуун агаарын бөмбөлгийн нислэг;
- (5) глайдерын нислэг;
- (6) Хууль болон ИНД-119-ийн дагуу Даргын олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэдэггүй шүхэр хаях агаарын хөлгийн үйл ажиллагаа;
- (7) тандем-шүхрээр буух үйл ажиллагаа;
- (8) тандем-ханг-глайдер, эсхүл параглайдерын нислэг;

Чухал эд анги / Priority part гэж татгалзал нь нислэгийг аюултай нөхцөлд хүргэх шалтгаан болж болох агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, эсхүл сэнсний маягийн гэрчилгээтэй бүтээгдэхүүний эд анги, эсхүл иж бүрдлийг;

Шаардлагатай үзлэг шалгалт / Required inspection гэж ИНД, НТЧ-ын удирдамж, эсхүл батлагдсан Техник үйлчилгээний заавар, хөтөлбөр, эсхүл хуваарьт хийхийг шаарддаг үзлэг шалгалтыг;

Шалгагч-нисгэгч / Flight examiner гэж ИНД-61-ийн дагуу олгосон шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг, эсхүл тусгай нислэгийн шалгалт зохион байгуулахыг Дарга зөвшөөрсөн этгээдийг;

Шалгах нислэг / Flight test (Flight evaluation) гэж агаарын хөлгийн хурдны бүх хязгаарын хүрээнд, хэвийн үйл ажиллагааны үед гүйцэтгэхээр зорьсон бүх маневрыг гүйцэтгэн, агаарын хөлгийн НТЧ болон нислэгт удирдагдах чадварыг шалгах нэг, эсхүл дараалсан нислэгийг; мөн “шалгалтын нислэг”-ийг ижил утгаар ойлгоно;

Шигүү суурьшлын бүс / Congested area гэж хот, сум, эсхүл суурингийн хувьд, орон сууц, үйлдвэрлэл, худалдаа, эсхүл амралт зугаалгын зорилгоор ашигладаг талбайг;

Шийдвэр гаргах өндөр (DH) / Decision height гэж хэрэв ойртолтыг үргэлжлүүлэхэд шаардлагатай тухайн ил харааны баримжаат цэгийг тогтоож чадаагүй бол, нарийвчлалтай ойртолтын үед ойртолтоос 2-т гарах ёстой, ХБЗ-ны босготой харьцуулан тогтоосон өндрийг;

Шийдвэр гаргах өндрийн-түвшин (DA) / Decision altitude гэж хэрэв ойртолтыг үргэлжлүүлэхэд шаардлагатай тухайн ил харааны баримжаат цэгийг тогтоож чадаагүй бол, нарийвчлалтай ойртолтын үед ойртолтоос 2-т гарах ёстой, далайн дундаж түвшинтэй харьцуулан тогтоосон өндрийн-түвшнийг;

Шилжилтийн зам / Translation circuit гэж нисдэг тэрэгний хувьд урагш давших нислэгт шилжих замыг;

Шилжих давхарга / Transition layer гэж шилжих өндрийн-түвшин (ТА) болон шилжих түвшний (ТЛ) хоорондох агаарын зайг;

Шилжих өндрийн-түвшин (ТА) / Transition altitude гэж тухайн цэг, эсхүл түүнээс доогуур нисэж байгаа агаарын хөлгийн босоо байршлыг өндрийн-түвшнээр илэрхийлэн удирддаг өндрийн-түвшнийг (алтиметр QNH);

Шилжих сургалтын зааварчилгаа / Conversion instruction гэж маягийн зэрэглэл шаардлагатай агаарын хөлгийн үйл ажиллагаатай танилцах зорилгоор авч байгаа зааварчилгааг; гэхдээ сурагч-нисгэгчид өгөх зааварчилгаа, эсхүл хяналт, мөн хөдөлгөөнгүй-далавчит агаарын хөлгөөс ротор-далавчит агаарын хөлөг рүү, эсхүл ротор-далавчит агаарын хөлгөөс хөдөлгөөнгүй-далавчит агаарын хөлөг рүү шилжихтэй холбоотой танилцах зааварчилгаа багтахгүй;

Шилжих түвшин (ТЛ) / Transition level гэж шилжих өндрийн-түвшнээс (ТА) дээш, ашиглах боломжтой хамгийн доод нислэгийн түвшнийг (FL) (алтиметр 1013 hPa);

Шилжүүлэх мэдэгдэл / Release note гэж үйлдвэрлэл, түгээлт болон техник үйлчилгээний үе шатанд тухайн бүтээгдэхүүнийг эргэн тогтоох боломжийг хангаснаар, нийлүүлж байгаа тухайн нисэхийн бүтээгдэхүүн нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц НТЧ-ын стандартад тохирч байгааг нотлох баримт бичгийг;

Шилжүүлэх тээш / Transfer baggage гэж нэг агаарын хөлгөөс нөгөө агаарын хөлөг рүү шууд шилжүүлсэн тээшийг;

Шинээр их засвар хийсэн / Newly overhauled гэж их засвар хийснээс хойш ажиллагааны тест хийснээс бусдаар ажиллаагүй, эсхүл ашиглалтад гаргаагүй бүтээгдэхүүнийг;

Шөнө / Night гэж үдшийн бүрий дуусахаас үүрийн гэгээ эхлэх хүртэлх хугацааг:

- (1) үдшийн бүрий нь жаргаж байгаа нарны голч тэнгэрийн хаяанаас 6° доор буюу нар жаргаснаас хойш 30 минутын дараа дуусна.
- (2) үүрийн гэгээ нь ургаж байгаа нарны голч тэнгэрийн хаяанаас 6° доор буюу нар мандахаас 30 минутын өмнө эхэлнэ.

Шувуутай холбоотой зөрчил / Bird incident гэж:

- (1) агаарын хөлөг 1, эсхүл түүнээс олон шувуутай мөргөлдсөн; эсхүл
- (2) 1, эсхүл түүнээс олон шувуу агаарын хөлөгт хэт ойртсоны улмаас нисгэгчид түгшүүр төрүүлэх шалтгаан болсон зөрчлийг;

Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ / Airline air operator certificate гэж тухайн гэрчилгээ эзэмшигчид Дарга дараах арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх эрх олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг:

- (1) ИНД-121-ийн дагуу, шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачаалал нь 3410 кг-аас дээш жинтэй нисэх онгоц ашиглан гүйцэтгэдэг үйл ажиллагаа; эсхүл
- (2) ИНД-125-ын дагуу, шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 10 - 30 зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачаалал нь 3410 кг, эсхүл түүнээс бага, MCTOW нь 5700 кг-аас дээш жинтэй нисэх онгоц ашиглан гүйцэтгэдэг үйл ажиллагаа; эсхүл
- (3) ИНД-125-ын дагуу гүйцэтгэх SEIFR-зорчигч тээврийн үйл ажиллагаа; эсхүл
- (4) ИНД-135-ын дагуу, шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 9, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай, MCTOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг ашиглан гүйцэтгэдэг, SEIFR-зорчигч тээврийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа;

Шугамын-үйл ажиллагааны нислэгийн цаг / Line-operating flight time гэж ИНД-121 болон ИНД-125-ын хувьд, тухайн дүрэмд хамаарах арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн нислэгийн цагийг;

Шууд хяналт / Direct supervision гэж НХҮ-ний ажилтны үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхийн хувьд, тухайн үнэмлэх эзэмшигч нь нөхцөл байдалд аль болох ойроос хяналт тавихыг, хэрэв эзэмшигч нь өөрөө ажил үүргээ гүйцэтгэж байгаа бол аль ч үед алдааг засаж залруулах, эсхүл хяналтыг өөртөө авахад бэлэн байхыг;

Шуудан / Mail гэж шуудан зөөгч, шуудангийн оператор, эсхүл шуудангийн бусад байгууллага, эсхүл дипломат байгууллагаар дамжин хүргэгдэх захидал, боодол, илгээмж, ил захидал, эсхүл бусад эд зүйлийг;

Шуудангийн эд зүйл / Postal article гэж захидал, илгээмж, эсхүл дараах эд зүйлийг багтаасан, шуудангаар илгээсэн болон хүргэгдээгүй бусад эд зүйлийг:

- (1) хүргэсэн боловч, хүлээн авагчийн гарт очоогүй эд зүйл;
- (2) захидал, илгээмж, эсхүл эд зүйлийн агууламж;

Шүхрийн байгууллага / Parachute organisation гэж шүхрийн үйл ажиллагаатай холбоотой тухайн эрхийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн, ИНД-149-ийн дагуу олгосон нисэх клубийн гэрчилгээ эзэмшигчийг;

Шүхрийн иж бүрдэл / Parachute assembly гэж аливаа этгээд ашиглахад зориулсан шүхэр болон түүний холбогдох холбоос, сав баглааны систем болон бусад бүрдэл хэсгийн эд ангийг;

Шүхрээр буух талбай / Parachute landing area гэж дээр нь шүхрийн буулт үйлдэхэд зориулсан талбайг;

Шүхэр / Parachute гэж өргөх хүч / эсэргүүцэл, эсхүл уян эсэргүүцэлтэй гадаргуугаас бүрдсэн, түүнээс ачааг утсан холбоосоор дүүжилсэн, эвхсэн байдлаас удирдан задлах боломжтой, моторгүй ажилладаг төхөөрөмжийг;

Энгийн нислэг / Normal flight гэж өндөр эрсдэлтэй нислэгээс бусад нислэгийг;

Эрсдэлтэй эд анги / Critical part гэж солих хугацаа, үзлэг шалгалтын үечлэл, эсхүл холбогдох журмыг үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний зааврын “НТЧ-ын Хязгаарлалтын хэсэг”, эсхүл НТЧ-ын хадгалалтын зааварчилгаанд заасан агаарын хөлгийн эд ангийг;

Эрүүл мэндийн заавар / Medical manual гэж Даргын гаргасан, эрүүл мэндийн ерөнхий чиглэлийг агуулсан зааврыг;

Эрүүл мэндийн нөхцөлд / Medical condition:

- (1) дараах нөхцөлийн их, багаас үл хамааран:
 - (i) өвчлөл, эсхүл гэмтэл;
 - (ii) бие махбодын гажиг, согог, эсхүл чадвар алдалт;
 - (iii) сэтгэцийн гажиг, согог, эсхүл чадвар алдалт;
 - (iv) энэ хэсгийн (i), (ii), эсхүл (iii)-д заасан бүх төрлийн өвчлөл, гэмтэл, гажиг, согог, эсхүл чадвараа алдсанаас үүдэлтэй үр дагавар;
- (2) аливаа сэтгэцийн байдал, эсхүл зан төлөв, эсхүл танин мэдэхүйн эмгэг;
- (3) эмийн бодист донтох, эсхүл түүнээс хамааралтай болох;
- (4) эмэгтэйчүүдийн хувьд жирэмслэлт, жирэмслэлтээс, эсхүл жирэмслэлтийг тасалснаас үүдэлтэй бие физиологийн болон сэтгэхүйн өөрчлөлт багтана;

Эрүүл мэндийн тодорхойлолт / Medical statement гэж сонирхогч нисгэгч, хэт хөнгөн агаарын хөлөг, параглайдер болон ханг-глайдерын нисгэгчийн эрүүл мэндийг тодорхойлсон баримт бичгийг;

Эрүүл мэндийн үнэлгээний тайлан / Medical assessment report гэж ИНД-67.59-ийн дагуу Даргын гаргасан тайланг;

Эрүүл мэндийн шалгагч / Medical examiner гэж эрүүл мэндийн шаардлагыг нь заасан үнэмлэх, эсхүл зэрэглэл авах хүсэлт гаргагчийн эрүүл мэндийн байдалд шалгалт хийхээр Үнэмлэх олгох эрх бүхий байгууллагын томилсон, нисэхийн анагаах ухааны сургалтад хамрагдсан ба нисэхийн салбарт ажилласан практик дадлага туршлага, мэдлэгтэй эмчийг;

Эрэг / Shore гэж устай залгаа, ус дээд түвшинд байхад түүнээс дээш байх газрын талбайг; хэсэгчлэн усанд автдаг газар үүнд орохгүй;

ЭХАТ мэдээлэл зохицуулалтын төв / SARICC (Search and rescue information coordination centre) гэж агаарын хөлгийн онцгой нөхцөлийн талаарх мэдээллийг хүлээн авдаг НХҮБ-ын нэгжийг;

UN дугаар / UN number гэж бодис, эсхүл тодорхой бүлгийн бодисыг таньж тогтоох зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюултай бараа Тээвэрлэлтийн Экспертийн хорооноос тогтоосон 4 оронтой тоон дугаар;

UNICOM үйлчилгээ / UNICOM Service гэж нисэхийн үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор орон нутгийн аэродромыг мэдээллээр хангах, нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний газрын радио холбооны үйлчилгээг; UNICOM нь НХҮ биш.

Яаралтай НТЧ-ын удирдамж / Emergency AD гэж Хуулийн дагуу Даргын гаргасан НТЧ-ын удирдамжийг;

Явгалалт / Taxi гэж агаарын хөлгийн хувьд, хөөрөлт, буултаас бусад аэродром, эсхүл усан гадаргуу дээгүүрх шилжих хөдөлгөөнийг, нисдэг тэрэгний хувьд, аэродромын гадаргуу дээгүүр газрын нөлөөлөл үйлчлэх өндөрт, агаараар шилжих нислэгийг;

Явгалах түлш / Taxi fuel гэж хөдөлгүүр асаахаас, хөөрөлт үйлдэхээр гүйж эхлэх хүртэл болон буултын гүйлт хийж дууссаны дараа ХБЗ-аас эргэн гарахаас эхлэн хөдөлгүүр унтраах хүртэл тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаанд шаардлагатай түлшийг;

1.3. Товчлол

Хуулийн дагуу боловсруулсан ИНД-д хэрэглэсэн товчлолыг дараах утгаар ойлгоно:

AAD (automatic activation device) - АЗТ (автоматаар задлагч төхөөрөмж)

AC (Advisory circular) - ЗЦ (Зөвлөмжийн цуврал)

ACAS (Airborne collision avoidance system) - ACAS (Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем)

ACC (Area control centre) - Бүсийн удирдлагын төв

AD (Airworthiness directive) - AD (Нислэгт тэнцэх чадварын удирдамж)

ADF (Automatic direction-finder) - ADF (Автоматаар чиглэл ологч компас)

ADS-B (automatic dependent surveillance broadcast) - ADS-B (автомат хамааралтай ажиглалт - радио нэвтрүүлэг)

ADS-C (automatic dependent surveillance - contract) - ADS-C (автомат хамааралтай ажиглалт - гэрээ)

AEDRS (Automatic engine data recording system) - AEDRS (Хөдөлгүүрийн өгөгдлийг автоматаар бичих систем)

AELS (Aircraft Emergency Location System) - AELS (Агаарын хөлгийн ослын байрлал тогтоох систем)

Aeromedical significance - НЭМОШ (Нисэхийн эрүүл мэндийн онцлох шаардлага)

Aeronautical information service organisation - НМҮБ (Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага)

Aeronautical telecommunication service organisation - АНТҮБ (Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллага)

AFRU (Aerodrome Frequency Response Unit) - AFRU (Аэродромын давтамжийг хариулах нэгж)

AFS (Aeronautical fixed service) - AFS (Нисэхийн суурин холбооны үйлчилгээ)

AFTN (Aeronautical fixed telecommunication network) - AFTN (Нисэхийн суурин цахилгаан холбооны сүлжээ)

AGL (Above ground level) - AGL (Газрын түвшнээс дээш)

Agricultural - ХАА (Хөдөө аж ахуй)

AIC (Aeronautical Information Circular) - AIC (Нисэхийн мэдээллийн цуврал)

AIP (Aeronautical Information Publication) - AIP (Нисэхийн мэдээллийн эмхэтгэл)

AIP Mongolia (Aeronautical Information Publication of Mongolia) - Монгол Улсын AIP (Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл)

Air traffic service organisation - НХҮБ (Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага)

AIRAC (Aeronautical Information Regulation and Control) - AIRAC (Нисэхийн мэдээллийн зохицуулалт ба хяналт)

Airworthiness - НТЧ (Нислэгт тэнцэх чадвар)

AIS (Aeronautical Information Service) - НМУ (Нисэхийн мэдээллийн үйлчилгээ)

AMC (Accredited medical conclusion) - Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт

AMEL (Aircraft maintenance engineer licence) - AMEL (Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн үнэмлэх)

AMO (Aircraft maintenance organisation) - АХТҮБ (Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага)

AMSL (Above mean sea level) - AMSL (Далайн дундаж түвшнээс дээш)

ANR (Air Navigation Register) - ANR (Агаарын Навигацийн Бүртгэл)

AOC (Air operator certificate) - АТ-ийн гэрчилгээ (Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ)

AQP (Advanced qualification program) - Мэргэшил дээшлүүлэх хөтөлбөр

ARC (Aerodrome reference code) - Аэродромын хяналтын код

ARFL (Aeroplane reference field length) - ARFL (Нисэх онгоцны зурвасны хяналтын урт)

ASDA (Accelerate-stop distance available) - ASDA (Хөөрөлтийн гүйлтийг зогсоох боломжит зай)

ASHTAM - ASHTAM (Галт уулын үнсний NOTAM)

ATC (Air traffic control) - НХУ (Нислэгийн хөдөлгөөний удирдлага)

ATCRBS (Air traffic control radio beacon system) - ATCRBS (НХУ-ын радио дохиологч систем)

ATIS (Automatic terminal information service) - ATIS (Аэродромын автомат мэдээллийн үйлчилгээ)

ATN (aeronautical telecommunication network) - ATN (нисэхийн цахилгаан холбооны сүлжээ)

ATO (approved training organisation) - Зөвшөөрөгдсөн сургалтын байгууллага

ATS (Air traffic services) - НХУ (Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ)

Aviation security service organisation - НАХҮБ (Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага)

- Aviation training organisation - НСБ (Нисэхийн сургалтын байгууллага)
- AWIB (Aerodrome and Weather Information Broadcast) - AWIB (Аэродромын болон цаг агаарын мэдээ дамжуулагч)
- BFR (Biennial flight review) - BFR (Хоёр жилийн нислэгийн дүгнэлт)
- BRNAV (Basic area navigation) - BRNAV (Навигацийн үндсэн бүс)
- BTPD (Body temperature and pressure dry) - BTPD (Биеийн хэм болон хуурай даралт)
- BTPS (Body temperature and pressure standard) - BTPS (Биеийн хэм болон стандарт даралт)
- CAA (the Civil Aviation Authority of Mongolia established by the Act) - ИНЕГ (Хуулийн дагуу байгуулагдсан Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар)
- CAR (Civil Aviation Rules) - ИНД (Иргэний нисэхийн дүрэм)
- CBIP (Certification Board for Inspection Personnel) - CBIP (үзлэг шалгалтын ажилтныг гэрчилгээжүүлэх зөвлөл)
- CDFA (a continuous descent final approach) - CDFA (үргэлжлэн өндөр алдах ойртолтын төгсгөл)
- CMP (Configuration, maintenance and procedures standards document) - CMP (Конфигураци, техник үйлчилгээ болон процедурын стандарт баримт бичиг)
- CRM (Crew resource management) - Багийн нөөцийн удирдлага
- CVR (Cockpit voice recorder) - CVR (Бүхээгийн дуу чимээ бичигч)
- DA (Decision altitude) - DA (Шийдвэр гаргах өндрийн-түвшин)
- dBm (Power expressed in decibels with a reference level of 1milliwatt) - dBm (1 милливатт түвшнийг децибилээр илэрхийлсэн чадал)
- dBW (Power expressed in decibels with a reference level of 1 watt) - dBW (1 ватт түвшнийг децибилээр илэрхийлсэн чадал)
- Design organisation - ЗББ (Зохион бүтээх байгууллага)
- DF (Direction finding) - Радиопеленгатор
- DH (Decision height) - DH (Шийдвэр гаргах өндөр)
- DME (Distance measuring equipment) - DME (Зай хэмжих төхөөрөмж)
- EASA (European Aviation Safety Agency) - EASA (Европын Нисэхийн Аюулгүй Байдлын Агентлаг)
- EDTO (Extended diversion time operation) - EDTO (Даялалтын хугацааг сунгасан нислэгийн үйл ажиллагаа)
- EET (Estimated elapsed time) - EET (Тооцоот өнгөрөлтийн цаг)

-
- ELT (Emergency locator transmitter) - ELT (Ослын байрлал дамжуулагч)
- ELT (AF) (Emergency locator transmitter (automatic fixed) - ELT (AF) (Ослын байрлал дамжуулагч (суурин автомат))
- ELT(S) (Emergency locator transmitter (survival) - ELT(S) (Ослын байрлал дамжуулагч (аврах))
- EPIRB (Emergency position indicating radio beacon) - EPIRB (Ослын байршил заагч радио дохиологч)
- ETA (Estimated time of arrival) - ETA (Тооцоот нисэн ирэх цаг)
- ETOPS (Extended-range twin-engine operations) - ETOPS (Хоёр-хөдөлгүүртэй агаарын хөлгийн алсын зайн нислэгийн үйл ажиллагаа)
- FAA (Federal Aviation Administration) - FAA (Холбооны нисэхийн удирдах газар)
- FAF (final approach fix) - FAF (ойртолтын төгсгөлийн цэг)
- FAP (final approach point) - FAP (ойртолтын төгсгөлийн цэг)
- FAR (Federal Aviation Regulations) - FAR (Холбооны Нисэхийн Дүрэм)
- FDPS (Flight data processing system) - FDPS (Нислэгийн өгөгдөл боловсруулах систем)
- FDR (Flight data recorder) - FDR (Нислэгийн өгөгдөл бичигч)
- FIC (Flight information centre) - Нислэгийн мэдээллийн төв
- FIR (Flight information region) - FIR (Нислэгийн мэдээллийн бүс)
- FIS (Flight information service) - Нислэгийн мэдээллийн үйлчилгээ
- FL (Flight level) - FL (Нислэгийн түвшин)
- FMS (Flight management system) - FMS (нислэгийн удирдлагын систем)
- GAA (General aviation area) - Ерөнхий зориулалтын нисэхийн бүс
- GLONASS (Russian segment of GNSS) - GLONASS (Глобал навигацийн хиймэл дагуулын системийн Оросын хэсэг)
- GNSS (Global navigation satellite system) - GNSS (Глобал навигацийн хиймэл дагуулын систем)
- GPS (Global positioning system) - GPS (Глобал байршил тогтоох систем)
- GPWS (Ground proximity warning system) - GPWS (Газарт ойртсоныг анхааруулах систем)
- HF (High frequency) - HF (Өндөр давтамж)

-
- HIGE (hover in ground effect) - HIGE (Газрын нөлөөтэй агаарт тогтох)
- HOGE (hover out of ground effect) - HOGE (Газрын нөлөөгүй агаарт тогтох)
- IAP (Instrument Approach Procedure) - Хэрэглэлээр ойртолт үйлдэх журам
- ICAO (International Civil Aviation Organisation) - ICAO (Олон улсын иргэний нисэхийн байгууллага)
- ICAO SARP (ICAO Standard and recommended practice) - ICAO SARP (ICAO-гийн стандарт, зөвлөмж)
- IFR (Instrument flight rule) - IFR (Хэрэглэлийн нислэгийн дүрэм)
- IFSD (In-flight shutdown) - IFSD (Нислэгт хөдөлгүүр унтрах)
- ILS (Instrument landing system) - ILS (Хэрэглэлээр буулт үйлдэх систем)
- IMC (Instrument meteorological conditions) - IMC (Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл)
- INCERFA (uncertainty phase) - INCERFA (Тодорхой бус үе шат)
- Instrument flight procedure service organisation - ХНЖҮБ (Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллага)
- ISA (International standard atmosphere) - Олон улсын стандарт атмосфер
- LAME (licensed aircraft maintenance engineer) - LAME (Агаарын хөлгийн техник үйлчилгээний үнэмлэхтэй инженер)
- LDA (landing distance available) - LDA (Буултын боломжит зай)
- LOC (localizer) - Локалайзер
- LRNS (long range navigation system) - LRNS (Алсын зайн навигацийн систем)
- LSA (Light Sport Aircraft) - Спортын хөнгөн агаарын хөлөг
- Maintenance organisation - ТҮБ (Техник үйлчилгээний байгууллага)
- Maintenance training organisation - ТҮСБ (Техник үйлчилгээний сургалтын байгууллага)
- MCTOW (Maximum certificated take-off weight) - MCTOW (Гэрчилгээжсэн максимум хөөрөлтийн жин)
- MDA (Minimum descent altitude) - MDA (Өндөр алдах минимум өндрийн-түвшин)
- MDH (Minimum descent height) - MDH (Өндөр алдах минимум өндөр)
- Medical examiner - ЭМШ (Эрүүл мэндийн шалгагч)
- ME1 (Medical examiner who holds a Medical Examiner 1 Certificate) - ЭМШ-1 (Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ-1 эзэмшигч)
- ME2 (Medical examiner who holds a Medical Examiner 2 Certificate) - ЭМШ-2 (Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ-2 эзэмшигч)
-

- MEL (Minimum equipment list) - MEL (минимум төхөөрөмжийн жагсаалт)
- METAR (Aerodrome routine meteorological report) - METAR (Аэродромын цаг уурын бодит мэдээлэл)
- Meteorological service organisation - НЦҮҮБ (Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага)
- MLS (Microwave landing system) - MLS (Буулт үйлдэх хэт богино долгионы систем)
- M MEL (Master minimum equipment list) - M MEL (мастер минимум төхөөрөмжийн жагсаалт)
- MNPS (Minimum navigation performance specifications) - MNPS (Навигацийн минимум үзүүлэлтийн тодорхойлолт)
- M TOPP (Mean Tracheal Oxygen Partial Pressure) - M TOPP (Мөгөөрсөн хоолойн хүчилтөрөгчийн хэсэгчилсэн дундаж даралт)
- MZFW (Maximum zero fuel weight) - MZFW (Түлшгүй максимум жин)
- NANU (Notice Advisory to NAVSTAR User (GPS NOTAM)) - NANU (NAVSTAR хэрэглэгчид хандсан анхааруулах мэдэгдлийг (GPS NOTAM))
- NDB (Non-directional radio beacon) - NDB (Чиглүүлэгч радио дохиологч)
- NDT (Non-destructive testing) - Үл эвдэх сорил
- NM (nautical mile) - NM (далайн миль)
- NOF (International NOTAM office) - Олон улсын NOTAM-ын нэгж
- NPA (non-precision approach) - Нарийвчлалтай бус ойртолт
- NPRM (Notice of proposed rule making) - Дүрмийн боловсруулалтад санал өгөх мэдэгдэл
- NSP (National security program) - Үндэсний аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр
- PAR (Precision approach radar) - PAR (Нарийвчлалтай ойртолтын радар)
- PBN (Performance-Based Navigation) - PBN (Үзүүлэлтэд суурилсан навигаци)
- PF (pilot flying) - Идэвхтэй нисгэгч
- PIB (Pre-flight Information Bulletin) - PIB (Нислэгийн өмнөх мэдээллийн товхимол)
- PIC (pilot-in-command) - Хөлгийн дарга
- PIC/US (pilot-in-command under supervision) - Шалгуулж байгаа хөлгийн дарга
- PLA (Parachute landing area) - Шүхрээр буух талбай
- PLB (Personal locator beacon) - PLB (Хувийн байрлал дохиологч)
- PMA (Parts Manufacturing Approval) - PMA (Эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл)

- PNF (pilot non-flying) - Ажиглагч нисгэгч
- PSR (Primary surveillance radar) - PSR (Ажиглалтын үндсэн радар)
- QFE (Atmospheric pressure at aerodrome level or at runway threshold) - QFE (Аэродромын, эсхүл ХБЗ-ны босгоны түвшин дэх атмосферийн даралт)
- QNH (An altimeter sub-scale setting to obtain elevation when on the ground) - QNH (Газарт тухайн өндөрлөгийг тодорхойлох зорилгоор алтиметрийн даралтын цонхны заалтыг тохируулах)
- RDPS (Radar data processing system) - RDPS (Радарын өгөгдөл боловсруулах систем)
- Regulated air cargo agent - ЗААБ (Зохицуулалттай агаарын ачааны байгууллага)
- RESA (Runway end safety area) - RESA (ХБЗ-ны төгсгөлийн аюулгүйн талбай)
- RF (Radio frequency) - Радио давтамж
- RFDPS (Radar and flight data processing system) - RFDPS (Радар болон нислэгийн өгөгдөл боловсруулах систем)
- RNAV (Area navigation) - RNAV (Бүсийн навигаци)
- RNP (Required navigation performance) - RNP (Навигацийн шаардлагатай үзүүлэлт)
- RPM (Revolutions per minute) - эргэлт/минут (1 минутад эргэх тоо)
- Runway - ХБЗ (Хөөрч, буух зурвас)
- RVR (Runway visual range) - ХБЗ-ны ил харааны зай
- RVSM (Reduced vertical separation minimum) - RVSM (Багасгасан босоо зайчлалын минимум)
- SAR (Search and rescue) - ЭХАТ (Эрэн хайх, авран туслах)
- SARICC (Search and rescue information co-ordination centre) - ЭХАТ мэдээлэл зохицуулалтын төв
- SARTIME (Search and rescue required time) - SARTIME (Эрэн хайх, авран туслах үйлчилгээ шаардлагатай цаг)
- SB (Service bulletin) - SB (сервис бюллетен)
- SEIFR (Single-engine IFR) - SEIFR (Ганц-хөдөлгүүрт IFR)
- SELCAL (Selective calling system) - SELCAL (Сонгож дуудах систем)
- SFAR (Special Federal Aviation Regulations issued by the Federal Aviation Administration) - SFAR (FAA-ийн гаргасан Холбооны Нисэхийн Тусгай дүрэм)
- SMS (Safety management system) - SMS (Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо)

- SSP (State safety program) - SSP (Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөр)
- SSR (Secondary surveillance radar) - SSR (Ажиглалтын хоёрдогч радар)
- STC (Supplemental Type Certificate) - STC (Нэмэлт маягийн гэрчилгээ)
- STPD (Standard temperature and pressure dry) - STPD (Стандарт хэм болон хуурай даралт)
- TALPA (Take-off and Landing Performance Assessment) - TALPA (Хөөрөлт болон буултын үзүүлэлтийн үнэлгээ)
- TAWS (Terrain awareness and warning system) - TAWS (Газрын бартааг мэдэрч, анхааруулах систем)
- TA (Transition altitude) - TA (Шилжих өндрийн-түвшин)
- TBO (Time between overhaul) - Их засвар хоорондын хугацаа
- TCAS (Traffic alert and collision avoidance system) - TCAS (Хөдөлгөөнийг анхааруулах ба мөргөлдөхөөс зайлсхийх систем)
- TCDS (Type Certificate Data Sheet) - TCDS (Маягийн гэрчилгээний өгөгдлийн хуудас)
- TL (Transition level) - TL (Шилжих түвшин)
- TLOF (touchdown and lift-off area located at a heliport) - TLOF (Хэлипортын газардах болон хөөрөх талбай)
- TODA (Take-off distance available) - TODA (Хөөрөлтийн боломжит зай)
- TORA (Take-off run available) - TORA (Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зай)
- TSO (Technical Standard Order) - TSO (Техникийн стандартын ордер)
- UAS (Unmanned aircraft system) - Хүнгүй агаарын хөлгийн систем
- UF (Uplink formats) - UF (Үндсэн сүлжээний формат)
- UHF (Ultra high frequency) - UHF (Ултра өндөр давтамж)
- ULAT (Ulaanbaatar time) - ULAT (Улаанбаатарын цаг)
- UTC (Co-ordinated universal time) - UTC (Олон улсын цаг)
- V_1 (Take-off decision speed) - V_1 (Хөөрөлтийн шийдвэр гаргах хурд)
- V_2 (Take-off Safety speed) - V_2 (Хөөрөлтийн аюулгүй хурд)
- V_{EF} (Calibrated speed at which the critical engine is assumed to fail) - V_{EF} (Эрсдэлтэй хөдөлгүүр татгалзана гэж үзсэн үеийн тохируулагдсан хурд)
- V_s (Stalling speed) - V_s (Хурд нурах хурд)
- VFR (Visual flight rules) - VFR (Ил харааны нислэгийн дүрэм)
- VHF (Very high frequency) - VHF (Хэт өндөр давтамж)

VMC (Visual meteorological conditions) - VMC (Ил харааны нислэгийн цаг уурын нөхцөл)

VOLMET (Meteorological information for aircraft in flight) - VOLMET (Нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт зориулсан цаг уурын мэдээ)

VOR (VHF omnidirectional radio range) - VOR (Бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч)

VSM (Vertical separation minimum) - VSM (Босоо зайчлалын минимум)

VSWR (Voltage standing wave ratio) - VSWR (Долгионы харьцааг вольтоор илэрхийлэх)

VTA (vertebrate toxic agent) - VTA (Мэрэгчийн хор)

--oOo--